

Лиахона



Хойч үеийнхэнд
зориулсан итгэлийн
өв, х. 44

Бидний зорилго: Сайн мэдээг
100 хүнтэй хуваалцах, х. 18

Газар хөдлөлт, гал түймэр,
салхи шуурганаас ч илүү
хүчтэй, х. 21


Анхдагчид: Тэднийг юу
урагшлуулсан бэ? х. 24

“БИД... ДЭЛХИЙ ДАЯАРХ
ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭН-
ТЭН АНХДАГЧДАД ХАН-
ДАН, БУСДЫН ДАГАХ САЙН
МЭДЭЭНИЙ ЗАМЫГ ГАРГА-
СААР БАЙГААД НЬ ТАЛАРХ-
ЛАА ИЛЭРХИЙЛЖ БАЙНА.”

АХЛАГЧ РОНАЛД А.РАСБАНД



“Урагш зүтгэх итгэл,” х. 24-өөс авав.



ОНЦЛОХ ӨГҮҮЛЭЛ

12 Гэгээнтнүүд: Сүмийн түүх— 5-р бүлэг: Ингээд өнгөрдөг байж

Иосеф Мартин Харрисын тусламжтайгаар ялтаснуудыг орчуулж эхэлснийхээ дараа гар бичмэлүүдийг гараасаа холдуулсныхаа үр дагаврыг амсдаг.



ХАВТСАН ДЭЭР

Зураг чимэглэлийг Дэвид Грийн

18 Бид сайн мэдээнээс хуваалцахдаа хэр амжилттай байсан бэ?

Нэвэр Чикунгуво

Бид бусдыг Христэд авчрах зорилгыг итгэлтэйгээр тавих үедээ гайхамигуудаар адислагдах болно.

20 Сүнслэг өдөөлтөд мэдрэг байцгаая

Ахлагч Хорхэ Ф.Зэбаллос

Байнгын чимээ шуугиантай байдаг дэлхийд бид Эцэгийн хүслийг мэдэхийн тулд намуун зөөлөн дуу хоолойг олж сонсох ёстой.

24 Урагш зүтгэх итгэл

Ахлагч Роналд А.Расбанд

Манай анхдагч өвөг дээдэс Сионд цуглахаар зүтгэх явцдаа маш хүнд хэцүү бэрхшээлийг туулсан.

30 Ганцаараа байхдаа итгэлээ хадгалах нь

Раян В.Солцгивэр

Сүмийн барилга, бүр цаашилбал тойрог байдаггүй байсан ч эдгээр гэгээнтэн төрсөн нутагтаа Сүмийг байгуулахын тулд шаргуу хөдөлмөрлөв.

36 Мормоны Ном амьдралыг өөрчилдөг

Хөрвөгчид сайн мэдээг хүлээн зөвшөөрөхөд нь Мормоны Ном хэрхэн тусалсан тухай хуваалцсан нь

БУСАД ӨГҮҮЛЭЛ

4 Итгэлийн хөрөг: Виктор Барбинягра

6 Тохинууллын зарчим: Өрөвч сэтгэлээр бусдад тусламжийн гараа сунга

10 Индэр дээр: Өөрийнхөө хэн болохыг мөн хэн байсныг мэдэх нь Шэри Л.Дью

40 Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой

80 Биднийг дахин уулзах хүртэл: Мормоны Ном элбэг дэлбэгийг авчирдаг Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон



44

44 Орчин үеийн гурван анхдагчийн аялал

Сара Кийнан

Эртний анхдагчдын адил өнөөдөр ч гэсэн Сүмд нэгдэхэд зоригтой байж, золиослол хийхийг шаарддаг.

48 Тусгаарлагдсан мэт санагдаж байна уу? Хурдаа сааруулахыг хичээгээрэй

Шарлотт Ларкэбэл

Завгүй, олон зүйлд сатаарсан амьдрал минь намайг Бурханаас холдуулж байсныг би ойлгосон.



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Сэжүүр: Өвөө чинь ямар ажил хийдэг вэ?



59

50 Хэцүү асуудлыг шийдэхэд тусалж чадах гурван зарчим

Асуух нь гэрчлэлээ хүчирхэгжүүлэх маш сайн арга зам бөгөөд хариулт авахаар Их Эзэнд хандах нь танд туслах боломжийг Сүнсэнд олгодог.

54 Үйлчлэхэд хэцүү цагт

Ли́ка Т.Валдэз

Би хандлагаа өөрчлөх хүртлээ өвөөдөө үйлчлэхдээ дургүй байв.

56 Үг хэлэхэд туслах долоон зүйл

Сара Хэнсон

Сүм дээр үг хэлэхэд хэцүү байж болох юм. Гэхдээ та бэлтгэж, сонирхолтой үг хэлэхийн тулд энэхүү тусламжийг ашиглаж болно.

58 Амьдралын бэлтгэл: Бид ариун сүмд юу хийдэг вэ?

60 Хүндэтгэлийн өдрөөр мэдрэх уйтгар гуниг

Алисса Нийлсэн

Хүндэтгэлийн өдрөөс зайлсхийхийн оронд хүсэн хүлээдэг болж сурсан минь.

62 Зурагт хуудас: Тэмцээний оноолт

63 Сүүлчийн үг: Та ариун сүмд орох зохистой байж чадна

Ахлагч Квинтин Л.Күк



68

64 Изабэллийн аялал

Жэссика Ларсэн

Аялал урт удаан байх болно, гэвч Изабэллийн гэр бүл ариун сүм рүү явах нь үнэ цэнтэй зүйл гэдгийг мэдэж байлаа.

66 Сайн өвөө, эмээ

Жэнна Кофорд

Эндрю сургуулийн Эцэг эхийн өдөрлөгт санаа зовж байв.

68 Эцэст нь мөнхийн гэр бүл болов

Жэйн Макбрайд

Миа найз Зөүгийгнхээ гэрт мэдэрсэн халуун дулаан мэдэрэмжиндээ маш дуртай байв.

70 Гэрлээ гэрэлтүүл: Найз ба номлогч

72 Төлөөлөгчид Христийн талаар гэрчилдэг

Ахлагч Гари И.Стивэнсон

73 Мормоны Номын уншлагын клуб: Хиламан 5:12

74 Бидний хуудас

75 Хуучин Гэрээний баатрын хуудас

76 Судрын түүх: Ханна, Самуел хоёр

Ким Вэбб Рэйд

79 Будах хуудас: Би бусадтай хуваалцаж чадна

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Рассэлл М.Нэлсон, Даллин Х.Өүкс,
Хэнри Б.Айринг

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга: М.Рассэлл Баллард,
Жэффри Р.Холланд, Дийтр Ф.Угдорф, Дэвид А.Бэднар,
Квинтин Л.Кук, Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн,
Роналд А.Расбанд, Гари И.Стивенсон, Дэйл Г.Рэнланд,
Гэррит В.Гонг, Үлиссэс Соарэс

Эрхлэгч: Хюго И.Мартинэз

Туслах редакторууд: Рэндэлл К.Бэннэтт, Кэрл Ф.Макконки
Зөвлөхүүд: Бризэн К.Эштон, Бонни Х.Кордон, Бага Лигранд
Р.Куртис, Эдуард Дюб, Шэрон Юбанк, Доналд Л.Холлструм,
Даглас Д.Холмэс, Эрих В.Көпишкэ

Удирдах захирал: Ричард И.Хийтон

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Адам С.Олсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр

Хэвлэлийн туслах: Фрэнсиска Олсон

Редакцийн баг: Мэрисса Дэниел, Дэвид Диксон, Дэвид
А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фүллэр, Гаррэт
Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Жон Рэйн Жэнсэн, Шарлотт
Ларкэбэл, Майкл Р.Моррис, Эрик Б.Мардок, Салли Жонсон
Одэкэрк, Жошуа Ж.Пэркий, Жан Пинборору, Ричард М.
Ромни, Минди Сэлү, Чакэлл Вордлэй, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:

Ж.Скотт Кнудсэн

Зураглал чимэглэлийн удирдагч: Талл Р.Петрссон

Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрюс, Фэй
П.Андрус, Мэндий Бэнгли, С.Кимбалл Ботт, Томас Чайлд,
Дэвид Грийн, Коллийн Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан
Лофгрэн, Скотт М.Моой, Эмили Чизко Эмингтон, Марк
В.Робисон, Брэд Тизри, К.Никол Вокзорст

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэт Нэбэкэр Аун

Хэвлэлийн захирал: Жэйн Анн Пэтэрс

Хэвлэх баг: Ира Глэнн Адэйр, Жюли Бардэтт, Томас
Ж.Кронин, Брайн В.Гайги, Жинни Ж.Нилсон, Дэрэк
Ричардсон

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жошуа Дэниел, Аммон Харрис

Хэвлэлийн захирал: Стивен Т.Льюис

Хуваарилалт хариуцсан захирал: Трой Р.Бэркир

Нэгдсэн Улс, Канадаас бусад орон дахь захиалга болон
үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон
тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт

liahona.lds.org pyu; шуудангаар Liahona, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар
ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин"
буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,
итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл,
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,
свахили, самоа, себуано, солонгос, тагало, тай, тахити, тонга,
украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват, хятад, хятад
(хялбаршуулсан), чех, швед, эстон, япон хэлээр нийтлэгддэг.
(Хялбаршуулсан) чех, швед, эстон, япон хэлээр нийтлэгддэг.
(Хялд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2018 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Зохиогчийн эрхийн тухай мэдээлэл: Өөрөөр заагаагүй
бол хувь хүмүүс Лиахона сэтгүүлээс арилжааны бус, хувьдаа
(мөн Сүмийн дуудлагат ажилд) ашиглах зорилгоор материал
хувиран авч болно. Энэ эрх ямар ч үед өөрчлөгдөхгүй.
Үзүүлэнгийн материалыг хэрэв зураг чимэглэлийн тухайд
ямар нэг хязгаарлалт тогтоосон бол хуулбарлаж болохгүй.
Зохиогчийн эрхийн талаар асуух зүйл байвал дараах хаягаар
хандана уу. Intellectual Property Office, 50 E. North Temple St.,
FL 13, Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон
шуудангийн: cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар
ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:

July 2018 Vol. 19 No. 4. LIAHONA (USPS 311-480) Mongolian
(ISSN 1525-7584) is published six times a year (January, April,
June, July, October, and December) by The Church of Jesus
Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150. USA subscription price is \$5.00 per year; Canada,
\$6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake
City, Utah. Sixty days' notice required for change of address.
Include address label from a recent issue; old and new address
must be included. Send USA and Canadian subscriptions to Salt
Lake Distribution Center at address below. Subscription help
line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard,
American Express) may be taken by phone. (Canada Poste
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2).

NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes
to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368, USA.

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ИНТЕРНЭТЭЭС ҮЗЭЖ БОЛНО



Liahona.lds.org гэсэн хаягаар
өгүүллүүдийг уншиж мөн өөрийнхөө
түүхийг илгээнэ үү.

Сүнсэлг өдөөлт бүхий бусадтай
хуваалцаж болох захиасуудыг
(англи, португаль, испани хэлээр)
facebook.com/liahona
хаягаар орж үзээрэй.



Санал хүсэлтээ
liahona@ldschurch.org
хаягаар илгээнэ үү.



Store.lds.org-оор орж захиална уу.
Аль эсвэл хангамжийн төв дээрээ очин,
тойргийн удирдагчаасаа асууж лавлан,
1-800-537-5971 (Америкийн Нэгдсэн Улс
болон Канадад) дугаараар холбогдоно уу.

GETTY IMAGES-ИЙН ШИГТЭЭ ЗУРАГ

ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа.

Аз жаргал, 4
Анхдагчид, 24, 30, 44
Ариун Сүнс, 20, 68
Ариун сүм, 58, 62, 63,
64, 74
Баптисм, 74
Бэрхшээл, 24, 43
Гэр бүл, 62, 64, 66, 68
Есүс Христ, 60, 72
Залбирал, 20, 48, 50, 76
Золиослол, 44, 64

Иосеф Смит, 12
Итгэл, 30, 40, 43
Мормоны Ном, 12, 36,
73, 80
Наманчлал, 63
Номлолын ажил, 18, 70
Нөхөрлөл, 68, 70, 75
Өөртөө итгэлтэй
байдал, 10
Судраас судлах, 48, 50
Сүмийн түүх, 12

Тэнгэрлэг Эцэг, 20, 48
Үйлчлэл, 6, 54
Үлгэр жишээ, 40, 41, 70
Үнэн, 50
Үнэнч байдал, 30, 75
Хуваалцах, 79
Хүндэтгэлийн өдөр,
56, 60
Хөрвөлт, 18, 36, 42, 44
Энэрэл, 6





ИТГЭЛИЙН ХӨРӨГ

Виктор төрөх байсан хугацаанаасаа гурван сарын өмнө төрсээ. Үүний улмаас тэр нэлээд хөгжслийн бэрхшээлтэй төрсөн бөгөөд долоон нас хүртлээ алхаж чаддаггүй байв. Виктор өөрт нь тулгарсан бэрхшээлийг үл тоон, баяр хөөртэй хүн байхаар шийдсэн юм. Тэр бусадтай харьцаж, тэдэнд хайраа үзүүлснээр баяр хөөрийг мэдэрдэг.

ГЭРЭЛ ЗУРАГЧИН ЛЭСЛИЙ НИЛССОН

Виктор Барбинягра

Украин, Харьков

Би бусад бүх хүнтэй адил өөрийн гэсэн асуудал бэрхшээлтэй. Тэдгээр нь бусдынхаас бага эсвэл их биш ч, бас бид тэдгээрийг 100 хувь шийдэж чадахгүй байж болох ч асуудал бэрхшээлээ туулан, баттай урагшилж чадна гэдгийг би мэднэ.

Сүмийн ачаар би Бурханы төлөвлөгөө бол аз жаргалын төлөвлөгөө учраас, юунаас ч үл хамааран та аз жаргалтай байж чадна гэдгийг мэддэг. Аз жаргал бол бидний дотоод сэтгэлийн асуудал бөгөөд гадны зүйл биш гэдэгт би итгэдэг.

Итгэлтэй байж, Бурханд найдсанаар мөн сайн мэдээний дагуу амьдарснаар аз жаргал ирдэг. Энэ нь бидэнд зөв хандлагатай байхад мөн өөрсдөдөө байгаа зүйлийг өөрсдийгөө сайжруулахын тулд ашиглахад тусалж чадна.

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Викторын итгэлтэй болохын тулд туулсан замын талаар илүү ихийг liahona.lds.org-оос үзнэ үү.

Авралын төлөвлөгөө бидэнд аз жаргалыг олоход хэрхэн тусалдгийг олж мэдэхийн тулд lds.org/topics дээрх "Plan of Salvation"-ээс үзнэ үү.

Тохинууллын зарчим:

ӨРӨВЧ СЭТГЭЛЭЭР БУСДАД ТУСЛАМЖИЙН ГАРАА СУНГА

*Та Аврагчийн өрөвч сэтгэлийн үлгэр жишээг дагаснаар
бусдын амьдралыг өөрчилж чадна гэдгээ олж мэдэх болно.*

Өрөвч сэтгэл нь бусдын зовлонг ойлгохын зэрэгцээ уг зовлонг нь нимгэлэх буюу хөнгөлөхөд туслах хүсэлтэй байхыг хэлнэ. Аврагчийг дагах гэрээ нь “нэг нэгнийхээ ачааг . . . үүрэлцэ[н]” (Мозая 18:8) өрөвдөн хайрлах гэрээ юм. Бусдыг харж хандах үүрэг даалгавар нь Их Эзэний адил: “эргэлзэгсдэд өршөөнгүй бай[ж]” (Иуда 1:22) үйлчлэх боломж билээ. Их Эзэн “хүн бүр өөрийн ах дүүст энэрэл ба өрөвч сэтгэлээр хандагтун” (Зехариа 7:9) хэмээн зарлигласан.

Аврагчийн өрөвч сэтгэл

Өрөвч сэтгэл нь Аврагчийн тохинууллын хөдөлгөгч хүч байсан юм (хажуу талын хэсэг дэх “Өрөвч сэтгэлт Аврагч”-ийг үзнэ үү). Түүний бусдыг өрөвдөх сэтгэл тоо томшгүй олон удаа эргэн тойрныхондоо тусламжийн гараа сунгахад хүргэсэн. Тэрээр хүмүүсийн эрэлт хэрэгцээ, хүсэл эрмэлзлийг ялган таньснаар

хамгийн тохиромжтой арга замаар тэднийг адислан, зааж сургаж байв. Биднийг зовж шаналах үед өргөн дэмжих гэсэн Аврагчийн хүсэл өрөвч сэтгэлийн дээд зэргийн илрэл болох үйлдэл буюу хүн төрөлхтний нүгэл болон зовлон шаналлын өмнөөс Цагаатгал хийхэд хүргэсэн билээ.

Бид үйлчилж байхдаа хүмүүсийн хэрэгцээнд нийцүүлэн туслах Түүний чадавхыг үлгэрлэн дагахыг хичээнгүйлэн чармайх ёстой. Бид зөв шударга амьдарч, Сүнсний өдөөлтийг сонссоноор утга учир бүхий арга замаар бусдад туслах боломжтой.

Бусдыг өрөвдөн хайрлах бидний гэрээ

Тэнгэрлэг Эцэг Өөрийн хүүхдүүдийг өрөвч сэтгэлтэй байхыг хүссэн (1 Коринт 12:25–27-г үзнэ үү). Бид Түүний жинхэнэ шавь болохын тулд бусдыг, ялангуяа тусламж хэрэгтэй хүмүүсийг өрөвдөн хайрлах сэтгэлийг өөрсдөдөө хөгжүүлэн, үзүүлэх ёстой (С ба Г 52:40).



Тохинууллын зарчмууд нэг нэгнээ халамжлахад бидэнд туслах зорилготой бөгөөд хуваалцах захиас биш юм. Үйлчилж байгаа хүмүүсээ таньж мэдэх үед тэдэнд халамж энэрлээс гадна ямар захиас хэрэгтэй байгааг Ариун Сүнс бидэнд шивнэн хэлэх болно.

Бид баптисмын гэрээгээрээ дамжуулан Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авснаар өрөвч сэтгэлээ хөгжүүлэх хүсэлтэй болохоо гэрчилдэг. Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх ерөнхийлөгч Хэнри Б.Айринг Ариун Сүнсний бэлэг бидэнд үүнийг хийхэд тусалдаг болохыг заасан. Тэрээр: “Та бол Есүс Христийн Сүмийн гэрээт гишүүн. . . .

“Чухамхүү тийм учраас та уй гашуу, бэрхшээл бүхий ачааг үүрэн, урагш тэмүүлэхээр тэмцэж буй хүнд туслахыг хүсдэг. Та тэр хүмүүсийн ачаа дарамтыг хөнгөн байлгаж, тэднийг тайвшруулахад Их Эзэнд тусална хэмээн амласан. Та Ариун Сүнсний бэлэг хүлээн авахдаа тэдгээр ачааг хөнгөлөхөд туслах хүчийг хүлээн авсан билээ”¹ хэмээн хэлсэн.

Жишээлбэл, Орос дахь нэг эгч гэр бүлийн хүнд хэцүү нөхцөл байдлын улмаас жил гаруй хугацаанд Сүмдээ явж чадаагүй байна. Салбарынх нь өөр нэгэн эгч түүнд өрөвч сэтгэлээр тусламжийн гараа сунган, ням гараг бүр утасдаж, сүм дээр хэлсэн үг, заасан хичээл, номлолын дуудлага, шинээр төрсөн хүүхдүүд болон салбарын тухай өөр бусад мэдээг дуулгадаг байжээ. Уг эгчийн гэр бүлийн нөхцөл байдал шийдвэрлэгдэхэд, найз нь түүн рүү долоо хоног бүр утасдаж байсны ачаар түүнд салбарынхаа нэгэн хэсэг хэвээр байгаа мэт санагдсан ажээ. ■

ЭШЛЭЛ

1. Хэнри Б.Айринг, “Тайтгаруулагч,” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 137.



ӨРӨВЧ СЭТГЭЛТЭЙ АВРАГЧ

Есүс Христийн өрөвч сэтгэл Түүнд тохиууллынхаа үеэр хэрхэн эргэн тойрныхоо хүмүүсийг эдгээж, адислан, зааж сургах хүслийг төрүүлж байсан тухай өгүүлсэн дараах судруудыг судлахыг бодож үзнэ үү.
Матай 9:35–38; 14:14; 18:27, 33; 20:30–34;
Марк 1:40–42; 5:19; 6:30–42; 9:22; Лук
7:13; 10:33; 15:20.

Өрөвч сэтгэлийг хөгжүүлэхэд зориулсан дөрвөн санаа

Хэдийгээр бид зовлон зүдгүүрийг туулснаар өрөвч сэтгэлийг өөрсдөдөө хөгжүүлж болох ч үүний тулд өнөөдрөөс эхлэн зарим зүйлийг хийж чадна. Та энэ дөрвөн зарчмыг хэрэгжүүлж болох арга замыг бодож үзнэ үү.

Үүний төлөө залбир. Та нарыг Тэнгэрлэг Эцэгт хандах үед Тэрээр зүрх сэтгэлийг тань нээх бөгөөд “бусад хүний мөнхийн халамж, аз жаргалын талаар үнэн сэтгэлээсээ санаа зовних болно” (Миний сайн мэдээг номло: Номлолын үйлчлэлд зориулсан удирдамж [2004], 135 мөн Моронай 7:48-ыг үзнэ үү).

1. Залбирал

Дадлага хий. Та нар бусдыг сонсож, ойлгосноор бусдад өрөвч сэтгэлийг үзүүлж болно. Өөрсдийгөө тэдний оронд тавьж, тэдэнд ямар санагдаж байгааг мэдэр. Хэрэв нөхцөл байдал бүрдэж, цаг зав гарах юм бол тэдний өвчин, зовлон, зүдгүүрийг нимгэлэхэд тусалж болно.

2. Дадлага

4. Найз нөхөрлөл

Дотнын найз нь бай. Өрөвч сэтгэлээ харуулах нь хүмүүсийн амьдралыг чин сэтгэлээсээ сонирхож байгаагаа харуулах гэх мэт энгийн зүйл байж болно. Сайн сонсож сур (“Тохинуулын зарчмууд: Сайн сонсогчдын хийдэг таван зүйл,” *Лиахона*, 2018 оны 6-р сар, 6–9-ийг үзнэ үү). Та тэднийг улам их хайрладаг болох ба уг хайраа үзүүлэх арга замыг таньж мэдэхэд илүү амархан болно.

3. Сүнслэг өдөөлт

Сүнслэг өдөөлтийг дага. Их Эзэн бидэнд өөрсдөө анзаарахгүй байж болох өрөвч сэтгэлээ үзүүлэх арга замуудыг илчилж чадна. Бусдад туслах Сүнслэг өдөөлтийг мэдэрсэн бол үүний дагуу үйлдэхдээ бүү эргэлз.

ӨРӨВЧ
СЭТГЭЛ

ӨӨРИЙНХӨӨ ХЭН БОЛОХЫГ МӨН ХЭН БАЙСНЫГ МЭДЭХ НЬ

Шэри Л.Дью

Энэхүү шинэ цувралд сүсэг бишрэлтэй эмэгтэйчүүдийн амьдрал, захиасаас онцлон нийтлэх бөгөөд
At the Pulpit: 185 Years of Discourses by Latter-day Saint Women (2017) номноос хэсэгчлэн авав.

Саяхан миний 16 настай үеэл дүү Мэган хоёр найзынхаа хамт манайд хонохоор ирсэн юм. Тэр орой биднийг ярилцаж байтал тэдний нэг нь дээр үед эдлэн газар дээр өсөх нь ямар байсныг асуув. . . . Би Мэганд болон түүний найзуудад “дээр үед” маш ичимхий бас өөртөө итгэх ямар ч итгэлгүй байдаг байснаа хэлсэн.

Тэгэхэд Мэган “Та энэ байдлаа-саа яаж салсан бэ?” гэж асуув. Бэлэн хариулт яг аман дээр гарч ирэхэд, би энэ сайхан залуу эмэгтэйчүүдийн илүү ихийг сонсоход бэлэн байгааг мэдрээд, хэлээ хааж билээ. Тиймээс би тэдэнд гол шалтгаан нь сүнс-лэг шалтгаан байсныг хэлсэн. Их Эзэн миний талаар ямар бодолтой байдгийг ойлгож эхэлмэгц миний өөрийнхөө талаарх болон өөрийн амьдралын талаарх үзэл бодол өөрчлөгдөж эхэлсэн хэмээн би хэлсэн юм. Тэгэхэд тэд тэр даруй: Та Их Эзэн ямар бодолтой байсныг яаж

мэдсэн юм бэ? Бас Түүнийг бидний талаар ямар бодолтой байдгийг бид өөрсдөө хэрхэн олж мэдэж болох вэ? гэж асуув.

Бид судар барин, хэдэн цагийн туршид Сүнсний дуу хоолойг хэрхэн сонсох тухай болон бидний хэн болох, бидний зорилго юу болох талаарх бодгальдаа далд хадгалагдсан мэдлэгээ ил гаргаасай гэж Их Эзэн үнэхээр хүсдэг тухай мөн бид үүнийг олж мэдэх үед энэ нь амьдралыг хэрхэн өөрчилдөг тухай ярилцсан.

. . . Бидний амжилт, аз жаргалд Сүнсний дуу хоолойг сонсож сурахаас илүү чухал зүйл байдаггүй. Бидний хувь хүн бүрийн өвөрмөц чанар буюу бидний хэн гэдгийг төдийгүй бас хэн байсныг өөрсдөд маань илчилдэг нь Сүнс юм. Ийнхүү үүнийг олж мэдэх үед бидний амьдрал гэнэт шинэ зорилготой болж, тэгснээр бид эргэлт буцалтгүй өөрчлөгддөг.



ДЬЮ ЭГЧИЙН ТУХАЙ

Шэри Линн Дью

1953 онд АНУ-ын

Канзас мужийн Үлис-

сэст төржээ. Тэр таван

хүүхдийн ууган нь байсан

бөгөөд тавдугаар анги төгсөх

үедээ гэрийнхээ буудайн эдлэн

дээр трактор бариад явдаг байжээ.

Ням гарагт эмээ Мауди Дью нь

сүмд явахаар өглөө эрт ирж авдаг

байсан бөгөөд цуглаан нь түрээсийн

байранд болдог байлаа. Тэд өрөөг

цуглаанд бэлдэхийн тулд тамхины

иш, пивоны лааз зэргийг цэвэрлэ-

дэг байжээ. Жижиг салбарт явдаг

байсан болохоор тэр маш олон удаа

үг хэлж, бас заадаг байсан байна.

Тэр залуу эмэгтэй байхдаа салба-

рын төгөлдөр хуурч болсон бөгөөд

16 настай байхдаа салбарынхаа

Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийн

зөвлөлд үйлчилж байжээ.

1978 онд Бригам Янгийн Их

сургуулиас түүхчийн диплом авс-

ныхаа дараа, Бүккрафт компанид

хянагчаар ажилд орсон байна. Тэр

1988 онд Дезерет Бүкт ажилд орсон

ба 2000 онд дэд ерөнхийлөгчөөр

ажиллаж эхэлжээ.

Тэр Барбара В.Вайндэрийн

ерөнхийлөгчийн зөвлөлийн удирд-

лаган доор Халамжийн нийгэм-

лэгийн ерөнхий хороонд элсэхдээ

35 настай байлаа. Тэр 1997 онд

Халамжийн нийгэмлэгийн ерөнхий

ерөнхийлөгчийн зөвлөлд Мэри

Эллэн В.Смүүтийн хоёрдугаар зөвлөх

болохдоо дөнгөж 43 настай байсан.

Дью эгч 2001 оны БЯИС-ийн

Эмэгтэйчүүдийн чуулганд үг хэлэх-

дээ өөрсдийн үнэ цэнийг ойлгож

ухаарахыг эмэгтэйчүүдэд зөвлөснөөс

эш татав.

. . . Бидний сүнс биднийг өөрсдийнхөө хэн болох талаарх үнэнийг санаасай гэж хүсэж байдаг. Яагаад гэвэл бид өөрсдийгөө ямар байдлаар харж байгаа болон өөрсдийгөө хэрхэн таньж мэдэж байгаа маань бидний бүх зүйлд нөлөөлдөг. . . . Энэ нь амьдралаа хэрхэн авч явж байгаа арга замд нөлөөлдөг. Тиймээс, өнөөдөр би та нарыг өөрсдийнхөө хэн гэдэг талаар төдийгүй мөн урьд өмнө хэн байсан талаараа тунгаан бодоход урьж байна.

. . . Биднийг төгс төгөлдөр мэддэг Бурхан биднийг өнөөдөр, урьд урьдынхаас илүү эсэргүүцэл, эрсдэл ихтэй энэ цаг үед ирүүлэхээр

хадгалж байсан гээд та нар төсөөлөөд үз дээ? Сүнслэг байдлын хувьд хамгийн аюултай орчин нөхцөлд сонгомол үеийнхнийг өсгөж, удирдах эмэгтэйчүүд хэрэгтэй байгаа энэ цаг үед гээд бодоод үз дээ? Тэр биднийг Сионыг өсгөн бэхжүүлэхдээ няцашгүй зоригтой байх болно гэдгийг мэдэж байсан учраас биднийг сонгосон гэдгийг та нар төсөөлж чадах уу?

. . . Үнэнч бөгөөд агуу. Зоригтой бөгөөд шийдмэг. Итгэлтэй бөгөөд эрэлхэг. Та нар ийм л хүмүүс мөн ийм ч байсаар ирсэн. Энэхүү үнэнийг ойлгох нь та нарын амьдралыг өөрчилж чадна. Учир нь энэ мэдлэг

өөр ямар ч байдлаар иршгүйгээр өөртөө итгэх итгэлийг авчирдаг.

. . . *Та* сонгогдсон мөн энэ үеийн төлөө хадгалагдсан гэдгийг ойлгох үедээ, бас энэхүү зорилготой нийцэн амьдрах үед урьд өмнө байснаасаа илүү баяр хөөртэй байх болно.

. . . Бурхан бол бидний Эцэг бөгөөд Түүний Төрсөн Ганц Хүү нь Христ юм. Бид Аврагчийн төлөө цэх зогсон, Түүний жимсний талбайд хичээнгүй, цуцашгүй дахин үйлчлэхдээ баяр хөөртэй байгаасай. Бид өөрсдийгөө хэн болохыг мөн хэн байсныг мэддэг учраас Бурханыхаа Сионыг байгуулахдаа эрэлхэг зоригтой байх болтугай. ■







5-Р БҮЛЭГ

Ингээд өнгөрдөг байж

Энэ бол Гэгээнтнүүд: Хожмын үеийн Есүс Христийн Сүмийн түүх нэртэй Сүмийн шинэ дөрвөн боть түүхийн номны 5-р бүлэг юм. Уг ном 14 хэл дээр хэвлэгдэн гарах бөгөөд Gospel Library аппликэйшны Сүмийн түүх хэсэгт болон онлайнаар saints.lds.org вэбсайт дээр тавигдана. Уг номын 1-р боть энэ оны сүүлээр хэвлэгдэн гарах хүртэл дараагийн хэдэн бүлгийг ирэх дугаарууддаа нийтлэх болно. Тэдгээр бүлэг нь Gospel Library аппликэйшн болон saints.lds.org вэбсайт дээр 47 хэлээр тавигдах юм.

Иосефыг алтан ялтсуудыг гэртээ авчирсны дараа эрдэнэсийн ангуучид олон долоо хоногийн туршид хулгайлах гэж оролджээ. Цэдгийг хамгаалахын тулд тэр нэг газраас нөгөө рүү шилжүүлэн, аавынхаа ажлын өрөөний зуух болон шалан доор мөн хураасан буудайн дотор нууж байв. Тэр огтхон ч анхаарлаа сулруулсангүй.

Хөршүүд нь хэрэгт дурлан гэрт нь ирж, цэдгийг үзүүлээч хэмээн гуйдаг байжээ. Хүмүүс мөнгө төлж үзье гэсэн ч Иосеф үргэлж татгалздаг байв. Хэрэв ялтсуудыг хамгаалахын тулд чадах бүхнээ хийх юм бол тэдгээр нь хамгаалагдах болно хэмээх Их Эзэний амлалтад тэр итгэж, тэдгээрийг хамгаалахаар эрс шийдэмгий байлаа.¹

Энэ бүхэн түүнд ялтсуудыг нягтлан шинжилж, Урим ба Туммимын талаар илүү ихийг олж мэдэхэд байн байн саад болдог байв. Хөрвүүлэгч чулуунууд ялтсуудыг орчуулахад туслах ёстой гэдгийг тэр мэдэж байсан ч үзмэрч чулуунуудыг эртний хэлийг уншихад огт хэрэглэж үзээгүй байлаа. Тэр ажлаа эхлүүлэхийг тэсэн ядан хүлээж байсан ч хэрхэн хийхээ сайн мэдэхгүй байв.²

Харин Иосефыг ялтсуудыг судалж байхад Палмирагийн нэр хүндтэй газрын эзэн Мартин Харрис гэгч түүний ажлыг сонирхох болжээ. Мартин Иосефын аавтай ойролцоо настай байсан бөгөөд заримдаа түүнийг газар дээрх ажилдаа туслуулахаар хөлсөлдөг байж. Мартин

алтан ялтсуудын талаар сураг дуулсан байсан ч Иосефын ээжийг гэрт нь ирж, хүүтэй нь уулз хэмээн урих хүртэл тэдгээрийг чухал гэж боддоггүй байлаа.³

Мартиныг ирэх үед Иосеф гадуур ажиллаж байсан учраас тэр Эмма болон гэр бүлийнх нь бусад гишүүнээс ялтсуудын талаар асууж лавлажээ. Иосефыг гэртээ ирэхэд Мартин гараас нь бариад, дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсэв. Иосеф түүнд алтан ялтсуудын тухай болон тэдгээрт бичсэн зүйлсийг орчуулан, хэвлэ хэмээх Моронайн зааварчилгааны тухай яриу.

“Хэрэв энэ нь чөтгөрийн ажил бол би үүнд оролцохгүй” хэмээн Мартин хэлсэн байна. Харин энэ нь Их Эзэний ажил бол тэр Иосефт үүнийг дэлхийд тунхаглахад нь туслахыг хүсэж байв.

Иосеф Мартинд хайрцган дотор байсан ялтсуудыг бариулж үзүүлжээ. Мартин ямар нэгэн хүнд зүйл дотор нь байна гэдгийг мэдсэн ч энэ нь алтан ялтсууд мөн эсэхэд эргэлзэж байлаа. “Чиний үгэнд итгээгүйд намайг битгий буруутгаарай” хэмээн тэр Иосефт хэлэв.

Харин Мартин шөнө дөлөөр гэртээ ирж, унтлагынхаа өрөөнд ороод, Иосефын хийж байгаа зүйл бурханлаг ажил мөн гэдгийг мэдэх юм бол байгаа бүхнээ зориулна гэдгээ Бурханд амлан залбирчээ.

Залбирч байхдаа Мартин намуухан зөөлөн дуу хоолой бодгальд нь ярихыг сонсов. Тэр мөчид ялтсууд Бурханаас ирсэн гэдгийг мөн Иосефт захиасыг нь хуваалцахад туслах ёстой гэдгээ тэр мэджээ.⁴

1827 оны сүүлээр Эмма жирэмсэн болсноо мэдэж, эцэг эхдээ захидал бичив. Иосеф тэр хоёр гэрлээд бараг жил болж байсан ба эцэг эх нь үүнд дурамжхан хэвээр байлаа. Гэвч Хэйлсүүд гэр бүлийнхнийхээ хажууд төрөх

боломжийг Эммад олгон, залуу хосыг Хармонид эргэн ирэхийг зөвшөөрөв.

Хэдийгээр Иосеф өөрийн эцэг эх, ах дүү нараас холдох хэрэгтэй болсон ч явах дуртай байсан юм. Нью Йоркод хүмүүс ялтсуудыг хулгайлах гэж оролдож байсан ба шинэ газар руу нүүх нь Их Эзэний ажлыг хийхэд шаардагдах амар тайван, ганцаар байх боломжийг түүнд олгох байлаа. Харамсалтай нь тэр өртэй байсан тул түүнд нүүхэд шаардагдах мөнгө байсангүй.⁵

Санхүүгийн асуудлаа зохицуулах зорилгоор тэр хотын төв рүү зарим өрөө төлөхөөр оржээ. Дэлгүүрт төлбөрөө хийж байх зуур Мартин Харрис түүн рүү дөхөж ирээд, “Ноён Смит, энэ тавин долларыг ав. Би үүнийг Их Эзэний ажлыг хийгээрэй хэмээн танд өгч байна” гэж хэлэв.

Иосеф мөнгийг нь авахдаа тээнэгэлзсэн ч эргүүлэн төлөхөө амлахад Мартин санаа зовох хэрэггүй гэж хэлжээ. Мөнгө нь бэлэг байсан бөгөөд өрөөнд байгаа бүх хүнийг сайн дураараа өгсөн гэдгийг нь гэрчлэхийг тэр хүссэн байна.⁶

Удалгүй Иосеф өрөө ч төлж, тэргэндээ эд зүйлсээ ачив. Дараа нь тэр Эмматай хамт алтан ялтсуудыг ван-дуйтай торхонд нуугаад, Хармонийг зорилоо.⁷

Хосууд ойролцоогоор долоо хоногийн дараа Хэйлсүүдийн цэлгэр том гэрт ирэв.⁸ Тун удалгүй Эммагийн аав алтан ялтсуудыг харуулахыг шаардсан ч Иосеф зөвхөн хадгалж буй хайрцгаа л үзүүлж чадна гэв. Үүнд нь уурласан Исаак түгжээтэй хайрцгийг авч үзэхэд хүнд байсан ч эргэлзсэн хэвээр үлджээ. Дотор нь юу байгааг үзүүлэхгүй юм бол гэрт нь байлгахыг зөвшөөрөхгүй хэмээн тэр хэлэв.⁹

Эммагийн аавын дэргэд орчуулга хийх тийм ч амар байсангүй. Гэхдээ Иосеф чадлаараа хичээж байлаа. Эммагийн тусламжтай тэр ялтсууд дээрх олон сонин үсгийг цаасан дээр хуулбарлан буулгав.¹⁰ Үүний дараа тэр хэдэн долоо хоногийн турш тэдгээрийг Урим ба Туммимаар орчуулах гэж үзжээ. Үүнийг хийхэд хөрвүүлэгчээр харахаас илүү зүйлийг түүнээс шаардаж байв. Тэр үсгүүдийг судалж байхдаа даруу байж, итгэлээ хөгжүүлэх ёстой байлаа.¹¹

Хэдэн сарын дараа Мартин Хармонид ирэв. Их Эзэн түүнийг Нью Йорк хот руу явж, эртний хэл судлаачидтай

уулз хэмээн дуудсан гэж тэр хэлжээ. Тэр өөрсдийгөө үсгүүдийг орчуулж чадна байх гэж найдаж байв.¹²

Иосеф ялтсуудаас өөр хэд хэдэн үсгийг хуулбарлан авч, орчуулж бичсэн цаасаа Мартинд гардуулсан байна. Эмма тэр хоёр зүүн зүг рүү нэртэй эрдэмтэдтэй уулзахаар явж буй найзаа харсаар үлдэв.¹³

Мартин Нью Йоркт ирээд, Колумбийн коллежийн латин, грек хэлний эрдэмтэн профессор Чарльз Антонтой уулзахаар очжээ. Профессор Антон нь Мартинаас бараг арван таван насаар дүү хүн байсан ба грек, ромын соёлын тухай нэртэй толь бичгийг хэвлүүлэн гаргасан гэдгээрээ олонд танил болсон нэгэн байв. Тэр бас америкийн индианчуудын талаарх түүхийг цуглуулж эхэлсэн байв.¹⁴

Антон өөрт нь саад болоход дургүй, хатуу чанга эрдэмтэн байсан ч Мартиныг хүлээн авч, үсгүүд болон Иосефын орчуулгыг судалжээ.¹⁵ Хэдийгээр уг профессор египет хэлийг мэдэхгүй ч уг хэлний талаарх зарим судалгааг уншиж танилцсан байсан тул яаж харагддагийг нь мэдэж байв. Үсгүүдийг харж байхдаа тэр египет хэлтэй төстэй талууд байгааг олж хараад, Мартинд орчуулгыг зөв хэмээн хэлжээ.

Мартин ч түүнд өөр үсгүүдийг үзүүлэхэд Антон тэдгээрийг бас судлав. Тэдгээрийн дунд эртний олон хэлний үсгүүд орсон байна хэмээн хэлээд Мартинд үнэн болохыг нь баталсан гэрчилгээ өгчээ. Түүнчлэн үсгүүдийг Самуел Митчилл хэмээх Колумбид заадаг байсан өөр нэгэн эрдэмтэнд үзүүлэхийг тэр зөвлөсөн байна.¹⁶

“Тэр эртний хэлнүүдийг сайн сурсан бөгөөд таны сэтгэлд нийцсэн хариултыг өгнө гэдэгт би итгэлтэй байна” хэмээн Антон хэлжээ.¹⁷

Мартин гэрчилгээг нь халаасандаа хийгээд яг гарах гэж байтал Антон түүнийг эргүүлэн дуудав. Тэр Иосефыг хаанаас алтан ялтсуудыг олсон гэдгийг мэдэхийг хүсэж байлаа.

“Бурханы нэгэн тэнгэр элч үүнийг түүнд илчилсэн” хэмээн Мартин хариулсан байна. Мөн ялтсуудын орчуулга дэлхийг өөрчлөн, устгагдахаас аварна хэмээн гэрчилжээ. Одоо түүнд тэдгээр нь үнэн гэсэн баталгаа байгаа тул тэр фермээ зарж, олсон мөнгөө орчуулгыг хэвлүүлэхэд хандивлана гэдгээ хэлсэн байна.

Антон “Гэрчилгээг чинь хараадахъя” гэжээ.

Мартин ч гэрчилгээг халааснаасаа гаргаж ирээд, түүнд өгөв. Харин Антон гэрчилгээг хэдэн хэсэг болгон ураад, тохинуулагч тэнгэр элч мэтийн зүйл байдаггүй хэмээн хэлсэн аж. Хэрэв Иосеф ялтсуудыг орчуулъя гэж бодож байгаа л юм бол Колумбид авчран, эрдэмтдээр орчуулуулах хэрэгтэй гэв.

Ялтсуудын нэг хэсэг нь лацдагдсан бөгөөд тэдгээрийг үзүүлэхийг Иосефт хориглосныг Мартин түүнд тайлбарлалаа.

Антон “Би лацдагдсан номыг уншиж чадахгүй” гэж хэлэв. Мөн тэр Иосеф түүнийг мэхэлж байгаа байх хэмээн сануулаад, “Зальхай этгээдүүдээс болгоомжил” гэж хэлсэн байна.¹⁸

Мартин профессор Антоныг орхин гараад, Самуел Митчилтэй уулзжээ. Тэр Мартиныг эелдгээр хүлээн авч уулзан, түүний түүхийг сонсож, үсгүүд болон орчуулгыг нь харж танилцав. Тэр утгыг нь гаргаж чадахгүй байсан ч египетийн дүрс үсэгтэй төстэй бөгөөд устаж алга болсон ард түмний бичиг байна хэмээн хэлжээ.¹⁹

Мартин удалгүй хотоос явж, Хармонид ирсэн бөгөөд тэрээр Иосефт эртний алтан ялтсууд мөн тэдгээрийг орчуулах хүч байгаа гэдэгт хэзээ хэзээ нээс илүү ихээр итгэх болсон байв. Тэр профессоруудтай хийсэн ярилцлагынхаа талаар Иосефт яриад, хэрэв Америкийн хамгийн боловсролтой эрчүүдийн зарим нь номыг орчуулж чадахгүй байгаа юм бол тэр орчуулгыг хийх хэрэгтэй хэмээн хэлжээ.

“Би чадахгүй. Учир нь би боловсролгүй нэгэн билээ” гэж Иосеф сандран хариулсан байна. Гэхдээ Их Эзэн түүнд ялтсуудыг орчуулахад туслах хөрвүүлэгчийг бэлдсэн гэдгийг тэр мэдэж байлаа.²⁰

Мартин ч хүлээн зөвшөөрөв. Тэр Палмира руу буцаж очин, ажил төрлөө эмхэлж цэгцлээд, аль болох хурдан эргэн ирж, Иосефын бичээчээр үйлчлэхээр төлөвлөжээ.²¹

1828 оны 4-р сард Эмма, Иосеф хоёр Эммагийн эцэг эхийн гэрээс холгүй, Сасквиеханна голын эрэг дээрх байшиндаа амьдарч байв.²² Төрөх нэлээн дөхсөн ч Иосефыг цэдгийг орчуулж эхэлснээс хойш тэр ихэвчлэн бичээчээр нь ажилладаг байлаа. Нэгэн өдөр Иосеф орчуулж байгаад нүүр нь гэнэт хувирснаа,

“Эмма, Иерусалимыг тойрсон хана байсан юм уу?” гэж асуужээ.

Тэр Библи дээр дүрслэн бичсэн зүйлсийг санаад, “Тийм ээ” гэж хариулав.

Иосеф “Өө, би хууртагдсан байна гэж айлаа” хэмээн санаа нь амарсан байдалтай хэлсэн гэдэг.²³

Түүх, судрын талаарх нөхрийнх нь мэдлэг нимгэн байсан ч орчуулгын ажилд нь огт саад болохгүй байсанд Эмма гайхдаг байжээ. Иосеф арайхийн нэг уялдаа холбоотой захидал бичдэг байв. Гэсэн ч түүнийг ямар ч ном, гар бичмэлгүйгээр цэдгийг хэлж бичүүлж байхад Эмма хажууд нь олон цагаар суудаг байсан юм. Зөвхөн Бурхан л түүнийг сүнслэгээр өдөөн орчуулуулж байсныг тэр мэдэж байлаа.²⁴

Удалгүй Мартин Палмирагаас буцаж ирэн, бичээчээр нь ажиллах болсноор Эммад хүүхдээ төрүүлэхээсээ өмнө амсхийх боломж олгов.²⁵ Гэвч амрахад


тийм ч хялбар байсангүй. Мартинтай хамт эхнэр Люси нь Хармонид ирнэ гэж зүтгэсээр ирсэн ба Мартиныхан хоёулаа хурц ааштай хүмүүс байлаа.²⁶ Иосефыг санхүүгээр дэмжих гэсэн Мартины хүсэл Люсид сэжигтэй санагдаж мөн тэр өөрийг нь Нью Йорк руу авч яваагүйд ууртай байв. Хармони руу орчуулгад туслахаар явах гэж байгаагаа хэлэхэд нь тэр нөхрөө дагаж, ялтсуудыг үзэх зорилгоор ирсэн байлаа.

Люсигийн сонсгол муудаж эхэлсэн байсан ба хүмүүсийн хэлж байгаа зүйлийг ойлгохгүй бол заримдаа тэр

өөрийг нь шүүмжилж байна гэж тусгаж авдаг байв. Мөн тэр бусдын хувийн орон зайг хүндэлж үзнэ гэдгийг мэддэггүй байлаа. Иосеф өөрт нь ялтсуудыг үзүүлэхээс татгалзахад тэр байшинг нь нэгжин, гэрийнх нь авдар, шүүтээ, чемоданыг хүртэл онгичиж эхэлжээ. Үүнээс болж Иосефт ялтсуудыг ойд нуухаас өөр сонголт байсангүй.²⁷

Люси ч удалгүй гэрээс нь явж, хөршийнд нь амьдрах болжээ. Эмма авдар, шүүтээгээ эргүүлэн эзэмших болсон ч Люси хөршүүдэд нь Иосеф Мартины мөнгийг авах гэж байна хэмээн ярих болов. Олон долоо хоногийн туршид бөөн асуудал тарьсны эцэст Люси Палмира дахь гэр рүүгээ явжээ.

Амар амгалан дахин тохиож, Иосеф, Мартин хоёр орчуулгыг хурдацтай хийж эхлэв. Үзмэрч, илчлэгч хэмээх тэнгэрлэг үүрэг хариуцлагаа гүйцэтгэх Иосефын



Мормоны Номын ялтаснууд дээрх үсгүүдийн зураглал.

чадвар хөгжиж байлаа. Хөрвүүлэгчдээр буюу өөр үзмэрч чулуугаар харснаар тэр ялтсууд өмнө нь байна уу эсвэл тэдгээрийг Эммагийн маалинган даавуунд ороон ширээн дээр тавьсан байна уу гэдгээс үл хамааран орчуулж чадаж байлаа.²⁸

Дөрөв, тав, зургаадугаар сарын эхэн хүртэл Иосеф цэдгийг нэгэн жигд хэлж бичүүлж байгааг Эмма сонсдог байв.²⁹ Тэр удаан боловч тод хэлж, заримдаа Мартин түүний хэлснийг гүйцээж бичсэнийхээ дараа “биччихлээ” гэж хэлэх хүртэл нь хүлээдэг байв.³⁰ Заримдаа Эмма бичээч хийдэг байсан бөгөөд дундуур нь завсарлага авах юм уу амарсныхаа дараа Иосеф хүнээр хэлүүлэлгүйгээр үргэлж орхисон газраасаа эхлүүлж чаддаг байсанд гайхдаг байжээ.³¹

Удалгүй Эммагийн төрөх цаг ч дөхлөө. Гар бичмэлийн цаас ч зузаарч, Мартин эхнэртээ орчуулгыг уншуулах юм бол тэр үнэ цэнийг нь олж харан, тэдний ажилд оролцохоо болино гэдэгт улам бүр итгэх болжээ.³² Тэр бас өөрийнхөө цаг зав, хөрөнгө мөнгийг Бурханы үгийг урагш авчрахад туслахад зориулж байгаад нь Люсиг баярлана байх хэмээн найдаж байв.

Нэг өдөр Мартин гар бичмэлийг хэдэн долоо хоног Палмира руу авч явахыг зөвшөөрөөч хэмээн Иосефоос гуйжээ.³³ Гэрт ирээд Люси Харрисын хэрхэн авирласныг санасан Иосефт уг санаа таалагдахгүй байв. Гэхдээ өөр олон хүн түүний үгэнд итгээгүй байхад түүнд итгэсэн Мартиныг тэр баярлуулахыг хүсэж байлаа.³⁴

Яахаа мэдэхгүй байсан Иосеф удирдамж авахаар залбирсан бөгөөд Их Эзэн түүнд Мартина хуудаснуудыг өгч болохгүй хэмээн хариулсан байна.³⁵ Гэхдээ эхнэртээ үзүүлэх юм бол бүх зүйлийг өөрчилнө гэдэгт Мартин ихэд итгэлтэй байсан учраас Иосефоос дахиж асуухыг хүсжээ. Иосеф асуусан боловч хариу нь урьдын адил байв. Мартин түүнд шахалт үзүүлэн гурав дахь удаагаа асуухыг хүсэхэд энэ удаад Бурхан тэдэнд хүссэнээрээ хий хэмээн хариулсан байна.

Хэрэв Мартин хуудаснуудыг түгжээтэй саванд хийж, зөвхөн гэр бүлийнхээ хэсэг хүнд л үзүүлэх юм бол хоёр долоо хоног авч явж болно гэж Иосеф түүнд хэлжээ. Мартин тэгнэ хэмээн амлаад, гартаа гар бичмэлийг барьсаар Палмира руу буцсан аж.³⁶

Мартиныг явсны дараа Моронай Иосеф дээр ирээд, хөрвүүлэгч чулуунуудыг авч явав.³⁷

Мартиныг явсны дараах өдөр Эмма нэлээн зовсны эцэст хүү төрүүлжээ. Хүү нь турьхан, өвчтэй байсан тул удаан амьдарсангүй. Энэ үйл явдлын дараа Эмма бие, сэтгэл зүйн хувьд туйлдаж ядарсан байсан ба заримдаа түүнийг үхлийн ирмэгт хүрлээ дээ гэж бодогдох үе ч тохиолдож байлаа. Иосеф түүнийг үргэлж асран халамжилж, нэг хэсэгтээ л түүний дэргэдээс салаагүй юм.³⁸

Хоёр долоо хоногийн дараа Эммагийн бие тэнхэрч, тэр Мартин болон гар бичмэлийн талаар бодох болжээ. “Надад нэг л хэцүү, тавгүй санагдаад байна. Ноён Харрис тэдгээрээр юу хийж байгаа талаар ямар нэг сураг сонсохгүй л бол сэтгэл амрахгүй нь” гэж тэр Иосефт хэлэв.

Тэр Мартиныг ол хэмээн шахан шаардсан ч Иосеф түүнийг орхихыг хүссэнгүй. “Ээжийг маань ир гэж хэл хүргэ. Чамайг байхгүй хооронд тэр надтай хамт байна” хэмээн тэр хэлэв.³⁹

Иосеф хойд зүг рүү явах шуудангийн тэрэгт суужээ.

Тэр Их Эзэний хэлсэн үгийг сонсолгүй Мартина гар бичмэлийг өгснөөрөө түүнийг гомдоосон байх вий гэхээс аяллын турш олигтой хоол ч идэж бас унтаж ч чадсангүй.⁴⁰

Түүнийг Манчестер дэх эцэг эхийнхээ гэрт ирэхэд нар мандаж байлаа. Смитийнхэн өглөөний ундаа идэхээр бэлдэж байсан ба Мартиныг тэдэнтэй нэгд хэмээн урин, хэл хүргэв. Найман цаг гэхэд ширээн дээр хоол унд бэлэн болсон байсан ч Мартин ирээгүй л байлаа. Түүнийг хүлээх зуур Иосеф болон гэрийнхэн нь түтшиж эхлэв.

Эцэст нь дөрвөн цаг өнгөрсний

дараа Мартин урдах газраа ширтсээр, гэр рүүгээ удаан гэгч холоос алхан ирж яваа харагдлаа.⁴¹ Тэр хашааны дэргэд зогсон, хашлаган дээр суунгаа малгайгаа нүд рүүгээ буулгав. Дараа нь тэр дотогш орж чимээгүй суулаа.

Гэрийнхэн нь Мартиныг хоол идэх гэж байгаа мэт халбага сэрээ авснаа доош унагаахыг харав. “Би бодгалиа алдлаа! Би бодгалиа алдлаа” хэмээн шанаан тушаагаа гараараа дарсаар тэр уйлав.

Иосеф үсрэн босож, “Мартин, чи гар бичмэлийг алдчихсан юм уу?” гэлээ.

“Тийм ээ, алга болсон, би хаана байгааг нь мэдэхгүй” гэж Мартин хариулав.

“Өө, Бурхан минь, Бурхан минь! Ингээд өнгөрдөг байж” хэмээн гараа зангидсаар Иосеф гасаллаа.

Тэр шалан дээгүүр нааш цааш холхисоор, юу хийхээ мэдэхгүй байв. “Буцаад яв” гэж тэр Мартинад



Пеннильванийн Хармони дахь Иосеф, Эмма Смит хоёрын гэр.

хэлэв. “Дахин хай” гэхэд нь

Мартин “Ямар ч хэрэггүй. Би гэрийнхээ нүх булан бүрийг нэгжсэн. Тэр ч бүү хэл ор, дэрээ хүртэл урж үзсэн. Байхгүй гэдгийг нь би мэдэж байна” гэв.

“Би эхнэртээ ийм үлгэр сонсгохоор очно гэж үү” гэж Иосеф дуу алдав. Энэ мэдээг сонсоод эхнэр нь үхнэ байх хэмээн тэр айж байлаа. “Би Их Эзэний өмнө ямар нүүрээрээ очих билээ?” гэв.

Ээж нь түүнийг тайвшруулах гэж оролдон, хэрэв даруухнаар наманчлах юм бол Их Эзэн уучилж магадгүй хэмээн хэлжээ. Харин энэ үед эхний удаа хэлэхэд нь л Их Эзэний үгийг дагаагүйдээ өөрөө өөртөө уурласан Иосеф эхэр татан уйлж байлаа. Тэр үлдсэн цагт олигтой юм ч идсэнгүй. Тэр орой тэндээ үлдээд, Иосеф дараа өглөө нь Хармони руу явжээ.⁴²

Люси сэтгэл нь зовсоор түүнийг явахыг харав. Гэр бүлийнхнийх нь хувьд итгэж найдаж байсан мөн сүүлийн хэдэн жилийн туршид тэдэнд баяр баясгалан авчирч байсан тэр зүйл нь ганцхан агшны дотор замхран алга болсон мэт санагдаж байлаа.⁴³ ■

Эш татсан бүтээлүүдийн бүрэн жагсаалт saints.lds.org вэбсайтад англи хэл дээр бий.

Тэмдэглэл дэх Сэдэв гэсэн үг нь онлайнгаар болон saints.lds.org вэбсайт дээр дэлгэрэнгүй мэдээлэл байгааг илэрхийлнэ.

ЭШЛЭЛҮҮД

1. Joseph Smith—History 1:59; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 8, in *JSP*, H1:236–38 (draft 2); Lucy Mack Smith, History, 1844–45, book 6, [1]–[2]; Knight, Reminiscences, 3.
2. Knight, Reminiscences, 3–4; Lucy Mack Smith, History, 1844–45, book 6, [1]–[3]; Joseph Smith History, circa Summer 1832, 1, in *JSP*, H1:11.
3. “Mormonism—No. II,” *Tiffany's Monthly*, Aug. 1859, 167–68; Lucy Mack Smith, History, 1844–45, book 6, [3]–[4]; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 8, in *JSP*, H1:238 (draft 2). **Сэдэв:** Мормоны Номын гэрчүүд
4. “Mormonism—No. II,” *Tiffany's Monthly*, Aug. 1859, 168–70.
5. Joseph Smith History, 1838–56, volume A-1, 8–9, in *JSP*, H1:238 (draft 2); Knight, Reminiscences, 3; “Mormonism—No. II,” *Tiffany's Monthly*, Aug. 1859, 170.
6. Lucy Mack Smith, History, 1844–45, book 6, [6]; Lucy Mack Smith, History, 1845, 121.
7. “Mormonism—No. II,” *Tiffany's Monthly*, Aug. 1859, 170.
8. “Mormonism—No. II,” *Tiffany's Monthly*, Aug. 1859, 170; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 9, in *JSP*, H1:240 (draft 2).
9. Isaac Hale, Affidavit, Mar. 20, 1834, in “Mormonism,” *Susquehanna Register, and Northern Pennsylvanian*, May 1, 1834, [1].
10. Joseph Smith History, 1838–56, volume A-1, 9, in *JSP*, H1:240 (draft 2); Knight, Reminiscences, 3.
11. Lucy Mack Smith, History, 1844–45, book 6, [3]; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 9, in *JSP*, H1:240 (draft 2); “Letter from Elder W. H. Kelley,” *Saints' Herald*, Mar. 1, 1882, 68; мөн Сургаал ба Гэрээ 9:7–8 (Revelation, Apr. 1829–D, at josephsmithpapers.org)-ийг үзнэ үү.
12. Joseph Smith History, circa Summer 1832, 5, in *JSP*, H1:15; Knight, Reminiscences, 3. **Topic:** Book of Mormon Translation (**Сэдэв:** Мормоны Номын орчуулга)
13. Joseph Smith History, 1838–56, volume A-1, 9, in *JSP*, H1:238–40 (draft 2); Joseph Smith History, circa Summer 1832, 5, in *JSP*, H1:15.
14. MacKay, “Git Them Translated,” 98–100.
15. Bennett, “Read This I Pray Thee,” 192.
16. Joseph Smith History, 1838–56, volume A-1, 9, in *JSP*, H1:240 (draft 2); Bennett, Journal, Aug. 8, 1831, in Arrington, “James Gordon Bennett’s 1831 Report on ‘The Mormonites,’” 355.
17. [James Gordon Bennett], “Mormon Religion—Clerical Ambition—Western New York—the Mormonites Gone to Ohio,” *Morning Courier and New-York Enquirer*, Sept. 1, 1831, [2].
18. Joseph Smith History, 1838–56, volume A-1, 9, in *JSP*, H1:240–42 (draft 2); Jennings, “Charles Anthon,” 171–87; Bennett, “Read This I Pray Thee,” 178–216.
19. Joseph Smith History, 1838–56, volume A-1, 9, in *JSP*, H1:244 (draft 2); Bennett, Journal, Aug. 8, 1831, in Arrington, “James Gordon Bennett’s 1831 Report on ‘The Mormonites,’” 355; Knight, Reminiscences, 4. **Topic:** Martin Harris’s Consultations with Scholars (**Сэдэв:** Мартин Харрис эрдэмтэдтэй зөвлөлдсөн нь)
20. Joseph Smith History, circa Summer 1832, 5, in *JSP*, H1:15; Исаиа 29:11–12; 2 Нифай 27:15–19.
21. Lucy Mack Smith, History, 1844–45, book 6, [8]; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 9, in *JSP*, H1:244; Joseph Smith III, “Last Testimony of Sister Emma,” *Saints' Herald*, Oct. 1, 1879, 289–90.
22. Joseph Smith History, 1838–56, volume A-1, 9, in *JSP*, H1:244 (draft 2); Isaac Hale, Affidavit, Mar. 20, 1834, in “Mormonism,” *Susquehanna Register, and Northern Pennsylvanian*, May 1, 1834, [1]; Agreement with Isaac Hale, Apr. 6, 1829, in *JSP*, D1:28–34.
23. Briggs, “A Visit to Nauvoo in 1856,” 454; see also Edmund C. Briggs to Joseph Smith, June 4, 1884, *Saints' Herald*, June 21, 1884, 396.
24. Joseph Smith III, “Last Testimony of Sister Emma,” *Saints' Herald*, Oct. 1, 1879, 289–90; Briggs, “A Visit to Nauvoo in 1856,” 454.
25. Joseph Smith History, 1838–56, volume A-1, 9, in *JSP*, H1:244 (draft 2); Isaac Hale, Affidavit, Mar. 20, 1834, in “Mormonism,” *Susquehanna Register, and Northern Pennsylvanian*, May 1, 1834, [1].
26. Lucy Mack Smith, History, 1844–45, book 6, [8].
27. Lucy Mack Smith, History, 1844–45, book 6, [3]–[5], [8]–[9].
28. Lucy Mack Smith, History, 1844–45, book 6, [9]–[10]; Joseph Smith III, “Last Testimony of Sister Emma,” *Saints' Herald*, Oct. 1, 1879, 289–90.
29. 1829 онд Иосеф, Оливер Каудери хоёрыг орчуулгын ажлаа хийж байхад Эмма Смит тэдэнтэй хамт нэг өрөөнд ажиллаж байсан гэдгээ хожим нь дурсан ярьсан байдаг ба 1828 онд Иосеф, Мартин нарыг орчуулж байхад ч мөн адил хамт байсан байх магадлалтай. (Joseph Smith III, “Last Testimony of Sister Emma,” *Saints' Herald*, Oct. 1, 1879, 290.)
30. William Pilkington, Affidavit, Cache County, UT, Apr. 3, 1934, in William Pilkington, Autobiography and Statements, Church History Library; “One of the Three Witnesses,” *Deseret News*, Dec. 28, 1881, 10.
31. Briggs, “A Visit to Nauvoo in 1856,” 454; Joseph Smith III, “Last Testimony of Sister Emma,” *Saints' Herald*, Oct. 1, 1879, 289–90.
32. Lucy Mack Smith, History, 1844–45, book 6, [10]; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 9, in *JSP*, H1:244; Joseph Smith History, circa Summer 1832, 5, in *JSP*, H1:15; Knight, Reminiscences, 5; and Historical Introduction to Preface to the Book of Mormon, circa Aug. 1829, in *JSP*, D1:92–93-ийг үзнэ үү.
33. Joseph Smith History, 1838–56, volume A-1, 9, in *JSP*, H1:244 (draft 2); Lucy Mack Smith, History, 1844–45, book 6, [10].
34. Lucy Mack Smith, History, 1844–45, book 6, [10]–[11]; book 7, [1].
35. Joseph Smith History, circa Summer 1832, 5, in *JSP*, H1:15.
36. Joseph Smith History, 1838–56, volume A-1, 9–10, in *JSP*, H1:244–46 (draft 2); Lucy Mack Smith, History, 1844–45, book 7, [1]; Knight, Reminiscences, 5.
37. Joseph Smith History, 1838–56, volume A-1, 9–10, in *JSP*, H1:244–46 (draft 2).
38. Lucy Mack Smith, History, 1844–45, book 7, [1]–[2]. **Topic:** Joseph and Emma Hale Smith Family (**Сэдэв:** Иосеф болон Эмма Хэйл Смитийн гэр бүл)
39. Lucy Mack Smith, History, 1844–45, book 7, [1]–[2].
40. Lucy Mack Smith, History, 1844–45, book 7, [2]–[4].
41. Lucy Mack Smith, History, 1844–45, book 7, [5].
42. Lucy Mack Smith, History, 1844–45, book 7, [5]–[7]. **Topic:** Lost Manuscript of the Book of Mormon (**Сэдэв:** Мормоны Номны алдагдсан гар бичмэл)
43. Lucy Mack Smith, History, 1844–45, book 7, [7]. **Topic:** Lucy Mack Smith (**Сэдэв:** Люси Мак Смит)

БИД САЙН МЭДЭЭНЭЭС ХУВААЛЦАХДАА ХЭР АМЖИЛТТАЙ байсан бэ?

Шинээр хөрвүүлэгдсэн болохоор эхнэр бид хоёр хэрхэн номлогч байх талаар сайн мэддэггүй байв. Гэсэн ч бид хоёр сайн мэдээг 100 хүнтэй хуваалцах зорилго тавьсан юм.

Нэвэр Чикунгуво

Зимбабвегийн Сүмийн түүхийн зөвлөгч

Миний эхнэр Эвэржойс бид хоёр Зимбабвегийн зүүн хил дээрх Мутарэ гэдэг жижиг хотынх. Бид хоёр баптисм хүртэж, гишүүний баталгаагаа хүлээн авсныхаа дараа удалгүй номлолын ажил хийнэ гэдэгтээ баяртай байсан. “Талбай нь цагаан аль хэдийн хадахад бэлэн байна” (С ба Г 33:7) гэдгийг уншаад, номлогч байх талаар ихийг мэдээгүй ч бид “хадуураараа хадаж, мөн бүх хүч, оюун, мөн чадлаараа хураах” хэрэгтэй юм байна гэж шийдсэн.

Бид хоёр Мутарэ хотын нэг дүүрэгт шинээр нээгдсэн Дангамбура салбарын гишүүд байв. Тэр үед 1991 онд уг салбар 25 гишүүнтэй байсан. Удалгүй биднийг салбарын номлогчоор дуудав. Бид хоёр манай бүсэд үйлчилж байсан ахмад хос номлогчдоос их зүйл сурч авсан юм. Тэд бид хоёрт өөрсдөдөө зорилго тавихыг санал болгосон.

Бид хүн бүртэй сайн мэдээ хуваалцахыг хүсэж байсан учраас салбарын номлогч байх эхний жилдээ 100 хүнтэй хуваалцах зорилго тавив. Бид туршлагагүй байсан байх. Гэхдээ энэ нь бидэнд хүрч болох зорилго мэт санагдаж байсан. Их Эзэн бидэнд тусална гэдэгт бид найдаж байлаа.

Сүмийн цуглаанууд дээр бид дуулал дуулж байгаад, хөгжмийн нуугдмал авьяастай байснаа олж мэдэж билээ.

Бид авьяасаа ашиглахаар шийдэн, сайн мэдээг сонирхож байгаа гэдгээ мэдэгдсэн хүмүүстэй заахаар уулзах

үедээ тэдэнд зориулан, заримдаа тэдэнтэй хамт дуулдаг болж эхэлсэн. Биднийг ариун дууллыг дуулах үед Сүнс бидэнтэй хамт байж, бидний зааж байсан хүмүүсийн зүрх сэтгэлийг хөндсөн юм. Бас сэргээгдсэн сайн мэдээний захиас ч тэгж нөлөөлсөн. Бид бүх хүнийг хожмын үеийн гэгээнтэн эсэхээс нь үл хамааран салбарынхаа найрал дуунд элсэхийг урьсан бөгөөд олон хүн найрал дуунд элссэн. Илүү олон хүн сайн мэдээний талаар мэдэж авч,

олон нь баптисмын ус руу орсон юм.

Бид номлолд үргэлжлүүлэн хичээж зүтгэх үедээ Сүмд нэгдсэн гэр бүлүүдийн төлөө мацаг барин, залбирч байсан. Орон нутгийн маань бусад хүн эдгээр гэр бүлийн зөв шударга жишээг харж байгааг бид мэдэрч байв. Бид гэр бүлүүдэд заахыг хүссэн илүү олон урилга хүлээн авсан бөгөөд бидний заадаг хүмүүсийн дунд хойшид гишүүн болохуйц хүмүүс олон байв.

Сайн мэдээнээс суралцаж, үүний дагуу амьдарснаар шинээр баптисм хүртсэн хосууд илүү ойр дотно мөн илүү хайраар дүүрэн болдог. Эцэг эхчүүд сайн мэдээний соёл уламжлалтай нийцэхгүй уламжлалаа орхиж



Нэвэр, Эвэржойс Чикунгуво хоёр



чадаж байв. Тэд архи, тамхинаас холдож, хүүхдүүдэдээ зөв зарчим зааж байсан. Өнгөрсөн үедээ дэлхийн зүйлсэд дэндүү их автсан байсан олон хүн одоо Сүмд дуудлага хүлээн авч чаддаг болсон. Тэд салбартаа *болон* орон нутагтаа адислал болсон юм. Их Эзэний мутар тэдний амьдралд хүчит өөрчлөлтийг авчирсан.

Тэр үед Мутарэд асар их хавчлага гарч байсан ч энэ нь Сүмийн өсөлтийг зогсоогоогүй билээ. Эсэргүүцэл нэмэгдэхийн хэрээр Сүмийн тухай ойлгож мэдэхийг хүссэн хүмүүсийн тоо нэмэгдэж байгаа мэт санагдсан. Жишээлбэл, төрд цэргийн алба хааж байсан эрчүүд Сүмийг буруутгахаар зүс буруулан ирээд, Сүнсээр

нөлөөлөгдөж байсан. Хожим нь олон нь баптисм хүртэж мөн санваарт томилогдсон юм.

Их Эзэний тусламжтайгаар бид анх тавьсан зорилгоосоо илүү олон хүнтэй сайн мэдээг хуваалцсан. Бид бусдад хүрч хандах арга зам хайхад бэлэн байсан учраас орон нутагтаа олон хүний амьдралд хүчит өөрчлөлт гарахыг нүдээр үзэх боломжтой байсан юм. ■

Хянагчийн тэмдэглэл: Дангамвура салбар хурдацтай өссөн учраас удалгүй Сүмийн байр баригдсан. Номлолын хичээл зүтгэл нэмэлт бүсүүдээр тархаж, 1995 онд Мутарэ нь найман хэсэгтэй дүүрэг болон зохион байгуулагджээ.





Ахлагч Хорхэ
Ф.Зэбаллос
Далын ахлагч

Сүнслэг өдөөлтөд мэдрэг байцгаая

*Газар хөдлөлт, догшин салхи, дүрэлзэн асах түймрээс
илүү хүч гэж байдаг. Гэхдээ энэ нь чимээгүй, намуухан бөгөөд хэрвээ
бид үүгээр удирдуулахыг хүсвэл үүнд анхаарал тавих ёстой.*

2010 оны 2-р сарын 27-ны шөнийн 3 цаг 34 минутад Чили улсын ихэнх хэсэгт 8.8 баллын хүчтэй газар хөдлөлт болж, сая сая хүнд айдас, түгшүүр, сэтгэлийн зовлон авчирсан юм.

Хэд хоногийн дараа би энэ газар хөдлөлтийн төвд ойрхон байдаг гадасны чуулганыг удирдахаар томилогдов. Газар хөдлөлт ба доргилтын дараах түлхэлт чуулганд оролцох хүмүүсийн оролцоонд нөлөөлөх байх гэж би бодож билээ. Чуулганы хуралдаан болгоны оролцогчдын тоо өмнөх чуулгануудын оролцогчдын тооноос их байсныг хараад би их гайхсан.

Уг газар хөдлөлт гадасны гишүүдэд Бурханд ойр байх, Хүндэтгэлийн өдрийг ариун байлгах, цуглаандаа оролцдог байх зэрэг нь хэчнээн чухал болохыг түр ч болов сануулсан ажээ. Түүнээс хойш хэдэн долоо хоногийн дараа би гадасны ерөнхийлөгч рүү утасдсан юм. Би Сүмийн цуглаанд оролцогчдын тоо өндөр хэвээр байгаа эсэхийг асуув. Доргилтын дараах түлхэлтийн хүч буурсны дараа Сүмд ирсэн хүмүүсийн тоо буурсан гэж тэр хариулсан.

2001 оны 9-р сард АНУ-ын Нью-Йорк хотод Ворлд трэйд центр (Дэлхийн худалдааны төв) устгагдсан гунигт үйл явдлын дараа ийм байдал давтагдсан юм. Мянга мянган хүн өөрсдөдөө хэрэгтэй байсан оюун санааны амар амгалан болон тайвшралыг эрэлхийлэн өөр өөрсдийн харьяалагддаг сүм рүүгээ явж байсан. Гэхдээ цаг хугацаа өнгөрөх тусам энэ эрэл хайгуул

багасаж, бүх зүйл хэвийн байдалд эргэж орсон. Итгэл, гэрчлэл, байнгын хөрвөлтийг хөгжүүлдэг зүйл бол газар хөдлөлт, шуурга, байгалийн эсвэл хүний үүсгэсэн гамшиг, зовлон биш юм.

Елиа болон намуун, зөөлөн дуу хоолой

Бошиглогч Елиагийн өдрүүдэд Ахаб Израилийн хаан байв. Ахаб Фоеникийн гүнж Иезебелтэй гэрлэжээ. Тэр эмэгтэй израильчуудыг шүтээн шүтэхийг оролцуулан Фоеникийн заншилтай танилцуулсан. Елиа Ахаб хааны өргөөнд олон байдаг Баалын пристүүдийг шалгаасны дараа Иезебел уг бошиглогчийн амийг хөнөөхөөр сүрдүүлсэн бөгөөд Елиа аглаг буйд руу зугтав. (Хаадын дээд 18:4, 13, 19, 21–40; 19:1–4-ийг үзнэ үү.)

Аглаг буйдад Елиа тэнгэр элчээр тэжээлгэсний дараа Хороб уул руу 40 өдөр 40 шөнө явжээ (Хаадын дээд 19:5–8). Их Эзэний үг аглаг буйдад Елиад иржээ. Түүнийг шөнө хоносон агуйгаасаа гарч ир хэмээн хэлсэн байна. Түүнийг уулан дээр Их Эзэний өмнө зогсох үед “асар их хүчтэй салхи” босож, маш хүчтэй салхилснаас хад болон уулсыг цуулан буталсан “хэдий ч салхин дотор Их Эзэн байсангүй.” Тэгээд газар хөдөлсөн боловч “газар хөдлөлтийн дотор Их Эзэн байсангүй.” Тэгтэл гал гарсан боловч “Их Эзэн гал дотор байсангүй” (Хаадын дээд 19:11–12). Шуурга, газар хөдлөлт мөн гал нь догшин ширүүн байсан хэдий ч эдгээр нь Их Эзэний бошиглогчид хандсан дуу хоолойн илрэл байгаагүй юм.

Байгалийн эдгээр хүчтэй үзэгдлийн дараа “намуун хүнгэнэх дуу” Елиад ирж, тэр түүнийг сонсов (Хаадын дээд 19:12–13). Их Эзэний тайвшруулам зөөлөн дуу хоолой Сири, Израилийн дараагийн хаанаар хэн хэнийг сонгохыг мөн өөрийг нь залгамжлах бошиглогчоор Елишаг сонгох ёстойг түүнд хэлжээ.

Дуу хоолойг олж сонсох нь

Елиад амьдралын болон тохинууллынх нь хүнд хэцүү цагт юу хийхийг нь хэлж өгсөн тэрхүү дуу хоолой Бурханы хүслийн дагуу хийхийг чин сэтгэлээсээ хүсдэг Түүний хүүхэд бүрд одоо ч боломжтой юм. Гэхдээ харанхуй, төөрөлдөм замаар явахад биднийг урьдаг чанга, дэлхийн дуу хоолойнуудын дунд бидэнд юу хийх, юу хэлэхийг, Бурханы биднийг хэн болоосой хэмээн хүсэж байгааг хэлж өгдөг намуун, зөөлөн дуу хоолойг бид хаанаас олж сонсож чадах вэ?

Нифай: “Христийн үгэн дээр найрла, учир нь болгоогтун, Христийн үгс та нарын хийвэл зохих бүх зүйлийг та нарт хэлэх болно” (2 Нифай 32:3) гэж бидэнд зөвлөсөн.

Бид дээр нь найрлаж болох Христийн үгийг хаанаас олж чадах вэ? Бид энэ үеийн оршин суугч бидэнд зориулан цэвэр ариун байдалд бичигдэн мөн хадгалагдсан судруудад, ялангуяа Мормоны Номонд хандаж болно. Бид түүнчлэн Тэнгэрлэг Эцэгийн болон бидний Аврагч Есүс Христийн хүслийг өнөөдөр бидэнд хэлж өгдөг өнөө үеийн бошиглогчдын үгсийг сонсдог.

Биднийг шинэ бөгөөд ярвигтай бэрхшээлтэй тулгарах үед амьд бошиглогчдын үгс биднийг удирддаг. Жишээлбэл, сүүлийн жилүүдэд дэлхийнхэн болон тэдний үзэл бодол гэрлэлт болон гэр бүлийг бүрмөсөн өөрчлөхийг эрэлхийлж байгаа хэдий ч бошиглогчдын үгс гэр бүлийн ариун нандин байдлыг зоригтой, хайраар дүүрэн, баттай онцлон, “эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурхан заяасан бөгөөд гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдаг”¹ хэмээн тунхагласан билээ.



Түүнчлэн өнөөгийн бошиглогч, төлөөлөгчид гэртээ болон Сүм дээр Хүндэтгэлийн өдрийг сахих нь чухал болохыг мөн гэр бүлийн түүх, ариун сүмийн ажлаар дамжуулан өвөг дээдсээ аврах ажлын ач холбогдлыг онцолдог. Ерөнхий чуулган болгон дээр тэд Сүмийн төлөө сүнслэг удирдамжийг нэмж хэлж өгдөг.

Ариун Сүнс таныг удирдана

Нифай “Хэрэв та нар уг замд орох, мөн Ариун Сүнсийг хүлээн авбаас, энэ нь та нарын хийвэл зохих тэр бүх зүйлийг та нарт үзүүлэх болно” (2 Нифай 32:5) хэмээн заасан. Тийн Нифай, Христийн үгсийг эрэлхийлэхийн чухлыг бататгаад, Бурхан Тэргүүтэний гурав дахь гишүүн болох Ариун Сүнстэй шууд бөгөөд хувийн харилцаатай байх ёстой талаар бидэнд зааварчилдаг.

Нифай юун тухай ярьж байгаагаа сайн мэдэж байсан. 30, 40 жилийн өмнө түүний гэр бүл цөлд амьдарч, амлагдсан нутаг тийш аваачих усан онгоцыг барьж байх үед Нифай тэнгэр элчийн дуу хоолойг сонссоныхоо дараа ах нарыгаа алдас үйлдсэнийх нь төлөө зэмлэсэн.



Нифай тэдэнд “Та нар алдсыг үйлдэхдээ шаламгай боловч Их Эзэн Бурханаа санахдаа удаан юм. Та нар тэнгэр элчийг харсан, мөн тэрээр та нарт ярьсан; тийм ээ, та нар түүний дуу хоолойг цагаас цагт сонссон; мөн тэрээр намуухан зөөлөн дуугаар та нарт ярьсан, гэвч та нар мэдрэхээс өнгөрсөн, иймээс та нар түүний үгсийг мэдэрч чадсангүй; иймийн тул, дэлхий салж хуваагдах мэт сэгсрэх аянгын дуугаар тэрээр та нарт ярьсан билээ” (1 Нифай 17:45) хэмээн хэлжээ.

Сүнслэг өдөөлтөд мэдрэг байцгаая

Бурхан Өөрийн хүүхдүүдтэй харьцахдаа ихэвчлэн Ариун Сүнсээр дамжуулан харьцдаг бөгөөд Ариун Сүнс бидэнтэй оюун бодол, зүрх сэтгэлд маань нэвтэрдэг хоолойгоор “бүх зүйлийг нэвт мөн цоо хатган шивнэдэг, намуухан аниргүй дуу хоолой”-гоор харьцдаг (С ба Г 85:6). Тэрхүү намуухан дуу хоолойг сонсож мөн хэн нэгнийг аянгын дуугаар бидэнтэй ярих ёстой болтол нь хүлээхгүй байцгаая! Елиа Их Эзэний дуу хоолой салхи шуурга, газар хөдлөлт болон галд байдаггүй болохыг ойлгож авсныг санаарай. Их Эзэн

түүнтэй Ариун Сүнсээр дамжуулан намуун зөөлөн дуу хоолойгоор ярьсан.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч Бонд К.Пакэр (1924–2015) “Сүнсний дуу хоолой яриагаар биш, харин *мэдрэмжээр* ирдэг. Та нар миний ойлгож авсны адилаар, сонсогдохын оронд *мэдрэгддэг* дуу хоолойг *сонсож* сурах болно. . . .

. . . Энэ нь зүрх сэтгэлд чинь бодол эсвэл мэдрэмж төрөх мэт оюун ухаанд чинь орж ирдэг сүнслэг дуу хоолой билээ.”²

Бид чихээрээ *сонсохоос* илүүтэй оюун ухаан, зүрх сэтгэлдээ Ариун Сүнсний үгийг *мэдрдэг*. Тэдгээр сүнслэг өдөөлтөд мэдрэг байцгаая! Бид бошиглогчдын үгийг хүлээн авахын тулд зүрх сэтгэл, оюунаа нээх болтугай. Бид намуун зөөлөн дуу хоолойгоороо дамжуулан бидэнд үргэлжлүүлэн заахыг Ариун Сүнсэнд зөвшөөрөх болтугай. Аврагч Өөрийг нь одсоны дараа шавь нарт нь илгээгдэх Ариун Сүнсний талаар заахдаа “Харин Туслагч буюу Миний нэрээр Эцэгийн минь илгээх Ариун Сүнс та нарт бүгдийг заах бөгөөд . . . бүгдийг сануулах болно” Иохан 14:26 хэмээн хэлжээ.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн итгэлтэй гишүүн болгон Ариун Сүнсээр дамжуулан тэнгэрээс хувийн удирдамж, сүнслэг өдөөлт, хувийн илчлэлийг хүлээн авах эрхтэй төдийгүй ийм адислал хүртсэн.

Ерөнхийлөгч Томас С.Монсон (1927–2018): “Тэрхүү намуун зөөлөн дуу хоолойн нөлөөнд ор. Эрх мэдэл бүхий хэн нэгэн таныг гишүүнээр батлагдахад толгой дээр чинь гараа тавин, ‘Ариун Сүнсийг хүлээн авна уу’ хэмээн хэлснийг санаарай. Үнэнийг гэрчилдэг энэ онцгой дуу хоолойнд зүрх сэтгэлээ, бүр оюунаа нээгээрэй. Бошиглогч Исаагийн амласнаар “Энэ бол зам. Үүтээр алхагтун гэсэн үгийг та нарын чих сонсоно” [Исаиа 30:21].”³ ■

ЭШЛЭЛҮҮД

1. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Liahona*, 2017 оны 11-р сар, 145.
2. Бонд К.Пакэр, “Залуучуудад зөвлөх нь,” 2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 18–21-ийг үзнэ үү.
3. Томас С.Монсон, “Итгэ, дуулгавартай бай, тэвч” *Liahona*, 2012 оны 5-р сар, 129

УРАГШ ЗҮТГЭХ ИТГЭЛ

*Их Эзэн Есүс Христийн талаарх гэрчлэлээрээ зэмсэглэсэн Вилли гар тэрэгний
бүлгийн гишүүд тулгарсан бэрхшээл, өлсгөлөнгөө даван туулж, урагш зүтгэсэн.*



**Ахлагч
Роналд
А.Расбанд**

Арван хоёр
Төлөөлөгчийн
Чуулга

Миний хуваалцахыг хүсэж байгаа түүх Английн зүлэг нь халиурсан гүвээт хөдөө нутаг болох Глүсестэрт 1825 онд төрсөн Жон Бэннэтт Хокинсоор эхэлдэг. Тэр 1849 онд Сүмийн гишүүн болж баптисм хүртсэн бөгөөд тэр жилдээ хожмын үеийн гэгээнтнүүдийн бүлэгтэй хамт *Хэнри Вэр* нэртэй усан онгоцоор Америкийг зорин гарчээ. Тэр 1852 оны 8-р сард Ютад ирсэн бөгөөд Ютагийн суурьшлын эхний өдрүүдийн анхны мужаануудын нэг байжээ.

Түүний ирээдүйн эхнэр Сара Элизабет Мүлтон бас Английн хөдөө нутгаас ирсэн байв. Ирчестэр нь Лондон хотын хойд хэсгээс 105 км-ын зайтай, Бирмингемээс зүүн тийш мөн адил зайтай Ривэр Ненэгийн ойролцоох жижиг тосгон юм. Сара Элизабет тэнд 1837 онд Томас Мүлтон, Эстер Марш хоёрын охин болж төржээ. Сара Элизабетын ээж нь түүнийг хоёрхон настай байхад насан өөд болсон бөгөөд аав нь 1840 онд Сара Дэнтонтэй гэрлэсэн.

1837 оны 6-р сард Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Хибэр С.Кимбалл (1801–1868) болон Сүмийн бусад удирдагч Англи улсад номлолын ажил хийж байв. Эдгээр номлогчоор заалгасан олон хөрвөгчийн дунд Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Парлей П.Праттын (1807–1857) бичсэн *Сэрэмжлүүлгийн дуу хоолой* (*A Voice of Warning*) товхимлыг Мүлтоны гэр бүлд өгсөн гэр бүл байв. Үүнийг уншаад Томас, Сара хоёр хөрвүүлэгдэн, 1841 оны 12-р сарын 29-нд баптисм хүртжээ. Тэр үед тэдний гэр бүл дөрвөн настай Сара Элизабет, долоон сартай Мари Анн гэдэг хоёр хүүхэдтэй байв.

Европ дахь хөрвөгчдийн зүрх сэтгэлд цугларалтын сүнс хүчтэй байв. Тэд гэгээнтнүүдийн ихэнхтэй хамт байж болохын тулд Америк руу цагаачлахыг хүсэж байлаа. Бусад олон хүний адил, Мүлтоны гэр бүлийнхэнд энэхүү хүсэл мөрөөдлөө биелүүлэх хангалттай мөнгө байсангүй. Гэвч тэд шийдмэг байсан бөгөөд жимсний шилэнд мөнгөө хадгалж эхэлжээ.

Тасралтгүй цагаачлалын сан

1849 онд ерөнхийлөгч Бригам Янг (1801–1877) Америк руу аюулгүй ирэхэд нь Сүмийн гишүүдэд туслахаар Тасралтгүй цагаачлалын санг үүсгэжээ. Энэ сангийн мөнгөн тусламжаар хамгийн анх аялсан хүмүүсийн бүлэг морин тэргээр аялсан бөгөөд энэ маягаар аялах нь удаан бас өртөг ихтэй байв. Тасралтгүй цагаачлалын сангийн тусламж авсан ч гэсэн энэ аяны зардлыг гаргаж чадах хүмүүс цөөхөн байлаа. Сүмийн удирдагчид гар тэрэг ашиглах талаар сонирхож мөн гар тэргээр аялах нь илүү хурдан бас хямдхан болохыг олж мэджээ.

Зүүн талд: Английн Глүсестэр дэх хөдөө нутгийн өнөөгийн байдал



АНУ-ын баруун Небраскагийн Скоттс Блафф дахь Үндэсний дурсгалт газар

Тэр үед Мүлтоны гэр бүл долоон хүүхэдтэй болсон байсан ба жимсний шилэнд хадгалсан мөнгөн дээрээ Тасралтгүй цагаачлалын сангаас тусламж авч мөн илүү хямд аргаар аяаснаар тэдний цагаачлах хүсэл мөрөөдөл биелэх боломжтой болжээ. Есөн гишүүнтэй гэр бүлийн хувьд аялалдаа бэлтгэхийн тулд болгоомжтой төлөвлөх хэрэгтэй байв. Өөрсдийнхөө худалдаж авах шаардлагатай зүйлсэд зориулан мөнгө хадгалахын тулд тэд бараг жил шахам голдуу арвайн гурил иджээ.

Тэдний явах цаг дөхөхөд Томас эхнэр нь хөл хүндтэй байсан тул уг аяныг хийх тухайд эргэлзэж байв. Гэсэн ч Сара Дэнтон Мүлтон итгэлтэй эмэгтэй байсан бөгөөд эргэж буцалтгүй шийдсэн байв. Тэднийг Англиас явахаас өмнө номлогчдын нэг нь Сарад адислал өгсөн бөгөөд энэ адислалд, хэрвээ тэр Юта руу явах аваас гэр бүлийнхээ нэг ч гишүүнийг алдахгүйгээр Ютад аюулгүй хүрэх болно гэсэн амлалт өгөгджээ. Удахгүй арвуулаа болох гэж байсан гэр бүлд энэ нь маш сайхан зүйлийг амласан адислал байлаа.

Уг гэр бүлийнхэн 1856 онд Англи улсын Ливерпүүлээс *Форнтон* нэртэй усан онгоцоор гарсан бөгөөд далайд гарснаас хойш гуравхан өдрийн дараа бяцхан хүүтээ төрүүлжээ. *Форнтон* усан онгоцыг Дани, Швед, Английн 764 гэгээнтнийг зөөхөөр хөлсөлсөн байв. Тэднийг Жэймс Грэй Вилли гэдэг нэртэй номлогч удирдаж байлаа.

Зургаан долоо хоногийн дараа *Форнтон* Нью-Йорк хотын усан онгоцны боомтод орж иржээ. Тэгээд Мүлтоны гэр бүлийнхэн баруун зүгийг зүглэн, холын аялал хийхээр галт тэргэнд суужээ. Тэд Айова мужийн Айова Ситид 1856 оны 6-р сард ирсэн бөгөөд тэндээс гар тэрэгний бүлгүүдийн аян эхэлж байв. Тэднийг тэнд очсоноос гуравхан өдрийн дараа ахмад Эдвард

Банкэрын гар тэрэгний бүлэг Айова Ситигээс гарсан бөгөөд бэлэн байсан гар тэрэгний олныг нь авч явав.

Гар тэрэгний бэрхшээл

Вилли бараг хоёр долоо хоног орчмын дараа Эдвард Мартинаар удирдуулсан гэгээнтнүүдийн өөр нэг гар тэрэгний бүлэгт нэгдэв. Эхний гурван гар тэрэгний бүлгийг шаардлагатай зүйлсээр нь хангаж явуулахаар шаргуу ажилласан Айова Сити дэх Сүмийн төлөөлөгчид олуулаа гэнэт оройтож ирсэн хүмүүсийг хангахаар сандралдан ажиллаж эхлэв. Эдгээр гэгээнтнийг аянаа цааш үргэлжлүүлэхээс өмнө тэд 250 гар тэрэг хийх хэрэгтэй байв.

Хөдөлмөрийн чадвартай эр хүн бүрийг гар тэрэг хийх ажилд оруулж, эмэгтэйчүүд нь аянд зориулан олон арван майхан оёв. Урьд өмнө гар тэрэг хийж үзээгүй эдгээр хүний олонх нь тодорхой зааврыг дагаагүйгээс болж олон янзын хэмжээ, даац бүхий гар тэрэгнүүдийг хийсэн нь хожим тэдэнд хүндрэл учруулсан юм. Шаардлагатай тооны гар тэрэг хэрэгтэй байсны улмаас тэд шинэ, ногоон модоор барих болж мөн зарим тохиолдолд дугуйг нь шир, тугалга ашиглан хийж байв. Гар тэрэг болгонд гэгээнтнүүдийн олонхынх нь хоол хүнс, бүх эд хогшил гэхээр зүйлийг ачдаг байжээ.

Мөн гар тэрэг болгонд ихэнхдээ 400–500 фунт буюу 180–230 кг-д багтах гурил, ор дэр, хоол ундны хэрэгсэл болон хувцас хунар ачиж байв. Гар тэргэн дээр хүн бүрд 8 кг ачаа ачих зөвшөөрөл өгсөн байжээ.

Томас Мүлтон болон түүний гэр бүлийн гишүүд арвуулаа дахин ахмад Виллигийн удирдлаган доор дөрөв дэх гар тэрэгний бүлэгт хуваарилагдсан байв. Энэ бүлэг 400 гаруй гэгээнтнээс бүрдсэн бөгөөд хөгшин хүмүүсийн тоо ердийнхөөс олон байжээ. Тэр оны 9-р



сарын тайланд “404 хүн, 6 тэрэг, 87 гар тэрэг, 6 шар үхэр, 32 үхэр, 5 луус” гэж жагсаан бичсэн байв.¹

Мүлтоны гэр бүлд бүхээгтэй нэг, бүхээггүй нэг гар тэрэг тус тус ноогджээ. Томас эхнэрийнхээ хамт бүхээгтэй тэргийг чирж байв. Шинээр төрсөн нялх Чарлэс болон түүний эгч Лиззи (София Элизабет) энэ гар тэргэнд суудаг байжээ. Лотти (Шарлотт) уруудаж явах үед л гар тэргэнд сууж болдог байв. Найман настай Жэймс Хибэрийг алдчихгүйн тулд олсоор бүслээд, тэрэгнээс уян ард нь алхуулдаг байсан байна. Нөгөө хүнд гар тэргийг нь хоёр том эгч нь болох Сара Элизабет (19), Мари Анн (15) хоёр болон хоёр эрэгтэй дүү Виллиам (12) болон Жозеф (10) нар чирдэг байжээ.

1856 оны 7-р сард Мүлтоны гэр бүлийнхэн Айова Ситигээс гарч, баруун зүгийг чиглэсэн 1300 милийн (2090 км) аянаа эхлэв. Тэд 26 өдөр аялсныхаа дараа Небраска мужийн Винтер Квортэрст (Флоренс) иржээ. Винтер Квортэрс Солт Лэйк Сити хоёрын хооронд ямар ч том хот байхгүй учраас заншсан ёсоор тэд тэнд хэдэн өдрийг өнгөрөөж, гар тэргээ засан, хангамжаа нөөцөлж авав.

Виллигийн бүлгийнхнийг Винтер Квортэрсээс гарахад бэлэн болох үед улирал дуусах дөхөж байсан учраас цааш явах уу эсвэл хавар болтол эндээ үлдэх үү гэдгийн талаар шийдэхээр зөвлөл хуралдсан байна. Уг замаар өмнө нь явж байсан зарим хүн ингэж оройтож аялах нь их аюултай гэдгийг сэрэмжлүүлж байв. Гэхдээ ахмад Вилли болон бүлгийн олон гишүүн Флоренсэд өвөлжих байр байхгүй байсан болохоор цааш явах хэрэгтэй гэж үзжээ.

Нөөцийн хомсдол

Виллигийн бүлгийн гишүүд 8-р сарын 18-нд аяллаа хангалттай нөөцгүйгээр эхэлсэн бөгөөд хоол хүнсээ Форт Ламари (одоогийн Вайоминг мужийн Ламаригийн

хойд хэсэг) дээрээс нөөцөлж чадна гэж бодож байв. Өөрсдийн авсан сэрэмжлүүлгийн улмаас тэд тэрэг болгонд нэмэлт 45 кг гурил хийсэн бөгөөд Солт Лэйк Ситигээс илгээх хангамжийн тэрэгтэй тааралдана гэж бодож байжээ. Гэтэл хангамжийн тэрэгний жолооч нар аян замыг туулан ирж байгаа цагаачид одоо байхгүй гэж бодоод, Виллигийн бүлгийг тэдэн дээр очихоос өмнө 9-р сарын сүүлээр Солт Лэйк Сити рүү буцсан байв.

Флоренсэд байхдаа Мүлтоны гэр бүлийнхэн 10 хүнтэй тэдний гэрийн ачаа дэндүү хүнд байсан учраас нэг хайрцагтай нөөцөө ардаа орхих нь зөв гэж боджээ. Тэр үед тэд Ливерпүүлд нэг ачаа, усан онгоцон дээр хайрцагтай хувцас, Нью-Йорк хотод авдартай хувцас болон Айова Ситид хувийн ихэнх зүйлээ хийсэн авдраа орхичихоод байв. Аян замын туршид ч тэд өөрсдийн ачааг хөнгөлөх арга замыг хайж байв.

Мүлтоны гэр бүлийнхэн болон тэдгээр гар тэрэгний бүлгийн гайхамшигтай эрэгтэй, эмэгтэйчүүдийн өдөр тутамд тохиолдож байсан зовлонг өнөөгийн амьдралын таатай орчныг таашаадаг хүмүүст ойлгоход хэцүү байж болох юм. Бид цэврүүтсэн гар хөл, хөндүүр бие, тоос шороо, шавар шавхай, наранд түлэгдэх, ялаа шумуул, хошууран давхих зэрлэг үхэр сүрэг, замд дайралдах индианчууд зэргийг төсөөлж чадах уу? Бид гол гатлахад, ялангуяа хурдтай урсаж байгаа гүнзгий голоор гар тэрэгтэй хөндлөн гатлах үед элс болон хальтрах хад чулуу ямар хэцүү болохыг төсөөлж чадах уу? Хангалттай хоол идээгүйгээр ямар их ядардгийг бид ойлгож чадах уу?

Аян замдаа Мүлтоны хүүхдүүд ээжтэйгээ хамт өөрсдийн хурдан багасаж буй нөөцөнд нэмэр болгохын тулд зэрлэг буудайг зулгааж авахаар тал руу явдаг байжээ. Нэг хэсэг уг гэр бүлийнхэн бүхэл өдрийн туршид 3 хүний дунд нэг алим, нэг арвайн талх хувааж идэж байв.



АНУ-ын Вайоминг мужийн Мартинь агуйн ойролцоох Свийтвотэр гол

9-р сарын 12-ны үдэш Британи улсаас буцаж ирж байгаа номлогчид тэдний буудал дээр ирэв. Тэднийг эхнэрийн маань элэнц өвөө болох Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Франклин Д.Ричардс (1821–1899) удирдаж байжээ. Ахлагч Ричардс бусад хүний хамт уг гар тэрэгний бүлгийн бэрхшээлийг хараад, Солт Лэйк хөндий рүү яаралтай явж, аль болох хурдан тусламж илгээхээ амлажээ.

9-р сарын 30-нд Виллигийн бүлгийнхэн Солт Лэйк Ситигээс зүүн тийш 400 милийн (645 км) зайд байдаг Вайомингийн Форт Ламарид хүрэв.

10-р сарын эхэн болж, өвөл эхэлж байсан бөгөөд уг бүлгийнхэн цааш урагшлахаар оролдох явцад бэрхшээл нь улам ихсэж байлаа. Нөөц хангамж маш бага байсан болохоор ахмад Вилли гурилаа эрэгтэйчүүдэд 15 унц буюу 425 гр, эмэгтэйчүүдэд 13 унц, хүүхдүүдэд 9, нялх хүүхдүүдэд 5 унцаар хуваарилахаас аргагүйд хүрэв. Тэд удалгүй ширүүн салхи, будрах цастай тулгарах гэж байв. 10-р сарын 20-ны өглөө гэхэд 10 см гүнзгий цас орсон байсан бөгөөд майхан болон тэрэгний бүхээгнүүд цасанд дарагдан нурсан байлаа. Тэр шуурганы өмнөх шөнө уг бүлгийн таван гишүүн бас ачааны хэд хэдэн мал хүйтнээс мөн өлсгөлөнгөөс болж нас барсан байсан бөгөөд дараагийн гурван өдөрт таван гишүүн нас барав. Эмэгтэйчүүд болон хүүхэд, өвчтэй хүмүүсээ эхэлж тэжээн, олон хүч чадалтай эр ямар ч хоолгүй явахаас өөр аргагүй болж байжээ.

Халамжийн бүлгүүд илгээгдэв

Свийтвотэр голын Роки Рижээс доош 3 км-ийн зайтай газар уг бүлгийнхэн буудаллаж, даарч өлсөн, хүнд хэцүү нөхцөлд шуурга өнгөрөхийг хүлээж байлаа.

Франклин Д.Ричардсын бүлгийнхэн Солт Лэйк Ситид

хүрээд, тэр даруй ерөнхийлөгч Янгад уг цагаачдад учирсан хүндрэл бэрхшээлийн талаар мэдээлжээ. Хөндийд байсан гэгээнтнүүд дараа жил хүртэл өөр цагаачид ирэхгүй гэж бодож байсан бөгөөд тэдний нөхцөл байдлын талаарх мэдээ түймэр мэт хурдан тархав.

Хоёр өдрийн дараа буюу 1856 оны 10-р сарын 6-нд Хуучин табернеклд Ерөнхий чуулган болжээ. Индэр дээрээс ерөнхийлөгч Янг тусламж үзүүлэхээр дараа өдөр нь явах эрчүүдийг болон хоол хүнс, хангамж нөөц ачиж явах луус, морины тусламжийг хүсэв.²

Жон Бэннэтт Хокинс тэр өдөр Хуучин табернеклд байсан бөгөөд тусламж хүссэн дуудлагад хариулав. Тэр Солт Лэйк Ситигээс халамжийн бүлгүүд болгон илгээгдсэн зуу зуун хүний нэг байжээ. 10-р сарын 21-ний орой тэдгээр аврагч тэрэг эцэст нь Виллигийн буудалласан газар хүрч ирэв. Тэднийг баяр хөөр, талархлаар дүүрэн, хөлдөж, өлсөж үхэх дөхсөн хүмүүс угтсан байна. Энэ нь миний элэнц өвөө, эмээ болох Жон Бэннэтт Хокинс болон Сара Элизабет Мүлтон хоёрын анхны уулзалт байсан юм.

10-р сарын 22-нд аврагчдын зарим нь бусад гар тэрэгний бүлэгт туслахаар цаашилсан бөгөөд Вилли бүлгийн үлдсэн тэргүүдийг Виллям Х.Кимбалл удирдан, Солт Лэйк Сити рүү чиглэн хөдөлжээ.

Гар тэргийг түрэх чадалгүй ядарсан хүмүүс хувийн эд зүйлээ тэргэн дээр тавиад, хажууд нь алхаж байв. Алхаж чадахгүй хүмүүс тэргэн дээрээ сууж байсан. Тэднийг Роки Риж дээр очих үед ахиад цасан шуурга бууж ирэв. Тэд хадан уулын хяраар өгсөх зуураа хөлдөж үхэхгүйн тулд өөрсдийгөө хөнжлөөр ороох хэрэгтэй байв. Тэдний бүлгийн 40 орчим хүн нас барчихаад байлаа.³

Маш хүйтэн байсан учраас уулын хяраар хөндлөн гарахдаа гэгээнтнүүдийн олон нь гар хөл,



нүүрээ хөлдөөсөн байв. Нэг эмэгтэйн нүд хөлдсөнөөс болоод сохор болсон байв.

Мүлтоны гэр бүлийнхэн найман хүүхэдтэйгээ гүнзгий хөр цасан дундуур хоёр гар тэрэг татаж, түрж байгааг төсөөлж байгаа биз дээ. Нэг гар тэргийг нь Томас эхнэртэйгээ хамт түрж байсан ба дээр нь чухал ачаа болох Лотти, Лиззи болон нялх Чарлэс нар байсан бөгөөд бүсэлхийгээрээ олсоор уяулсан бяцхан Жэймс Хибэр ард нь унан тусан чирэгдэн алхаж байв. Нөгөө гар тэргийг нь Сара Элизабет болон нөгөө гурван хүүхэд нь чирч, татаж байжээ. Нэгэн найрсаг, ахмад настай эмэгтэй бяцхан Жэймс Хибэрт хүнд хэцүү байгааг хараад, гар тэрэгний ард алхангаа түүний гараас барин алхав. Энэ найрсаг үйлдэл түүний баруун гарыг аварсан бөгөөд түүний зүүн гар хасах градусын хүйтэнд ил байсан учраас хөлдсөн аж. Тэднийг Солт Лэйк Ситид ирсний дараа түүний зүүн гарын хэд хэдэн хурууг тайрчээ.

11-р сарын 9-ний үдээс өмнө Аравны нэгийн оффисын байрны үүдэнд гар тэрэгтэй зовж зүдэрсэн хүмүүс зогссон байсан бөгөөд энэ нь одоогийн Солт Лэйк Ситигийн Иосеф Смитийн Дурсамжийн байр байрладаг газар юм. Тэдний олных нь хөл, үе мөч хөлдсөн байв. Аян замд нь 69 хүн нас баржээ. Гэхдээ Англид байхдаа авсан адислалаар Мүлтоны гэр бүлийнхэнд өгсөн амлаат биелсэн юм. Томас, Сара Дэнтон Мүлтон хоёр нэг ч хүүхдээ алдаагүй.

Авралаас хайр дурлалд

Уг бүлгийнхний ирэхийг тэсэн ядан хүлээж, халамжлан туслахад бэлэн байсан Солт Лэйкийн зуу зуун иргэн тэднийг тосон авав. Мүлтоны гэр бүлийнхнийг үхлийн аюулаас аврахад тусалсан залуу аврагчдын нэгэнд талархсан талархал Сара Элизабетийн хувьд удалгүй

хайр дурлал болон хувирсан байна.

1856 оны 12-р сарын 5-нд, сайн сайхныг хүссэн хайртай хүмүүсийнхээ дунд Сара Элизабет өөрийг нь аварсан хүн болох Жон Бэннэтт Хокинстой гэрлэжээ. Тэд дараагийн 7-р сард Хишгийн өргөөнд энэ амьдралд болон үүрд мөнх лацдан холбуулжээ. Тэд Солт Лэйк Ситид суурьшсан бөгөөд гурван охин, долоон хүүтээр адислагдав. Охидын нэг нь болох Эстер Эмили манай өвөө Чарлэс Расбандтай 1891 онд гэрлэсэн юм.

7-р сарын 24-нд бид Анхдагчдын өдрийг тэмдэглэдэг бөгөөд Солт Лэйкийн хөндий болон АНУ-ын баруун хэсгийн нийгмийг барьж босгохын тулд бүхнээ зориулсан бусад олон анхдагчийн төлөө баяр талархлаа илэрхийлдэг. Бид бас бусдын дагах сайн мэдээний замыг бадруулсан, бадруулж байгаа дэлхий даяарх хожмын үеийн гэгээнтэн анхдагчдаа талархлаа илэрхийлж байна.

Тэднийг юу хөдөлгөсөн бэ? Тэднийг юу урагшлуулсан бэ? Их Эзэн Есүс Христийн талаарх гэрчлэл тэднийг хөдөлгөж, урагшлуулсан. Би анхдагчдын зээнцэр хүүгийн хувьд тэдний туулсан зовлон бэрхшээл дэмий өнгөрөөгүй гэдгийг гэрчилж байна. Тэдний мэдэрч байсан зүйлийг би мэдэрдэг. Тэдний мэдэж байсан зүйлийг би мэддэг бөгөөд үүний талаар гэрчилж байна. ■

2007 оны 7-р сарын 24-нд Солт Лэйк Сити табернеклд Анхдагчдын өдрийн өглөөний үйлчлэл дээр өгсөн захиасаас эш татав.

ЭШЛЭЛҮҮД

1. F.D. Richards and Daniel Spencer, "Smith, Marilyn Austin, *Faithful Stewards—the Life of James Gray Willie and Elizabeth Ann Pettit*, 95–120," history.lds.org.
2. Brigham Young, "Remarks," *Deseret News*, Oct. 15, 1856, 252-ыг үзнэ үү; мөн түүнчлэн LeRoy R. Hafen and Ann W. Hafen, *Handcarts to Zion* (1981), 120–121-ийг үзнэ үү.
3. Форт Ламарид хүрэхээс өмнө уг бүлгийн 19 хүн нас барснаас долоо нь далайн усан онгоцонд, дөрөв нь Айова Ситид нас баржээ. Форт Ламари болон өвлийн эхэн сар хүртэл ахиад 19 хүн нас барсан ба ихэнх нь аврагч бүлгийнхнийг ирэхийн өмнөх өдрүүдэд нас баржээ.

Ганцаараа байхдаа итгэлээ ХАДГАЛАХ НЬ

Раян В.Солцгивэр
Сүмийн түүхийн алба

Өнөө үед ихэнх хожмын үеийн гэгээнтэн тойрог, салбаруудад уулзалдаж, “мацаг барихаар мөн залбирахаар, мөн өөр хоорондоо бодгалиудынхаа аз жаргалын талаар ярихаар ойр ойрхон цугладаг” (Моронай 6:5). Гэхдээ эдгээр үгийг бичсэн бошиглогч Моронай өөрийн хүмүүсийг устгагдсаны дараа ганцаараа шавийн хувьд үлдсэн тэр үедээ хамгийн дурсамжтай үгээ бичсэн юм.

Сүмийн түүхийн туршид хожмын үеийн гэгээнтнүүд нөхцөл байдлаасаа болж ганцаараа үлдсэн ч итгэлээ хадгалж байв. Зарим нь Моронайн адил ирээдүйн үеийнхний төлөө гэрч, жишээ болж, амьдралынхаа сүүлчийн өдрүүдийг өнгөрөөдөг. Зарим нь өөрсдийнхөө сүсэг бишрэлийг бусадтай хуваалцах боломжтой болох тэр өдрийг хүртэл хүлээдэг.

Энэ өдрийн төлөө олон жил залбирсан нь

1913 онд нэгэн номлогч Вена дахь гэрийнх нь хаалгыг тогших үед Франциска

*Дайн, өвчин тахал эсвэл өөр
нөхцөл байдлаас болж Сүмийн
эдгээр гишүүн улс орондоо цорын
ганиц гишүүн нь байхдаа хэрхэн
итгэлтэй үлдэж чадсан тухай.*

Бродилова Сүмийн түүхэнд гүйцэтгэх үүргээ огт мэдээгүй байжээ. Түүнийг хөрвөгдсөнөөс хойш нэг жилийн дараа Австри-Унгарын хаант улс Дэлхийн 1-р дайнд нэрвэгдэж, номлогчид гэр рүүгээ буцан, олон эрэгтэй гишүүн цэрэгт татагдсаны улмаас Франциска болон цөөн хэдэн эгч үлдэж, өөрсдөө цуглардаг байв.

Энэ нь Францискагийн хувьд олон жилийн турш Сүмийн гишүүдтэй харилцах цорын ганц харилцаа болж байжээ. Дайны дараа Францискагийн нөхөр Францискийг Чехословакийн шинэ засгийн газарт ажиллуулахаар амласан байв. Тэднийг Прага руу нүүсний дараа Франциска тэр улсдаа Сүмийн цорын ганц гишүүн нь байжээ. Хэдэн сарын дараа Франциск нас барж, Франциска хоёр жаахан охин Францэс, Жэйн хоёроо тэжээхээр ганцаараа хоцров.

Франциска хоёр охиндоо сайн мэдээг өөрөө заасан юм. Францэс “Би Сүмд өссөн. Сүм маань гэр орон маань байсан!” хэмээн дурсан ярьжээ.¹ Франциска Австри дахь Сүмийн



Франциска Бродилова дэлхийн 1-р дайн эхлэхээс нэг жилийн өмнө 1913 онд Вена дахь Сүмд элссэн бөгөөд 1929 он хүртэл Сүмийн бусад гишүүнтэй холбоо харилцаагүй байв.

1929 онд ахлагч Жон А.Видцеу сайн мэдээг номлохын төлөө Чехословакийг онцгойлон адислах үед Франциска (хоёулаа дунд талын эгнээнд) тэнд байжээ.

гишүүдэд захидал бичиж, Чехословак руу номлогч илгээхийг хүсжээ. 40 гаруй жилийн өмнө Прагад байсан сүүлчийн ном-

логч шоронд хоригдож, уг хотоос хөөгдсөн болохоор Сүмийн удирдагчид дурамжхан байв. Шинэ засгийн газар байгуулагдсан ч гэсэн Сүмийн удирдагчид тийм ч их зүйл өөрчлөгдөөгүй байх гэж эмээж байлаа.

Франциска шантралгүй үргэлжлүүлэн захиа бичсээр мөн номлол байгуулагдаасай хэмээн залбирсаар байжээ. 1928 онд, Францискаг арван жил ганцаараа байсны эцэст олон жилийн өмнө Прагад номлож байсан номлогч болох 83 настай Томас Бисинжер буцаж иржээ. Уг гэр бүлийн ганцаардал дууссан мэт санагдаж байв. Богино хугацааны дараа ахлагч Бисинжерийн эрүүл мэнд муудсан тул уг нутгаас явахаас өөр аргагүй болов.

Франциска урам нь хугарсан боловч гадаадад байгаа гишүүдэд болон Сүмийн удирдагчдад үргэлжлүүлэн захиа бичихээр шийджээ. Түүний цуцашгүй байдал шагнагдаж, 1929 оны 7-р сарын 24-нд Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жон А.Видцеу (1872–1952) Прагад бүлэг номлогчтой хамт ирсэн юм. Тэр орой Франциска уг бүлгийн хэнтэй хамт Карлстэйн Харшийн ойролцоох толгод руу авирч, тэнд ахлагч Видцеу сайн мэдээг номлохын тулд Чехословакийг онцгойлон адисалж, албан ёсоор номлолыг зохион байгуулав. Хожим Франциска: “Цөөхөн хүн л бидний мэдэрсэн баяр хөөрийг ойлгож чадна. Бид энэ өдрийн төлөө олон жилийн турш залбирч байлаа”² хэмээн бичжээ.

Салбар нь бараг 6 сар орчим Францискагийн гэрт цуглаж байв. Франциска яваандаа Мормоны Номыг чех хэл рүү орчуулахад нь охидодоо тусалсан бөгөөд одоогийн Бүгд Найрамдах Чех Улсад Сүм зохион байгуулагдахад тусалсан юм.

Францискагийн адил олон хожмын үеийн гэгээн-тэн ганцаардмал байдлыг туулсан. Дараах эрэгтэй, эмэгтэйчүүд өөрсдийн төрсөн нутагт сайн мэдээг анх хуваалцаж, Сүмийг зохион байгуулалцсан хүмүүсийн дунд байсан бөгөөд энэ нь бусад хүнд хожим нь гэгээнтнүүдтэй нөхөрлөх боломжийг олгосон юм.



Нөхрөө нас барсны дараа
Франциска хоёр охиноо ганцаараа
өсгөсөн.

Францискагийн
адил хожмын
үеийн олон
гэгээнтэн
ганцаардмал
байдлыг туулсан.
Эдгээр эрэгтэй,
эмэгтэй өөрсдийн
итгэлийн галыг
бадрааж, сайн
мэдээг хуваалцан,
төрсөн нутаг
орондоо Сүмийг
байгуулж байсан
юм.

Удирдах ахлагчийн хувьд Фужия
Нара (хар костюмтай) 1924 онд
Япон дахь номлолыг хаагдсаны
дараа гишүүдтэй холбоотой үлдэх
үүрэг хариуцлагыг хүлээжээ.



Үнэн итгэлийн байнгын бэлэг

Японы номлол 1924 онд хаагдахад олон гишүүнд орхигдсон, төөрөлдсөн мэт санагдаж байв. Япон дахь 160 орчим гишүүнийг удирдах үүрэг уг нутгийн удирдах ахлагч Фужия Нара дээр буусан бөгөөд тэрээр төмөр замын ажил эрхэлж байсан учир энд тэнд тархсан гишүүдтэй уулзах боломжтой байдаг байв. Фужия айлчлан уулзах боломжгүй үедээ *Shuro (Далдуу модны навчи)* гэдэг нэртэй сэтгүүлийг хэвлэн, үүндээ сайн мэдээний захиасуудыг хуваалцаж, цааш цаашдын хэцүү жилүүдэд үлдсэн гэгээнтнүүдээ урамшуулснаар тэдэнтэй холбоотой байдаг байжээ.

Фужия ажлаасаа болж Манчурия руу нүүж, оронд нь орсон удирдах ахлагч 1937 онд гэнэт нас барснаар Японы гишүүдтэй тогтоох холбоо тасарчээ. Фужия “Бид Солт Лэйк Сититэй ямар ч холбоогүй байсан хэдий ч энд Сүм дахин нээгдэнэ гэдэгт итгэлтэй байсан”³ гэж хэлжээ.

Дэлхийн 2-р дайны үеэр Фужия Токио руу буцаж ирээд, тэнд хөршүүдээ номлон мөн долоо хоног тутам Ням гаргийн хичээлийн цуглаануудыг зохион байгуулдаг байв. Дайны дараа Фужия Америкийн армид үйлчилж байсан хожмын үеийн гэгээнтэн болох Эдвард Л.Клиссолдын үлдээсэн, уг орны Сүмийн гишүүдийг өөртэй нь холбоо барихыг хүссэн

бичгийг олжээ. Фужия тэр даруй Эдвардын зочид буудлын өрөөнд очив. Эдвард Токио дахь хожмын үеийн гэгээнтнүүдийн цуглаануудад очихдоо бараг 100 шахам хүн оролцож байгааг хараад их гайхсан байна.

Хожим нь Фужия “Энэ бүхний туршид хамгийн агуу, байнгын бэлэг нь үнэн итгэлийг мэдэж, хүлээн авах явдал байлаа. Энэ нь Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийг болон Ариун Сүнснийг мэдэх гэсэн үг байв”⁴ гэж хэлжээ.

Хавайд Сүмийг байгуулсан нь

Жонатан Х.Напэла эхнэр Китигийнхээ хамт 1851 онд баптисм хүртэхээсээ өмнө Мауи арал дээр бусдын хүндэтгэл хүлээсэн шүүтч байв. Жонатаныг Сүмд нэгдсэнээс болж шүүтчийн суудлаа шилжүүлэхийг шаардсан бөгөөд тэр хавай хэлээр ярьдаг хүмүүсийн дунд Сүмийг өсгөн бэхжүүлэхэд хүчээ зориулав. Жонатан номлогч Жорж К.Каннонд уг хэлийг зааж, Мормоны Номыг орчуулахад туслан, гадаад хэл дээр номлогчдыг сургах хамгийн анхны хөтөлбөрийг бий болгожээ.

Үүний үр дүнд гурван жилийн дотор Хавай үндэстний 3 000 гаруй хүн Сүмд нэгдэв. Жонатан “Энэ бол Бурханы Сүм гэдэг нь бидэнд маш илэрхий байдаг. Энэ арлууд дээр Ариун Сүнсийг хүлээж авч болохын тулд Бурханы ач ивээлээр, Их Эзэн Есүс Христээр дамжуулан хүчтэй итгэлтэй болсон олон хүн бий” гэж бичжээ.⁵

1872 онд Кити Напэла уяман өвчин туссан бөгөөд Молокай дахь уяман өвчтөнүүдийн колони руу нүүх шаардлагатай болов.

Баруун гар талд: Хавай дахь анхны хөрөөгчдийн нэг Жонатан Напэла Мормоны Номыг хавай хэл дээр орчуулахад тусалжээ. Доод талд: Вилхэлм Фридрих (зүүн талаас хоёр дахь), Эмил Хоппэ (ард талын эгнээний голд) хоёр Аргентин дахь анхны баттисмуудад оролцов.



ЖОНАТАН НАПЭЛАГИЙН ЗҮРГИЙГ CHURCH HISTORY LIBRARY AND ARCHIVES-ЫН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ

Гэгээнтнүүдтэй үлдэхийн оронд Жонатан өөрийг нь бас хамт оруулахыг колониос хүсжээ. Тэр эрүүл мэндийн албанд хандан, “Үлдсэн богино хугацаанд нь би эхнэртэйгээ хамт байхыг хүсэж байна” гэж бичсэн байв.⁶ Уг өргөдлийг зөвшөөрсөн бөгөөд Жонатан Молокай дахь салбарын ерөнхийлөгч болов. Жонатан католик шашны прист Эцэг Дамиэнтэй хамтран, тахалд нэрвэгдсэн хүмүүст тохинуулахаар нэгдэн ажиллаж байв. Жонатан колонид байхдаа уяман өвчин тусаж, улмаар нас барсан юм.

“Би Бурханы мутарт зэмсэг нь байгаадаа баяртай байдаг”

Фридрикийн болон Хоппэгийн гэр бүлийнхэн 1920-оод оны эхээр Германаас Аргентин руу нүүхдээ тэндхийн цорын ганц хожмын үеийн гэгээнтнүүд байв. Вилхэлм Фридрих, Эмил Хоппэ хоёр шинэ очсон нутагтаа сайн мэдээг хуваалцахыг оролдож, товхимол тараан мөн цуглаанд ирэхэд бусдыг урьж байв. Вилхэлм



“Тэнгэрлэг Эцэг Сайн мэдээг хүлээж авах чин үнэнч найзуудыг илгээнэ гэдэгт би бүрэн найдаж байна. Яагаад гэвэл би Бурханы мутарт зэмсэг нь байгаадаа баяртай байдаг”⁷ гэж бичжээ.

Гэсэн хэдий ч тэд том бэрхшээлүүдтэй тулгарсан. Гэр бүлүүд хол зайтай амьдардаг байсан бөгөөд хамтдаа цуглахын тулд хоёр цаг явах хэрэгтэй байдаг байв. Эмил Аароны санваарын дикон, Вилхэлм багшийн зэрэгтэй байсан учраас тэд ариун ёслол адислах, санваарын адислал өгөх зэрэг ёслолуудыг гүйцэтгэх боломжгүй байв.

1924 онд Хилдэгард Хоппэ охин төрүүлсэн боловч охин нь хоёр сарын дараа нас баржээ. Хилдэгард гашуудаж, нялх үрийнхээ нэрийг Сүмийн цэдэгт хэрхэн багтааж болох тухай асуусан юм.

*Сүмийн суурийг
тавих тэдний
хичээл зүтгэл
хожим нь бусдад
гэгээнтнүүдтэй
нөхөрлөх
боломжийг
олгожээ.*

**Эдгээр болон дэлхий
даяарх өөр бусад
итгэлтэй гэгээнтний
талаар илүү их мэдээлэл
авахын тулд Gospel
Library аппликэйшний
Church History хэсэг дэх
Country Histories эсвэл
history.lds.org руу орж
үзнэ үү.**

*Филлип болон Аннэлис Ассард
(зүүн талд) хоёр Люсиен, Агате
Аффоуе хоёртой Зааны Ясан
Эрэгт уулзсан ба тэд тэндхийн
цорын ганц гишүүд биш
байсандаа баяртай байв.*



Үүний улмаас Вилхэлм Солт Лэйк Сити дэх Сүмийн удирдагчидтай харилцаж эхэлжээ.

Нэг жил хагасын дараа Буэнос Айрэс дахь өсөн нэмэгдэж байгаа хөрвөгчидтэй уулзуулахаар Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Мэлвин Ж.Баллардыг (1873–1939) бусад хэдэн номлогчтой хамт илгээсэн аж. 1925 оны 12-р сард ахлагч Баллард тэнд очоод, хэд хэдэн хөрвөгчид баптисм хүртээж, салбарыг зохион байгуулав. Христийн мэндэлсний баярын өдөр ахлагч Баллард Өмнөд Америкийг номлолын ажлын төлөө онцгойлон адисалж мөн уг тив дээрх анхны номлолыг зохион байгуулжээ.

Сайн мэдээг Түүний хүмүүст буцаан авчрах нь

Филлип, Аннэлис Ассард хоёр 1980 онд номлогчдыг Германы Келн дахь гэрийнх нь хаалгыг тогших үед өөрсдөдөө сайхан амьдрал босгочихоод байлаа. Тэд тэр даруй сайн мэдээг хүлээн авсан бөгөөд “адислалуудаар цутгагдах” мэт санагдсан байна. Филлип удалгүй сэргээгдсэн сайн

мэдээг хуваалцахаар өөрийн төрсөн нутаг болох Зааны Ясан Эрэг рүү буцаж очих хүчтэй хүслийг мэдэрчээ. Филлип “эхнэртэйгээ хамт олон удаа залбирч, мацаг барьсны дараа 1986 онд гэр бүлийнхээ болон ард түмнийхээ байдлыг сайжруулахын тулд, өөрийн хүлээж авсан зүйлийг тэдэнд өгөхөөр Зааны Ясан Эрэг рүү буцахаар шийдсэн”⁸ гэж дурсан ярьсан.

Германаас явахаасаа өмнө Филлип Сүмийн удирдагчидтай зөвлөлдсөн байв. Зааны Ясан Эрэгт Сүмийн ямар ч байгууллага байхгүй байсан ч тэнд өөр улсад байхдаа Сүмд элссэн хэд хэдэн гишүүн байв. Ассардын гэр бүлийнхэнд тэдний нэрийг өгсөн бөгөөд тэд дараа жилийн туршид тэдний хүн нэг бүрд хичээнгүйлэн захидал бичжээ. Яваандаа, Ассардын гэр бүлийнхэн бусдын итгэлийн очийг асаасан төдийгүй тэдэнд гэртээ Ням гаргийн цуглаануудыг хийж эхлэх зөвшөөрөл өгөгджээ. Цаашдаа тойрог салбарууд үүсэж, 1997 онд Зааны Ясан Эрэг дэх анхны гадас зохион байгуулагджээ. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Frances McOmber, in Ruth McOmber Pratt, “Frantiska Vesela Brodilova,” unpublished manuscript (2009), 18.
2. Františka Brodilová, in Pratt, “Frantiska Vesela Brodilova,” 25.
3. Fujiya Nara, in Lee Benson, “Japanese Member Survives Adversity,” *Church News*, Feb. 17, 1979, 7.
4. Fujiya Nara, in Benson, “Japanese Member Survives Adversity,” 7.
5. Jonathan Napela, in “Foreign Correspondence: Sandwich Islands—Minutes of Conference, Makawao, April 1st, 1852,” *Deseret News*, Nov. 27, 1852, 4.
6. Jonathan Napela, in Fred E. Woods, “A Most Influential Mormon Islander: Jonathan Hawaii Napela,” *The Hawaiian Journal of History*, vol. 42 (2008), 148.
7. Wilhelm Friedrichs, letter, dated Mar. 5, 1924, Argentine Mission Correspondence, Church History Library.
8. Robert L. Mercer, “Pioneers in Ivory Coast,” *Liahona*, Mar. 1999, 19.



Мормоны Ном амьдралыг өөрчилдөг

*Эдгээр хөрвөгч Мормоны Номыг
уншсанаар итгэлээ хөгжүүлсэн.*

Мормоны Ном нь Бурханы хүүхдүүд биднийг Есүс Христийн үнэн сургаалын талаар мэдлэгтэй болгоход зориулагдсан бэлэг үнэхээр мөн юм. Перугийн Лима хотод амьдардаг гишүүн Энрикэ Сэрпа Бустамантэ Мормоны Номыг биднийг хайрладаг эцэг эхийн захидал гээд, “Бидний Тэнгэрлэг Эцэг зөвлөгөө өгч, сайн сайхны төлөө удирдан залж, бүхий л цаг үед адислахын тулд бошиглогчдоор дамжуулан бидэнд ‘захиа’ бичсэн. Тэрээр маш ухаалаг төлөвлөгөө боловсруулан гаргасан бөгөөд биднийг адислалууд болон сайн мэдээг нь ойлгоход зүрх сэтгэлээ бэлдсэн яг тэр үед тэдгээр хайрын захидлыг хэрхэн өгөхөө мэддэг” хэмээн бичжээ.

Дэлхийн өөр өөр хэсэгт байдаг зарим хөрвөгчийг Сүмийн талаар анх суралцаж байхад Мормоны Номын яг юу нь гүн гүнзгий сэтгэгдэл тэдэнд төрүүлсэн тухай зарим гэрчлэлийг бид энд оруулав.

Есүс Христийн бас нэгэн гэрээ

Би Нигерийн Ибаданд байдаг үеэл дүүгийнхээ гэрт Мормоны Номыг анх харсан юм. Би ном унших дуртай болохоор, яагаад үүн дээр “Есүс Христийн бас нэгэн гэрээ” гэж бичсэнийг ойлгохыг хүссэн тул уг номыг авч уншив.

Тухайн үед зөвхөн израильчуудын Аврагч гэдэг нь миний хувийн бодолтой зөрчилдсөн том асуудал байсан ба “Есүс Христийн бас нэгэн гэрээ” хэмээх дэд гарчиг нь Аврагч зөвхөн израильчуудын биш, харин ертөнцийн Аврагч юм гэж ойлгоход оюуныг минь нээж өгсөн билээ. Тэр нифайчууд дээр ирж, тэдэнд

хууль, ёслолуудаа тогтоож өгсөн нь тохинууллынх нь талаар илүү ихийг мэдэх хүслийг надад төрүүлсэн.

Тэрхүү дэд гарчиг намайг Сүмийн талаар илүү ихийг мэдэхэд хөтөлсөн юм. Мормоны Номон дээрх үнэнийг өөрөө мэдэж авахын тулд залбир гэх зэрэг зөвлөгөөнүүдийг дагаснаар би Сүнснийг мэдэрч эхэлсэн (Моронай 10:4-ийг үзнэ үү). Есүс Христ амьд бөгөөд бид бүгдэд хайртайг би одоо мэднэ.

Эзэкиэл Акэ, АНУ, Айдахо

1 Нифай 8—“Урьд өмнө миний амсаж асан бүхнээс дээгүүр тэргүүн амтат” жимс

1 Нифай 8:11–12-т Лихай амьдралын модны жимсний талаар “урьд өмнө миний амсаж асан бүхнээс дээгүүр тэргүүн амтат. . . Энэ нь миний сэтгэлийг үлэмж агуу баяраар дүүргэв” хэмээн дүрсэлсэн байдаг. Эдгээр шүлгийг уншихад надад уг жимс онцгой байсан юм байна гэсэн хүчтэй мэдрэмж төрж, би ч гэсэн түүнээс хүртэхийг хүссэн.

Би Лихайг маш сайн ойлгож байв. Хэрэв би Лихайн оронд байж, мөн тийм жимс үнэхээр байсан бол надад ч гэсэн адилхан бодол төрж, гэр бүлийнхэндээ ч мөн идүүлэхсэн гэж ихэд хүсэх байсан гэж бодож байв. Эцэг эх маань Сүмийн гишүүн хараахан болоогүй байсан миний хувьд энэ нь маш үнэн санагдсан бөгөөд одоо ч гэсэн эдгээр мөрийг уншихад сэтгэл зүрхний маань хүслийг илэрхийлж байгаа мэт санагддаг.

Уг жимс Бурханы хайр болон Түүний сайн мэдээг төлөөлж байсныг мэдэж авахаас ч өмнө энэ нь онцгой байсныг би мэдэж байлаа. Бүр сүүлд уг жимсний

утга учрыг ойлгосныхоо дараа би үүнийг судар дээр ямар гайхалтай зөв дүрсэлсэн юм бэ гэж бодож билээ.

Судруудад үнэхээр бошиглогчдын цэдэглэсэн үнэн болон Бурханы үг хадгалагдсан байдаг.

Юн Жин Ём, Өмнөд Солонгос, Гиеонги муж

Иаков 5:74—Бурханд үйлчлэх хүсэл

Би Сүмийн талаар суралцаж байхдаа Иаков 5:74-ийг уншсан. Уншсан мөчөөс эхлэн уг шүлэг санаанаас маань гараагүй юм. Амьдралынхаа туршид би өмнөх сүмийнхээ маш идэвхтэй гишүүн нь байсан бөгөөд үргэлж Бурханд үйлчлэх хүслийг өвөрлөж явдаг байв. Тэр ч бүү хэл, хэзээ нэгэн цагт Түүнд үйлчлэхийн тулд гүн ухаан, шашин судлалаар суралцахыг хүсдэг байлаа. Би гүн ухаанаар суралцах элсэлтийн шалгалтандаа аль хэдийн тэнцсэн байв.

Гэвч би уг судрыг анх уншсанаа хэзээ ч мартахгүй. Энэ нь ХҮТ-ийн Сүмийн үйл ажиллагаанд анх удаа

оролцсоны маргааш орой байсныг би санаж байна.

Ангиудын хоорондох завсарлагааны үеэр самбар дээр номлогчдын үйлчлэх насыг бууруулсан талаарх ерөнхийлөгч Томас С.Монсоны хүлээн авсан илчлэлтийг тавьсан байхыг би олж харсан.

Тэр орой би Иаков 5:74-ийг уншаад, Бурханд үйлчлэх ёстой юм байна гэдгээ мэдэж билээ. Яагаад ч юм бэ, өөрсдийн амьдралыг Түүнд зориулсан надтай чацуу залуухан хоёр номлогчийг хараад, би ч гэсэн тэдэнтэй адилхан үйлчилж болно гэдгээ мэдсэн. Тэр Сүмийн цуглааны өмнөх орой би баптисм хүртэхээр, харин маргааш орой нь номлолд явахаар шийдэж билээ. Би Филиппиний Сэбу Зүүн номлолын сайхан хүмүүст үйлчилснийхээ дараа одоо гэртээ нэр төртэй буцаж ирчихээд байна.

Жозэф Гүтиррээ, Филиппин, Батангас

Иносын ном—Нүглийн өршөөл

Би анх Мормоны Номыг уншиж байхдаа хаанаас эхлэхээ сайн мэдэхгүй байлаа. Би уучилж өршөөх талаар, ялангуяа өөрийгөө уучлах дээр асуудалтай байсан ба өршөөл хүлээн авахуйц зохистой эсэхээ ч мэдэхгүй байв. Номлогч эгч нарын нэг нь надад хариултаа судраас олж болно мөн хаанаас эхлэхээ мэдэхгүй байвал үүнийхээ талаар залбирах ёстой бөгөөд хэрэгтэй судар тань гарч ирнэ гэж хэлсэн. Би судраа нээж, хуудаснуудыг эргүүлж байгаад, зогссон газраасаа уншихаар шийдсэн ба Иносын номын 4–6-р шүлэг гарч ирсэн юм. Уншсаны дараах яг тэр мөчид Мормоны Ном үнэн гэдгийг би мэдсэн.

Жэннифер Андрэски, АНУ, Калифорни

Мозая 27—Өөрчлөгдөх боломж

Анх удаа Мормоны Номыг уншихад надад Мормоны Номын Мозая дээрх Алмагийн хүү Сүмийг үгүйсгэн, устахыг завдаж буй талаар өгүүлсэн хэсэг хамгийн их таалагдсан. Гэхдээ түүнд огцом өөрчлөгдөхөд хүргэсэн нэг зүйл тохиолдсон нь Ариун Сүнс байсан бөгөөд энэ нь түүнийг итгэгч болгосон. Хүн бүрд өөрчлөгдөх боломж өгөгдөж байх ёстой болохоор энэ нь надад маш их таалагдсан.

Мариа Грациа Энрикэ Гонзалез, Чили, Маулэ






Эзэкиэл Акэ



Жозеф Гүтиррээ



Жэннифер Андрэски



Мари-Шантал Хөүг



Вэнү Баскар Накка

Мозая 27:28–29—Аз жаргал ба гэтэлгэл

Шинэ гишүүн миний хувьд, Мозая 27:28–29 надад гүн сэтгэгдэл төрүүлсэн юм. Их Эзэн надад нигүүлсэнгүй хандаж, нүгэлт амьдралаас маань гэтэлгэсэнд би талархаж байсан ба одоо ч талархсан хэвээр. Баптисм хүртэхээсээ өмнө би өөрийгөө аз жаргалтай хүн гэж бодож байсан ч сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авсны дараа мэдэрсэн аз жаргалыг түүнтэй харьцуулахын аргагүй. Би хэзээ ч гайхалтай ирээдүй хүлээж байгаа гэдэгт ийм итгэлтэй, баттай байгаагүй.

Би Алмагийн “Та нар түүнчлэн амьдралын модны жимснээс хүртэгсэд байж болохын тулд ирэгтүн мөн наманчлалд баптисм хүртэгтүн” (Алма 5:62) гэсэн урилыг хүлээн авсныхаа дараа Залуу Алмагийн бичсэний адил “Би хамгийн харанхуй ангальд байсан; харин эдүгээ би Бурханы гайхамшигт гэрлийг харнам. Бодгаль минь мөнхийн зовлонд тарчилж байв; гэвч би шүүрэгдлээ, мөн бодгаль минь цаашид дахин өвдөх нь үгүй” (Мозая 27:29) гэсний адил тайвшрал, амар амгалан төрүүлэх чөлөөлөлтийг мэдэрч билээ. Энэ хэсэг надад амьдралын шинэ эхлэл, шинээр олж авсан аз жаргал маань Есүс Христ бол миний Аврагч, Гэтэлгэгч гэдгийг хүлээн зөвшөөрсөн явдал дээр суурилсан байсан гэдгийг ойлгоход тусалсан. Харин одоо миний Аврагч шударга ёсны төлбөрийг өмнөөс минь төлж, надад наманчлах бүрдээ тэрхүү гэтэлгэгч хайрыг ахин дахин мэдрэх боломжийг олгосонд би үргэлж талархах болно.

Мари-Шантал Хөүг, Канад, Онтарио

Тэр жижигхэн хөх ном

Би Энэтхэгт төрсөн бөгөөд тэнд номлогчидтой уулзаж мөн анх удаа сүмд очсон. Тэр ням гараг Христийн амилсны баярын ням гараг байв. Ажлынхаа хуваариас болж би сүмд оройтож ирээд, өсвөр үеийнхний Ням гаргийн хичээлийн ангид оролцсон ба номлогчдын нэг

нь хичээл зааж байсан юм. Тэр миний урьд өмнө харж байгаагүй нэг хөх номноос судруудыг эш татсан боловч Библи шиг сонсогдож байв. Түүнийг зааж байх үед, миний зүрх сэтгэлд хүчтэй мэдрэмж төрж, би ч бас энэ номыг өөрийн болгох хэрэгтэй гэдгээ мэдсэн юм.

Би хичээлийн дараа шууд түүн дээр очоод, “Надад энэ ном хэрэгтэй” гэж хэлэв. Уг ном нь түүний өөрийнх нь хувийн судар байсан болохоор тэр үүнийг надад өгч болохгүй байсан тул надад бариулж, үзүүлсэн юм. Би өмнөх нүүрэн дээр нь алтан үсгээр “Мормоны Ном” гэж бичсэнийг харсан. Өөрийн гэсэн тийм номтой болох хэрэгтэй гэсэн мэдрэмж надад дахин төрөв. Уг номлогч миний хаягийг аваад, надад нэг хувийг авчирч өгөхөөр амласан юм. Мэдээж, номлогчид манай гэрт удалгүй ирж, надад өөрийн гэх Мормоны Номын хувийг гардуулж билээ. Тэгээд тэд надад сонирхогчийн хичээлийг зааж эхэлсэн.

Тэр жил Христийн амилсны баяр миний амьдралд итгэмээргүй бэлгийг авчирсан нь Мормоны Ном байсан юм. Тэр жижигхэн хөх ном амьдралд минь амийн сүнснийг авчирсан ба надад үүнээс сурах боломж байсанд би маш их талархдаг. ■

Вэнү Баскар Накка, АНУ, Калифорни муж



МОРМОНЫ НОМОН ДАХЬ ХҮЧТЭЙ ҮНЭНҮҮД

“Бурханы хүүхдийг Түүний талаар болон Түүний Хайрт Хүүгийнх нь талаар илүү ихийг мэдэхийг эрэлхийлэх үед гайхамшигтай зүйл тохиолддог. Мормоны Номоос өөр хаана ч эдгээр үнэнийг илүү тодорхой, илүү хүчтэй заадаггүй. . . .

Хайрт ах, эгч нар аа, Мормоны Ном бол үнэхээр Бурханы үг гэдгийг би гэрчилж байна. Үүнд амьдралын хамгийн чухал асуултуудын хариулт бий.

Рассэлл М.Нэлсон, “Мормоны Ном: Үүнгүйгээр таны амьдрал ямар байх байсан бэ?” 2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 55.

СЭЙНТ ЖОРЖИЙН САЙН ХҮМҮҮС

Би 12 настай байхдаа ерөнхийлөгч Лорэнзо Снөүгийн (1814–1901) АНУ-ын Юта мужийн Сэинт Жоржид хуурай гангаас болж зовж байсан хожмын үеийн гэгээнтнүүдийн төлөө залбирч байгааг харуулсан Сүмийн киног үзсэн юм.

Ерөнхийлөгч Снөү “Их Эзэн, Сэинт Жоржийн сайн хүмүүсийг адислаач” гэж залбирсан.

“Сэинт Жоржийн сайн хүмүүс” гэдэг үгс миний залуу оюун ухаанд мартагдашгүй сэтгэгдэл төрүүлсэн юм. Би Чилид амьдарч байхдаа “Сэинт Жоржийн сайн хүмүүс” гэж ямар итгэлтэй гэгээнтнүүд байгаа бол гэж төсөөлөхийг хичээдэг байв. Би тэдэнтэй уулзахыг хүсэж байлаа.

30 гаруй жилийн дараа, 2005 онд манай гэр бүл хоёр дахь хүүгээ Юта мужийн Прово хотод Бригам Янгийн Их Сургуульд сурч байсан ах дээр нь аваачиж өгсөн юм. Очсон өдрийнхөө орой нь би “Би Сэинт Жоржийн сайн хүмүүстэй очиж уулзмаар байна” гэж хэлэв.

Том хүү маань “Аав аа, Сэинт Жорж их хол шүү дээ” гэж зөрөв.

Би “Аав нь онгоцны билетийг төлсөн. Аав нь хоолыг нь төлж байна. Аав нь бензиний үнийг ч төлж байгаа. Аав нь өөрийнхөө төлөө ганц л зүйл хийхийг хүсэж байна. Аав нь Сэинт Жоржийн сайн хүмүүстэй л уулзмаар байна” гэж хариулсан юм.

Намайг тоглоогүйг мэдээд, хүү маань “За” гэж хэлсэн.

Маргааш нь бид 260 миль (418 км) хол машинаар явав. Сэинт Жоржид очсоныхоо дараа бид ариун сүмд байдаг зочдод зориулсан төвд очиж мөн ерөнхийлөгч Бригам Янгийн (1801–1877) өвлийн гэрийг очиж үзсэн. Бид бас табернекд очиж үзсэн ба тэнд ерөнхийлөгч Снөүгийн “Сэинт Жоржийн сайн хүмүүст” хандан ярьсан тэрхүү индрээс өөрийнхөө гэр бүлд хандан ярихад намайг урьсан юм. Бид хотоор алхаж, хүмүүстэй уулзаж, тэднийг ажиглаж байв. Тэд ердийн, итгэлтэй хожмын үеийн гэгээнтнүүд мэт санагдаж байсан.

Би гэр бүлээрээ тийшээ явсандаа баяртай байлаа. Биднийг Чили рүү буцаж очсоны дараа би “Сэинт Жоржийн сайн хүмүүсийг” урьд өмнө нь харж байснаа ойлгосон юм.

Миний ажил мэргэжил, Сүмийн дуудлагаас болж би Чили даяар аялдаг байсан. Каламад би зарлигуудыг сахихыг хичээж байгаа залуучуудыг харж байсан. Ла Серенад би Сүмийн цуглаанууд дээр хүүхдүүдтэйгээ эртлэн ирдэг, сэтгэлээ зориулсан эцэг эхчүүдийг харж байсан. Антофагастад би өдөр бүр зөв зүйлийн төлөө тэмцэж байдаг хожмын үеийн гэгээнтнүүдийг харж байсан. Валлэнар, Копиапо, Калдэра, Токопилла болон бусад хотод би амьдрал нь хэцүү үед ч өвдөг сөхрөн залбирч, урагш зүтгэх гишүүдийг харж байсан.

Би хаана амьдардаг ч бай, ямар бэрхшээлтэй тулгарсан ч бай дуулгавартай дагаж, тэвчдэг, итгэлтэй хожмын үеийн гэгээнтнүүдийг хараад, “Энэ хүмүүс бол Сэинт Жоржийн сайн хүмүүс” гэж дотроо боддог. ■

Клаудио Гонзалез, Антофагаста, Чили

Би хаана байгаагаас нь үл шалтгаалан, итгэлтэй хожмын үеийн гэгээнтнүүдийг хараад, “Энэ хүмүүс бол Сэинт Жоржийн сайн хүмүүс юм” гэж дотроо боддог.



“ҮНЭНДЭЭ, БИ НЭГ НЬ ШҮҮ ДЭЭ”

Намайг автобусанд ороод дөнгөж суутал нөгөө талын суудалд сууж байсан хүн над руу тонгойн, “Чи их сайхан сүнстэй юм” гэж хэлсэн.

Би ямар их гайхсанаа хэлээд ч хэрэггүй байх. Миний сүнсний талаар магтаалын үг хэн ч хэлж байгаагүй. Юу гэж хариулахаа сайн мэдэхгүй байсан тул би зүгээр л “Баярлалаа” гэв.

Тэр эрэгтэй шашны бүлэгтэйгээ ажилладаг ажлынхаа улмаас намайг тийм гэж мэдэж байна гэж хэлсэн. Түүнийг надад сүнсээ хэрхэн сайхан хадгалах тухай зөвлөгөө өгөхөд нь би түүнийг сонсож байв.

Автобус зогсон, бид хоёр хоёулаа буухаар босож зогсоход тэр “Тэр мормончуудыг л битгий сонсоорой” хэмээн бодлоо хэлсэн юм.

Цаг хугацаа түр зогсчих шиг санагдав. Энэ хүн миний төрхнөөс ямар нэг онцгой зүйл харсан байв. Гэхдээ тэр нь миний шашны улмаас болж тийм байсан гэдгийг огт мэдээгүй байлаа.

Би юу гэж хариулах хэрэгтэй байсан бэ? Үнэндээ бол, би эхэндээ юу ч хэлэлгүйгээр, сонсоогүй мэт өнгөрдөг юм уу ч гэж бодож байлаа. Би түүнд Сүмийн гишүүн гэдгээ хэлэх юм бол тэр сөрөг үгээр ширүүн хариулах байх гэж санаа зовж байв.

Тэрхэн хоромд надад “Би сайн мэдээнээс ичихгүй. Яагаад гэвэл тэр нь итгэгч хүн бүрийг авралд хүргэх Бурханы хүч мөн” (Ром 1:16) гэдэг судар санаанд минь орж ирсэн юм. Би сайн мэдээнээс ичээгүй гэдгээ ойлгосон бөгөөд хэрвээ би гэрч болон зогсохгүй юм бол миний сүнс бусдын төлөө гэрэлтэхгүй гэдгийг ухаарсан. Би шийдэмгий гэгч нь тэр хүн рүү хараад, “Үнэндээ, би нэг нь шүү дээ” гэж хэлсэн юм.



Хэрвээ гэрч болон зогсохгүй юм бол миний сүнс бусдын төлөө гэрэлтэхгүй гэдгийг би ухаарсан.

Тэр хүн над руу ширтэж, би ч өөдөөс нь ширтэв. Тэр инээгээд, кофенд дэндүү дуртай учраас Сүмд элсэж чадахгүй гэж хэлсэн нь гайхширлыг минь төрүүлсэн юм. Би ч инээн, бид өөр өөрсдийнхөө замаар одож билээ.

Өнөөдрийг хүртэл би өөрийн гаргасан тэрхүү сонголтондоо баяртай байдаг. Сүмийн гишүүн

хэмээн зогсох нь хэцүү байж болно гэдгийг би мэднэ. Заримдаа энэ нь бүр аймшигтай ч байж болно! Гэхдээ биднийг Бурханы төлөө зогсоход бидний сүнс гэрэл мэт дэлхийд гэрэлтэж чадна. ■ Абби Торн, АНУ, Юта



Миний машины
зогсоолоор гүйх гүйлт
3 жилийн турш үргэлжилсэн.

СҮМ РҮҮ ГҮЙЖ ОРСОН МИНЬ

Нэг удаа би гүйх газар хайж байхдаа өөрийн хөрш зэргэлдээ байдаг нэг Сүмийн гадаах машины зогсоолоор гүйж үзэхээр шийдсэн юм. Энд гэрэлтэй, засмал зам тавигдсан байсан болохоор би их дуртай байв. Тэр байрыг тойроод 10-15 удаа гүйх юм бол энэ нь миний 3 милийн (4.8 км) гүйлтийн дасгал болж болохыг би олж мэдэв.

Миний машины зогсоолоор гүйх гүйлт 3 жилийн турш үргэлжилсэн юм. Зарим үед Сүмийн цуглаанууд болон бусад үйл ажиллагааны үеэр гүйдэг байсан учраас машины зогсоол дээр хүмүүсийг хардаг байлаа.

Хэд хэдэн удаа би хэн нэгэнтэй Сүмийн талаар ярих хэрэгтэй гэж бодсон ч яаж ярихаа огт мэдэхгүй байв. Нэг орой би ажлаасаа харьж яваад, тэнд зогсохоор мөн хэн нэгнийг олж магадгүй гэж бодоод, очиж үзэхээр шийдсэн юм. Би

сүмийн байранд ороод, номлогчид номлолын ерөнхийлөгчтэйгөө ярилцлага хийгээд дуусах гэж байгааг олж мэдэв. Би өөрийгөө танилцуулж, бид үүдний өрөөнд суув. Тэнд тэд надад сайн мэдээний миний анхны хичээлийг зааж билээ.

Дараагийн хэдэн долоо хоногийн турш би номлогчидтой үргэлжлүүлэн уулзав. Намайг ариун ёслолын цуглаанд очиход тойргийн гишүүд намайг хайрлан хүлээн авч, нөхөрлөж, урам дэм өгдөг байсан юм. Би ойлгож мэдэн, сурч авч байсан зүйлсийнхээ талаар бодож үзээд, Сүмийн талаарх сонирхол минь баптисм хүртэхээр шийдсэн хэрэгцээ болон өөрчлөгдсөнийг ойлгосон. Би Тэнгэрлэг Эцэгийнхээ надаар хийлгэхийг хүсэж байгаа зүйлийг хийж байгаа гэж Сүнсээр өдөөгдсөн боловч уг шийдвэрийн талаар үргэлжлүүлэн бодож байлаа. Эцэст

нь би 2001 оны 11-р сард 36 настай байхдаа баптисм хүртсэн юм.

Сүмийн машины зогсоолоор гүйх миний шийдвэр тэр үед надад тийм ч чухал санагдаагүй. Гэхдээ энэ нь миний хамгийн агуу адислалууд болох Сүмд гишүүн болж, эхнэр Жэннифэртэйгээ танилцан, Сан Диего Калифорни ариун сүмд энэ амьдралд болон үүрд мөнх лацдан холбуулахад хөтөлсөн билээ.

Тиймээс, хэрвээ та танай цуглааны байрны машины зогсоол дээр хэн нэгэн хүн дасгал хийж байгааг харах юм бол өөрийгөө танилцуулаарай! Тэр танай тойргийн шив шинэ гишүүн болох ч юм бил үү, та мэдэхгүй шүү дээ. ■

Даниэл Р.Томпсон, АНУ, Калифорни

СОНСОХЫГ ХҮСЭЭГҮЙ ЗӨВЛӨГӨӨ

Манай нөхөр бид хоёрыг шинэ бизнес эхлүүлэхээр шийдэх үед эхний гурван жил маш хэцүү байв. Бид ашиг олж чадахгүй, өрөнд орж байлаа. Бид шаргуу ажиллаж байсан ч гэнэтийн асуудал ар араасаа гарч, амьдралын маань тэр цаг үеийг хамгийн хүнд хэцүү үе болгосон юм.

Хадам ээж маань Христийн мэндэлсний баярын маргааш нь насан өөд болж, долоо хоногийн дараа нь шинэ жилийн өмнөх өдөр би маш хүндээр өвдөж, бүх зүйл дордов. Тэр үед бид дампуурлын байдалд орчихсон, машинаа ч алдчихсан, бүр хамгийн муу нь гэвэл эрүүл мэндийн даатгалаа алдчихсан байв.

Эцэст нь, намайг наад зах нь таван жил өвчлүүлсэн, маш хурдан явцтай хорт хавдар туссан гэж оношилсон юм. Энэ нь маш ноцтой байсан бөгөөд яаралтай мэс засал хийлгэх шаардлагатай байв. Надад богино хугацаа үлдсэн байсан бөгөөд шаардлагатай үнэтэй эмнэлгийн эмчилгээг төлөх мөнгө бидэнд байгаагүй.

Нөхөр бид хоёр бишоптойгоо уулзаж, тусламж хүссэн юм. Энэ нөхцөл байдал нь шуудхан хэлэхэд амь амьдралын асуудал байсан гэдгийг бид тайлбарласан. Бишоп маань санаа зовж байсан ч тусламж өгөхөөсөө өмнө, өөр нэг арга зам нээгдэж магадгүй тул ахиад жаахан хүлээх ёстой гэж сүнслэгээр өдөөгдөж байгаагаа хэлэв. Бидний итгэл хангалттай бол Их Эзэн шаардлагатай тусламжийг авах арга замаар намайг хангаж өгөх болно хэмээн тэр бидэнд батлан хэлж билээ.

Эхлээд бишопын хариулт уурыг минь хүргэж, би гомдсон. Бишоп, Их Эзэн хоёр хоёулаа намайг орхисон мэт надад санагдаж билээ. Гэхдээ би сайн мэдээний талаар

гэрчлэлтэй байсан бөгөөд бишоп маань Бурханаас дуудагдсан гэдэгт итгэдэг байсан. Зүрх сэтгэл минь шаналж байсан ч би Тэнгэрлэг Эцэгт бишопоо үргэлжлүүлэн хайрлаж, хүндэлж, дэмжихэд минь надад туслахыг гуйн залбирсан. Ийнхүү залбирч байхдаа би тайвширч, Их Эзэн надад ямар нэг аргаар туслах болно гэдгийг мэдэрсэн юм.

Нөхөр бид хоёр итгэлтэйгээр урагшилж, шаардлагатай шинжилгээнүүдээ хийлгэн, мөнгөний хомсдолтой байсан ч мэс заслын цаг авсан. Мэс заслынхаа өмнөх өдөр бид бизнесээ сайн үнээр зарсан ба

тэгснээр миний эмнэлгийн бүх зардлыг төлж чадсан юм.

Манай бишоп яагаад туслахаас түдгэлзсэний шалтгаан сая л надад тодорхой болж билээ. Надаар үнэ цэнтэй сүнслэг явдлыг мэдрүүлэхийн тулд тэр сүнслэгээр өдөөгдөн үйлдсэн байжээ. Энэ явдал надад хэдий зам нь аймаар, халшрам санагдаж байсан ч Аврагчид хэрхэн найдахыг заасан. Би сонсохыг хүсээгүй зөвлөгөөгөө бишопоосоо авсандаа талархаж байна. Бурхан гайхамшгийн Бурхан бөгөөд биднийг хэзээ ч орхидоггүй гэдгийг би мэднэ. ■ Нэрийг нууцлав, Бразил, Порто Алэгрэ



Надад богино хугацаа үлдсэн байсан бөгөөд шаардлагатай үнэтэй эмнэлгийн эмчилгээг төлөх мөнгө бидэнд байгаагүй.

Орчин үеийн гурван анхдагчийн аялал

Сара Кийнан

Б и Австралийн Мелборнд номлолд үйлчилж байхдаа гадаад оюутнуудаас бүрдсэн тойрогт үйлчилдэг байсан юм. Тэднийг ням гаргийн ангид анхдагчдын тухай ярилцаж байхад би, тэд өөрсдөө бараг бүгдээрээ дөнгөж хөрвөгдөөд байсан бас тэдний хэнийх нь ч өвөг дээдэс Хойд Америкийн хөндийг туулаагүй учраас энэ хичээлийг хэр их сонирхох бол доо гэж бодож байлаа.

Олон гадаад оюутан уг түүхүүдийг маш их сонирхсон нь миний гайхлыг төрүүлсэн юм. Тэдний зарим нь эдгээр гадаад оюутан анхдагчидтай адил шинэ хөрвөгчид байсан бөгөөд өөрсдийн амьдарч байсан бүсэд Сүмийг байгуулахын тулд золиослол хийсэн болон хувийн ямар нэг байдлаараа эртний гэгээнтнүүдтэй холбогдож байгаагаа дурдсан юм. Эдгээр гишүүний заримын хувьд тэдний төрөлх нутагт Сүм маш жижиг эсвэл огт байдаггүй байсан. Тэд орчин үеийн анхдагчид

байсан бөгөөд ирээдүйн үеийнхэнд зориулан шашны шинэ өвийг бий болгож байв.

Орчин үеийн анхдагчдын эгнээнд элссэн хөрвөгчдийн заримд тохиолдсон явдлыг хуваалцъя.

ГЭР БҮЛЭЭ ШИНЭ АРГА БАРИЛААР ХҮНДЛЭХ НЬ

Нами Чан, Тайвань, Таоюань

Т айвань дахь манай гэр бүл болон хамаатнуудын олонх нь Буддын шашинтай. Би залуу байхдаа Хятадын шинэ жилээр болон бусад баяраар өвөг дээдэстээ мөн олон бурханд зориулан өргөл өргөхөд бэлдэхэд нь тусалдаг байснаа санаж байна. Энэ нь манай гэр бүлийн уламжлал байсан бөгөөд өвөг дээдсээ дурсан тэмдэглэж, өөрийн гэр бүлд амар амгалан болон хөгжил дэвшлийг авчирдаг арга зам байв.

Гурван залуу Сүмд нэгдээд, хэрхэн өөрсдөдөө болон гэр бүлдээ итгэлийн өвийг бий болгосон тухай түүхээ хуваалцав.

Хамаатнуудын маань зарим нь орон нутгийн Христийн сүмд элсэхэд эхэндээ энэ нь манай гэр бүлд нөлөө үзүүлээгүй. Гэтэл Чинг Мин фестивалийн үеэр, өвөг дээдэстээ мөргөж, тэдний булшин дээр утлага уугиулах үед манай Христийн шашинтай хамаатнууд үүнд оролцохоос татгалзсан. Тэд Арван зарлигийг, ялангуяа “Чи Надаас өөр бурхадтай байж болохгүй” (Египетээс гарсан нь 20:3) хэмээх зарлигийг



дагахаар шийдсэн гэдгээ хэлсэн юм. Манай гэр бүл өмнө нь өөр шашны талаар ярьж байгаагүй бөгөөд тэр өдрөөс эхлэн Христийн шашин нь манай гэр бүлийнхний нүдэнд уламжлалыг устгадаг гэж бодогдож, сөргөөр үзэгдэж эхэлсэн билээ.

Би их сургуульд явж байхдаа гудамжинд ХҮГ номлогчидтой тааралдсан юм. Ер нь бол, би тэдний хэлэх зүйлийг сонирхоогүй. Гэхдээ надад тохиолдсон зарим үйл явдал тэдний захиасыг сонсоход зүрх сэтгэлийг маань бэлтгэсэн байв. Тэдэнтэй уулзаж байхдаа би залбирахыг мөн Мормоны Номыг уншихыг зөвшөөрсөн бөгөөд надад зааж байсан зүйлсийн талаар хувийн гэрчлэлтэй болж эхэлсэн. Гэхдээ эцэг эх маань Христийн шашны эсрэг бодолтой байсан болохоор би тэдэнд баптисм хүртэх хүсэлтэй байгаагаа хэлэхийг хүсээгүй. Би анх номлогчидтой уулзсанаасаа хойш

олон сарын дараа аав, ээж хоёртоо баптисм хүртэхийг мөн номлолд үйлчлэхийг хүсэж байгаагаа хэлсэн юм. Тэд ууртай байсан ч би зөв сонголт хийж байгаагаа мэдэж байв.

Надад анхдагч өвөг дээдэс байхгүй ч гэсэн би тэдний золиослолыг ойлгодог юм шиг санагддаг. Зарим уламжлалаа орхин, гэр бүлийн гишүүдийн эсэргүүцэлтэй тулгарах нь хэцүү байдаг. Одоо ч гэсэн, Сүмд нэгдээд таван жил болсны дараа мөн номлолд үйлчилсний дараа ч манай гэр бүл миний шийдвэрийг бүрэн дүүрэн дэмждэггүй. Гэхдээ тэд хүлээн зөвшөөрдөг болсон. Сүмд нэгдсэнээр би гэр бүлээ шинэ арга замаар хүндэлж, гэр бүлийн түүхээ бичин, өвөг дээдсээ эрж хайх боломжтой болсон. Есүс Христ болон Түүний Цагаатгалын талаарх миний гэрчлэл гэр бүлтэйгээ гарч болох ямар ч зөрөлдөөнийг шийдвэрлэхэд тусалдаг.

САЙН МЭДЭЭНЭЭС БАЯР ХӨӨР ОЛОХ НЬ

Харри Гуан, АНУ, Юта

Би Хятадад өссөн ба хэзээ ч сүмд явж байгаагүй ч гэсэн өөрийгөө Христийн шашинтан гэж боддог байсан. Би Бурхан болон Есүс Христийг сонирхдог байсан бөгөөд Христийн сургаал маш их тайвшрал авчирдаг гэж боддог байлаа.

Би коллежид сурахаар Нэгдсэн Улс руу нүүж, тэндээ орон нутгийн Христийн сүмд явж эхлэв. Цөөн хэдэн сарын дараа би Бригам Янгийн Их Сургуульд явах талаар бодож байгаа хэдэн найзаасаа Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн тухай сонссон юм. Би Христийн сүмд хэд хэдэн оюутнаас хожмын үеийн гэгээнтнүүдийн тухай асуухад, тэд “мормончуудаас” хол байхыг чин сэтгэлээсээ сэрэмжлүүлсэнд ихэд гайхаж билээ. Би эхлээд тэдний зөвлөгөөг сонссон бөгөөд долоо хоног орчмын дараа олон нийтийн мэдээллийн хэрэгслээр юм үзэж байхдаа Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холландын үг хэлэхийг харсан юм. Тэр хэлсэн үгэндээ Сүмийн гишүүд бусад шашинд хүндэтгэлтэй хандах ёстойг дурдсан байв ([lds.org/prophets-and-apostles](https://www.lds.org/prophets-and-apostles) дээрээс “Faith, Family, and Religious Freedom”-ийг үзнэ үү). Би ахлагч Холландын үгийг сонсоод, энэ Сүмийн талаар илүү ихийг мэдэх хэрэгтэй юм байна гэж мэдэрсэн. Энэ нь Сүнс байсныг би одоо мэднэ.

Би Сүмд явж, хожим нь номлогчидтой уулзсан. Тэдний заасан

зүйл, ялангуяа Авралын төлөвлөгөө миний сэтгэлийг хөндсөн юм. Намайг баптисм хүртэхээр шийдэхэд аав, ээж хоёр маань тийм ч баяртай байгаагүй ч өөрөө шийдвэр гаргах насанд хүрсэн гэдгийг маань хүлээн зөвшөөрсөн. Өвөө, эмээ хоёрыгоо хэдэн сарын дараа Америкт над дээр айлчилж ирэхэд нь би тэдэнд сайн мэдээний талаар заах боломжтой байсан юм. Тэр хоёр хоёулаа баптисм хүртэхээр шийдсэн.

Сайн мэдээ надад маш их баяр хөөрийг авчирсан бөгөөд намайг эхнэр минь болох хүн рүү хөтөлсөн. Энэ нь миний хийсэн болон хойшид хийх бүх золиослолыг хариулахуйц үнэ цэнтэй билээ.

ХОЙЧ ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛЖ ЗАМЫГ БЭЛТГЭХ НЬ

Брүк Киникини, АНУ, Хавай

Би 15 настай байхдаа Сүмд орсон ч Бхүүхэд байхаасаа л сүмд явж итгэл, гэрчлэлээ хөгжүүлдэг байсан. Би гэр бүлдээ цорын ганц гишүүн нь байсан



ч итгэлтэй найзууд маань намайг хайрлаж, өөрсдийн үлгэр жишээгээр удирдан дагуулж байлаа.

Эртний анхдагчдын адил би хэзээ ч хөлдүү хөндийг туулан, гар тэрэг түрээд алхах шаардлагагүй байсан. Үнэндээ, би Сүмд нэгдэхдээ олон бэрхшээл туулаагүй. Мэдээж, би зарим найзаасаа салж, ганцаараа Сүмд явж мөн семинарт оролцож байсан. Гэхдээ энэ нь миний гэр бүлд ямар нөлөө үзүүлсэн мөн үзүүлж байгаа талаар бодох үедээ би гаргасан хамгийн зөв шийдвэрүүдийн маань нэг байсныг мэддэг. Баптисм хүртэх, ариун сүмд лацдан холбуулах, гэрээнүүддээ үнэнч үлдэх шийдвэр маань миний гурван хөөрхөн хүүхдийн амьдралд болон хойч үеийнхэнд мөнхөд эерэг нөлөө үзүүлэх хэлхээ холбоог үүсгэсэн.

Анхдагч байна гэдэг нь бусдын төлөө замыг бэлдэх гэсэн үг юм. Сүмийн итгэлтэй гишүүн байснаараа миний хүлээн авсан олон адислалын нэг нь бусдыг Христэд авчрахад туслах боломжтой байх явдал юм гэж би бодох дуртай. Хавайн Мауи арлын 15 настай охин эсвэл төгөл дэх 14 настай хөвгүүний даруухан залбирал зэрэг жижиг мэт санагдах үйл явдлууд өнгөрсөн, одоо, ирээдүйд гэр бүлүүдийн амьдралыг өөрчилж чадна.

Орчин үеийн анхдагчид зөвхөн хөрвөгчид биш юм. Бид хойч үеийнхэнд итгэлтэй байдлын удаан хадгалагдах өвийг үлдээхийг эрэлхийлснээр бүтдээрээ анхдагч болох боломжтой. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.



АНХДАГЧ ӨВӨӨ ЭЗЭМШИХ НЬ

“Би Сүмийн эртний анхдагчдын итгэл, зоригийг хайрлан, хүндэтгэж явдаг. Миний

өөрийн өвөг дээдэс тэр үед далайн чанадад амьдарч байсан Хэн нь ч хөндийг гатлах аяныг хийгээгүй. Гэвч би Сүмийн гишүүний хувьд энэ анхдагч өвийг өөрийнхөө өвөг дээдсийн нэгэн адил талархаж мөн бахархан авч үздэг.

Би орон бүрд амьдарч байгаа итгэл бишрэл, тэсвэр хатуужил, золиослолын түүхээрээ Бурханы хаант улсын хожмын үеийн түүхэнд ихээхэн хувь нэмэр оруулж байгаа өнөө үеийн Сүмийн анхдагчдыг бас нэгэн адил баярын дуугаар тунхаглаж байна.”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дийтр Ф.Угдорф, “Бидний өвөг дээдсийн итгэл,” 2008 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 70.



Тусгаарлагдсан мэт санагдаж байна уу? Хурдаа сааруулахыг хичээгээрэй

Шарлотт Ларкэбэл

Сүмийн сэтгүүлүүд

Алз болон могойны хажууд удаан дугаарлан зогсож хүлээхийг хар дарсан зүүднийхээ хувийн жагсаалтад оруулдаг бол та ганцаараа биш.

Бид оочерт зогсох, замын хөдөлгөөнд түгжрэх эсвэл автобус харуудан зогсохдоо хүлээх дургүй байдаг.

Бидний аз болж хүлээлт нь хар дарсан зүүд мэт болсон бөгөөд өдөр тутам тохиолддог энгийн зүйл биш хааяа тохиолддог зүйл болоод байна. Өнөөдөр бид хүлээх цаг гэж байхгүй эрин үед амьдарч байна. Технологи нь бүх зүйлийг хурдасгаж байгаа болохоор бидний нэг зүйлд анхаарал тавих хугацаа алтан загас хүлээхээс ч богино болоод байна (яг үнэн шүү).¹ Бид хүлээх хэрэгтэй болоход ихэвчлэн утсаа оролдож цагаа өнгөрөөхийг хичээдэг.

Технологи юм уу цаг ашиглан үр дүнтэй байхад буруу зүйл байхгүй. Гэхдээ хурд болон байнгын сатаарал нь биднийг нэгэн чухал зүйлээс холдуулдаг байж болох юм.

Судраас илүү зүйл

Саяхан надад сүнслэг байдлын хувьд нэгэн хэвийн болсон мэт санагдаж байв. Би үүнийг ойлгож

чадахгүй байлаа. Би Сүмд явж, хурдан залбирч, судраа халт харчихдаг байсан. Би заримдаа сүнслэг өдөөлт мэдэрч байсан ч ерөнхийдөө ямар нэг хэмжээгээр тусгаарлагдсан мэт санагдаж байв.

Энэ тухай Тэнгэрлэг Эцэгт хандан залбирахдаа сэтгэл зовнин хэлэхэд “Тэмцэлдэхээ больж, намайг Бурхан гэдгийг мэд” (Дуулал 46:10) гэсэн үгс санаанд орж ирж билээ.

Тэмцэлдэхээ больж гэдэг үгийг тодруулж, доогуур нь зурж, тодоор бичсэн мэт байв.

Би бүх зөв зүйлийг хийж байсан ч тэдгээрийг хурдан, анхаарлаа бага төвлөрүүлэн хийж байсан байх. Би сайн мэдээний дагуу амьдрахдаа сатаарсан байдлаар хандаж байв.

Хэрвээ би сатаарсан байдлаар өнгөц хандаж оролцож байх юм бол шашны ямар ч дадал надад Бурхан Тэргүүтэнтэй холбогдох гүн гүнзгий сүнслэг холбоог авчирч чадахгүй. Энэ эшлэл ямар нэг ухаалаг судраас хавьгүй илүү зүйл юм. Бурханыг мэддэг болж, өөрийн хүсэн мөрөөдөж байсан тэнгэрлэг мэдлэгтэй холбогдохын тулд би хурдаа сааруулж тэмцэлдэхээ болих хэрэгтэй байв.

Энэхүү сүнслэг өдөөлтийг дагах нь амархан байгаагүй. Гэхдээ энэ нь бүхий л өөрчлөлтийг гаргасан юм.

Хэн ч “Би хүлээх дуртай” гэж хэлж байгаагүй. Гэхдээ тэгж хэлж байх хэрэгтэй байж магадгүй.

Одоо, хурдаа сааруулаарай . . .

Нифай “*хичээнгүйлэн хайгч тэр* олох болно; мөн Бурханы нууцууд нь тэдэнд Ариун Сүнсний хүчээр *задлагдах* ажгуу” хэмээн заасан (1 Нифай 10:19; тодотгол нэмэв).

Үүнийг задалж үзье. Бурханы нууцуудыг судалж мэдэхэд *хичээнгүйлэн эрэлхийлэх* шаардлагатай. Энэ нь байнгын, ухамсарлан хийх дадал бөгөөд нэг удаа Google дээрээс хайх зүйл биш юм. Дараа нь нууцууд энд тэндээс ил гараад ирдэггүй ч яваандаа *задлагддаг*. Энэ үйл явцад цаг хугацаа хэрэгтэй. Мөн тэрхүү цаг хугацаа маш чухал!

Тунгаан бодож мөн эрэлхийлэхэд зарцуулах *цаг хугацаа* нь Сүнсний хүчээр дамжуулан хариултуудыг авчрах Сүнстэй холбогдох *цаг хугацааг* бидэнд өгдөг.

Ерөнхийлөгч Дэвид О.Маккэй (1873–1970) бясалгал нь “шашны ямар нэг сэдэв дээр үргэлжлүүлэн, гүн төвлөрөн бодох” буюу Их Эзэний дэргэд очих хамгийн ариун . . . хаалгануудын нэг юм”² хэмээн

тунхаглажээ. Бид хурдаа сааруулснаар илчлэлтийн үүд хаалгыг нээж чадна. Бид дэлхийн нийтлэг хандлагаас гарч, тэнгэрийн зүйлстэй холбогдож чадна. Бидэнд тэр хаалга *хэрэгтэй*. Бид хурдаа сааруулах хэрэгтэй.

Үүнд хичээл зүтгэл шаардагддаг

Миний хувьд, хурдаа сааруулах гэдэг нь өвдөг сөгдөн, залбирахдаа


чанга ярихыг хэлдэг. Бишрэнгүй байдалтай байж, үгээ сонсогдохоор хэлэх нь надад анхаарлаа сайн төвлөрүүлэхэд тусалдаг. Хурдаа сааруулах гэдэг нь судрын бодит номноос уншиж мөн тэмдэглэлийг бодитой хөтлөхийг хэлдэг. Энэ нь илүү хичээл зүтгэл, цаг хугацаа шаарддаг бөгөөд энэхүү нэмэлт хичээл зүтгэл, цаг хугацаа нь “сэрж мөн чадвараа сэргээх” сайн цаг үе юм. Тэгснээр Сүнсний болон үнэнийг хүсэх хүслийг “өөрсөддөө хөгжихийг” мөн гэрчлэлийн тэр үрэнд “үндэслэн, мөн ургаж, тэгээд үр жимс авчрахыг” зөвшөөрдөг (Алма 32:27, 37).

Бид хэдэн товч дараад л, хүссэн мэдээлэл болгоноо олж авч чаддаг бол сүнсэлэг ойлголт болон хөрвөлт нь *цаг хугацаа* болон хичээнгүй *зүтгэлийг* шаарддаг. *Яаж* хурдаа сааруулж, сайн мэдээнд хичээл зүтгэл гаргах нь чухал биш, харин хийх нь л чухал! Бэлэн мэдээлэл өгөгдсөн үед бид сурч мэдэх өөрсдийн оролцооны ихэнхийг үгүй болгодог. Бид Сүнстэй холбогдох боломжуудаа багасгадаг.

Өдөр тутмын ажлыг хялбарчилж, цагийг илүү үр дүнтэй ашиглах боломж олгодог технологи, хөгжлийг бид дуртайяа хүлээн авч болно. Гэхдээ үүнтэй хамт олонтоо ирдэг сатаарсан амьдрал, өнгөц бодлыг сонгон авч болохгүй. Хүлээхээс халшрахын оронд бид үүнийг хурдаа сааруулах, бясалгах мөн Сүнстэй холбоогоо гүнзгийрүүлэх боломж хэмээн хүлээн авч болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Leon Watson, “Humans Have Shorter Attention Span Than Goldfish, Thanks to Smartphones,” *The Telegraph*, May 15, 2015, telegraph.co.uk.
2. *Teachings of Presidents of the Church: David O. McKay* (2011), 3132.



Хэцүү асуудлыг шийдэхэд ТУСАЛЖ ЧАДАХ ГУРВАН ЗАРЧИМ

Итгэлээ хөгжүүлэх арга замаар хэрхэн хариулт эрэлхийлэхийг энд тайлбарлав.



Танд урьд өмнө нь Сүмийн эсвэл сайн мэдээний талаар асуух зүйл гарч байсан уу? Асуух зүйл байгаа болохоор өөрийгөө хангалттай итгэлгүй эсвэл өөрийн тань гэрчлэл хангалттай хүчтэй биш юм байна гэж та санаа зовж байсан уу?

Асуулттай байх нь зуурдын амьдрал дахь аяны ердийн нэгэн шаардлагатай хэсэг юм. Эдгээр нь

таныг илүү ихийг ойлгож, илүү их итгэлтэй болоход хүргэнэ. Гэсэн хэдий ч хариулт олох гэсэн таны хандлага, зүтгэл болон үйлдэл үр дүнд нь нөлөөлж чаддаг.

Семинар дээр та нар мөнхийн үнэн рүү та нарыг удирдахад туслах сургаалын эдгээр гурван гол зарчмыг мэдэж авах болно.

1. Итгэлээр үйлд

Та асуух зүйл гарах үед Бурханд найдан мөн хариулт авахын төлөө Түүнд хандахыг сонгосноор итгэлээр үйлдэж болно. Бурхан “шат шатаар, дүрэм дүрмээр” (2 Нифай 28:30) хариулт өгдөг. Эргэлзсэн үедээ өөрт байгаа гэрчлэлд тулгуурлах нь чухал юм.

“Итгэлдээ эргэлзэхээсээ өмнө эргэлзээндээ эргэлз.”¹ —Ахлагч Дийтр Ф.Угдорф
 “Мэддэг зүйлээсээ зууран, илүү их мэдлэг иртэл тэвчээртэй байцгаа.”² —Ахлагч Жэффри Р.Холланд

2. Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь авч үз

Хэрвээ та асуултыг авралын төлөвлөгөө болон Аврагчийн сургаалуудын агуулгын хүрээнд авч үзэх юм бол Бурханы тэдгээрийг хэрхэн хардаг арга замаар аливаа зүйлийг харж эхлэх болно. Энэ нь дэлхийнхний биш, харин Бурханы үнэний жишгийг ашиглан, асуултууддаа хандахад тань тусална.

“Мөнхийн үнэнд зангуугаа тавих нь . . . бидэнд Есүс Христэд итгэх итгэлээс мөн бид мөнх амьдралд хүрэх зам дээр байгаа гэх мэдлэгээс ирэх амар амгаланг бидэнд өгөх болно.”³
 —Ерөнхийлөгч Даллин Х.Өүкс

Хэрэв амьдралын *тань* сайн мэдээний гэрэл, баяр баяслыг халхлах аливаа зүйл байгааг олж мэдвэл үүнийг сайн мэдээний алсын хараагаар хараарай гэж би та нарыг урьж байна. Сайн мэдээний томруулдаг шилээр харж, амьдралын чухал бус, эмх замбараагүй асуудлуудад аз жаргалын агуу төлөвлөгөөг олж харах мөнхийн хараанд маань харанхуйлах боломжийг олгохгүйн тулд сэргэг бай.”⁴ —Ахлагч Гари И.Стивэнсон

3. Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү ихийг ойлгож авахаар эрэлхийл

Бурхан үнэнийг эрэлхийлэх явцад тань ашиглаж болох олон эх үүсвэрийг танд өгсөн. Эдгээрт Ариун Сүнс, судрууд, гэр бүл, Сүмийн удирдагчид болон Есүс Христэд итгэх итгэлийг тань нэмэгдүүлэх Сүмээс гадуурх эх

сурвалжууд багтдаг. Хариултуудыг эрэлхийлж байх үедээ найдвартай, найдваргүй эх сурвалжуудыг ялгаж үзэх тал дээр анхаараарай. Найдвартай эх сурвалжууд нь амьдралд тань Ариун Сүнсийг урьж мөн итгэлийг тань бэхжүүлнэ.

“Үнэний талаарх ойлголтоо өргөжүүлж, нэмэгдүүлэх хичээл зүтгэлээс тань баялаг ашиг тус . . . ирэх болно. Мэдлэгээ өргөжүүлэхийн тулд судруудыг болон бошиглогчдын тунхаглалыг ашигла.”⁵ —Ахлагч Ричард Г.Скотт (1928–2015)

“Бид бүх сайн ном болон бусад сайн эх сурвалжаас үнэнийг байнга эрэлхийлдэг. Хэрэв ариун журамтай, сайхан эсвээс сайн гэгддэг буюу сайшаалтай ямар нэгэн зүйл байдаг бол бид эдгээр зүйлийг эрэлхийлдэг” [Итгэлийн тунхаг 1:13].”⁶ —Ахлагч Дийтр Ф.Угдорф

Та өөрөө үүнийг оролдоод үз!

Дараах жишээнүүд энэ нь хэрхэн хийгдэж болохыг үзүүлнэ. Эдгээр нь бүрэн дүүрэн хариулт биш, зөвхөн залуу эрэгтэй, эмэгтэйчүүд эдгээр асуултад хэрхэн өөрсдөө хариулахыг хичээж

болохыг харуулсан жишээ гэдгийг анхаараарай. Та хариултыг нь олж, гэрчлэлээ хүчирхэгжүүлэхийн тулд, асуух зүйлтэй байгаа сэдвээрээ үргэлжлүүлэн суралцаж мөн залбирах хэрэгтэй.

Биднийг хайрладаг Тэнгэрлэг Эцэг яагаад муу зүйлс тохиолдохыг зөвшөөрдөг вэ?

Итгэлээр үйлд. Би Бурханы миний төлөөх хайрыг мэдэрч байсан бөгөөд Бурхан яагаад муу зүйлс тохиолдохыг зөвшөөрдгийг ойлгодоггүй ч гэсэн Түүний амьдардаг гэдгийг мэднэ. **Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь авч үз:** Сонгох эрх нь авралын төлөвлөгөөний нэгэн чухал хэсэг юм. Бурхан биднийг дэлхий рүү саад бэрхшээл туулж, шийдвэр гарган мөн бие махбодтой болгуулахаар илгээсэн. Хүмүүст шийдвэр гаргахыг зөвшөөрнө гэдэг нь заримдаа хүмүүсийг буруу сонголт хийхэд мөн бусад хүний амьдралд нөлөөлөх болно гэсэн үг. Байгалийн гамшиг, хөгжлийн бэрхшээл, үхэл зэрэг буруу сонголтоор ирдэггүй зовлон бэрхшээл нь Бурханд итгэх итгэл, гэрчлэлээ хүчирхэгжүүлэх боломжийг олгодог.

Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү ихийг ойлгож авахаар эрэлхийл. Бидний хэцүү зүйлийг туулдаг шалтгааны талаар судрууд болон орчин үеийн бошиглогчид юу гэж хэлдэг вэ? “Саад тотгор хийгээд зовлон зүдгүүрүүд чинь хэсэг хугацаанд байх болно; Мөн тэгээд, хэрэв чи үүнийг дажгүй давбал, Бурхан чамайг тэнгэрт өргөмжлөх болно” (С ба Г 121:7–8). Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд “Бурхан биднийг хэзээ ч ганцааранг нь үлдээдэггүй, бидэнд тулгарсан бэрхшээлүүдэд маань тусламж үзүүлэхгүйгээр биднийг хэзээ ч орхидоггүй”⁷ гэж хэлсэн. Би яагаад бэрхшээлтэй тулгарах ёстойгоо мэдэхгүй ч Есүс Христ надад болон бүх хүнд зориулж Цагаатгалыг гүйцэтгэсэн гэдэгт итгэдэг. Би саад бэрхшээлтэй тулгарсан үедээ амар амгалан, хүч чадал, тусалцаа дэмжлэг авахын тулд Түүнд болон Тэнгэрлэг Эцэгт хандаж чадна (Алма 7:11–12-ыг үзнэ үү).



Ариун Сүнс надтай ярьж байгааг би хэрхэн мэдэх вэ?

Итгэлээр үйлд. Надад хэзээ сүнслэг өдөөлт хүлээж авч байгаагаа хэлэх нь заримдаа хэцүү байдаг ч бусдын гэрчлэлийг сонсож, судар уншсанаар Түүний зөвлөгөөг сонсохыг үргэлжлүүлэн хичээх юм бол Сүнс надад туслах болно гэдгийг би мэднэ.

Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь авч үз. Зөв болох зүйлийг хийхээр сүнслэг өдөөлт хүлээн авч болохын тулд Бурхан бидэнд Ариун Сүнсний бэлэг өгдөг. Би сайн зүйлийг үйлдэхээр сүнслэг өдөөлт авч байгаа бол энэ нь миний өөрийн бодол мэт санагдсан ч гэсэн Сүнснээс ирж байгаа гэдгийг нь мэдэж чадна.

Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү ихийг ойлгож авахаар эрэлхийл. Судруудад “Чи даруу бай; тэгвэл чиний Бурхан Их Эзэн чамайг гараас чинь хөтөлж мөн залбирлуудад чинь чамд хариу өгөх болно” (С ба Г 112:10) хэмээн заадаг. Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар “Чин сэтгэлийн хүсэл болон зохистой байдал нь бидний амьдралд илчлэлтийн сүнсийг урьдаг”⁸ хэмээн заасан. Хэрвээ би даруу байхыг мөн Сүнсний хувьд зохистой байхаар чадах бүхнээ хийхийг хичээж байгаа бол Их Эзэн надад хариулт авахаар удирдуулахад минь туслах болно. Тэрээр Сүнс надтай ямархуу байдлаар ярьдгийг зааж өгнө.

Дүгнэлт

Асуулттай байх нь итгэл дутагдаж байгаа тэмдэг биш; энэ нь харин өсөн нэмэгдэж байгаа гэрчлэлийн үзүүлэлт байх нь олонтоо. Та итгэлээр үйлдэн, утга санаа, асуултыг мөнхийн талаас нь авч үзэж, тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлголтыг эрэлхийлэхдээ Есүс Христэд итгэх илүү их итгэлийг болон асуултандаа тустай хариултыг олж авч чадна. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Дийтр Ф.Угдорф, “Ирж, бидэнтэй нэгд,” 2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган.
2. Жэффри Р.Холланд, “Эзэн минь, би итгэж байна,” 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган.
3. Даллин Х.Өүкс, “Тэрээр зүрх сэтгэлдээ тунгаахдаа” (2013 оны 2-р сарын 8-нд залуучуудтай хийсэн Сүмийн Боловсролын Системийн онцгой цугларалт, lds.org/prophets-and-apostles)
4. Гари И.Стивэнсон, “Сүнсэлг хиртэлт,” 2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган.
5. Ричард Г.Скотт, “Acquiring Spiritual Knowledge,” 1993 оны 10-р сарын Ерөнхий чуулган.
6. Дийтр Ф.Угдорф, “Үнэн гэж юу вэ?” (Залуучуудад зориулсан Сүмийн Боловсролын Системийн онцгой цугларалт, 2013 оны 1-р сарын 13), broadcasts.lds.org.
7. Жэффри Р.Холланд, “Тэнгэр элчүүдийн үйлчлэл,” 2008 оны 10-р сарын Ерөнхий чуулган.
8. Дэвид А.Бэднар, “Илчлэлтийн Сүнс,” 2011 оны 4-р сарын Ерөнхий чуулган.

ЭНЭ ЯАЖ БОЛДГИЙГ ҮЗ ДЭЭ

Нэг залуу эмэгтэй асуултандаа хариулт авахын тулд энэ үйл явцыг хэрхэн туулж байгааг үзэхээр “Мэдисоны түүх” видео бичлэгийг үзнэ үү. lds.org/go/71853 руу орно уу.



Би ийм хэцүү
ааштай хүнийг яаж харж
халамжлах юм бэ?

ҮЙЛЧЛЭХЭД

ХЭЦҮҮ ЦАГТ

Лика Т.Валдээ

Миний даван туулахад хамгийн хэцүү байсан зүйлүүдийн нэг нь миний өөрийн “Надад хамаагүй” гэх хандлага байсан юм. Хэрвээ хийж байгаа зүйл минь сонирхол татахгүй бол би хүмүүстэй тэвчээргүй, хөндий харьцдаг байсан.

Нэгэн хичээлийн амралтаар маань надаас 76 настай өвөөгөө халамжлахыг хүсэхэд энэ бүхэн өөрчлөгдсөн юм. Бид түүнийг “Дэди” гэж дууддаг байсан. Тэр цус харваснаасаа болоод биеийн тал хэсэг нь мэдээгүй болсон байв. Гэр бүлийнхэн маань түүнийг хоёр сарын турш халамжлахыг надаас хүсэхэд би яаж хийхээ төсөөлж ч чадахгүй байв.

Би өглөө эртлэн босоод, түүний өглөөний хоолыг бэлтгэх, усанд ороход нь туслах мөн эмийг нь бэлдэх хэрэгтэй байв. Би өдөр тутам дасгалаа хийхэд нь бас алхахад нь тусалдаг байсан. Тэр сайн алхаж чадахгүй байсан болохоор би үргэлж түүний хажууд байж, усанд ороход нь бас бие засахад нь ч хажууд нь байдаг байв. 18 настай охины хувьд энэ нь хамгийн хэцүү байлаа.

Энэ бүхнээс гадна, түүнтэй хамт байхад ер нь л хэцүү байдаг байсан. Тэр Сүмийн гишүүн биш байсан бөгөөд минийхээс өөр зарчим баримталдаг байв. Тэр үргэлж хашгичин, хэзээ ч инээмсэглэдэггүй бас байнга “Би үхэх гэж байна” гэж үглэдэг, харамслаар дүүрэн амьдралтай хүн байв. Түүний энэ хандлагаас болж бид хоорондоо ойр дотно байхад хэцүү байлаа.

Эхлээд би өөрийн хийх ёстой зүйлээс зайлсхийхийн тулд чадах бүхнээ хийдэг байсан ч тэр нь бүтсэнгүй. Тиймээс би хандлагаа өөрчилж, бүх л чадлаараа зүтгэхээр шийдсэн юм.

Ийм шинэ хандлагатайгаар долоо хоног байсны дараа Дэдидээ үйлчлэх нь надад баяр хөөр авчрах болов. Би илүү тэвчээртэй болж, түүний зовлонг ойлгож эхэлсэн. Би түүнд

үйлчилж байхдаа түүнтэй хамт байх цагаа дарамт гэж үзэхээ больж, харин түүнтэй цагийг сайхан өнгөрөөх боломж гэж бодож эхэлсэн.

Дэди ч өөрчлөгдсөн. Царайгаа барайлгасан энэ хөгшин инээсэн, зөөлөн ааштай өвөө болж хувирсан юм. Тэр бүр өсвөр үеийнхэнд зориулсан (Especially for Youth) дуунуудыг ч сонсох дуртай болж билээ.

Нэг орой би түүний чимээ гаргахыг нь сонсоод, юу хийж байсныг нь олж мэдэхээр өрөө рүү нь шагайсан юм. Тэр анх удаагаа залбирч байжээ. Түүний энэ өөрчлөлтөөс би өдөр бүр урам авдаг болов.

Би одоо коллеждоо эргээд явж байгаа ч гэр бүлийнхэнтэйгээ сард хоёр удаа Дэди дээр айлчлахаар очдог. Бид түүнтэй хамт хоол идэж, түүнд дуу дуулж өгдөг. Түүний эрүүл мэнд муудсан болохоор миний түүнд өгч чадах хамгийн хүчирхэг бэлэг бол түүний төлөө залбирах юм.

Би Дэдигээ халамжлах боломжтой байсандаа талархаж байна. Яагаад гэвэл энэ нь бусдад юут өгөх чадвартайгаа харахад надад тусалсан. Хайр маш хүчирхэг бөгөөд Дэди бид хоёрын хоёулангийнх нь зүрх сэтгэлийг зөөлрүүлсэн. Би золиослол болон нинжин сэтгэлийн учир утгыг ойлгож авсан. Энэрэл хайр үнэхээр зүрх сэтгэл бүрийг гэгээрүүлдэг! ■

Зохиогч нь Филиппинийн Сантьягод амьдардаг.



ГЭР БҮЛДЭЭ ҮЙЛЧЛЭХ НЬ

“Эхлээд гэр орон, гэр бүлийнхэндээ үйлчил. Энэ нь мөнхөд байх харилцаа холбоо юм. Гэр бүлийн тань, ялангуяа өөрийн тань нөхцөл байдал төгс биш байсан ч та нар үйлчилж, дэмжиж, хүчирхэгжүүлэх арга замыг хайж олоорой. Яг байгаа газраасаа эхэл. Бусдыг байгаагаар нь хайрла. Хүсэж байгаа ирээдүйн гэр бүлдээ өөрийгөө бэлд.

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Бонни Л.Оскарсон, “Бидний өмнөх хэрэгцээ,” 2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган.



1. СУДРУУДЫГ БОЛОН ОРЧИН ҮЕИЙН БОШИГЛОГЧДЫН СУРГААЛЫГ АШИГЛА (С БА Г 52:9-ИЙГ ҮЗНЭ ҮҮ).

Энэ бол таны хэлэх үгийн гол цөм. Ер нь бидний Сүмд байгаа гол шалтгаануудын нэг нь Есүс Христийн сайн мэдээг зааж мөн суралцах явдал байдаг шүү дээ. Та сэдвээ Судруудын удирдамжийг ашиглан судалж болно (scriptures.lds.org), бас Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг ашиглан судалж болно (gc.lds.org дээрээс сэдвийн хайлт хийнэ үү). Хэлэх үгэндээ ашиглахаар төлөвлөж байгаа судар, эшлэлүүдийг ойлгож байгаа эсэхээ бататгаарай. Хэрвээ тусламж хэрэгтэй бол аав, ээжээсээ эсвэл Сүмийн гишүүдээс асуугаарай.

2. СҮНСИЙГ УРЬ.

Үг хэлэх үедээ Сүнсийг өөртэйгөө хамт байлгахын тулд урьдаас залбирч мөн бэлтгэх нь зөв арга байдаг. Сүнс таны зовнилыг арилгаж, тайвшруулахаас гадна үнэний талаар гэрчилдэг (С ба Г 42:14-ийг үзнэ үү). Өөрийн үнэн гэж итгэдэг зүйлсийн талаар гэрчлэлээ хуваалцсанаар ариун ёслолын цуглаан дээр Сүнсийг урь.

3. ӨӨРТ ТОХИОЛДСОН ТҮҮХИЙН ТАЛААР БОД.

Бусадтай холбогдох хамгийн сайн арга замуудын нэг нь түүхээ хуваалцах явдал юм. Бид бусдад тохиолдсон явдлыг сонсож, тэдний амьдралын талаар сонсох дуртай. Тиймээс өөрт оногдсон сайн мэдээний зарчмын сэдэвтэй холбоотой бөгөөд өөрт тохиолдсон инээдтэй, өвөрмөц, бэрхшээлтэй явдлын талаар бодож олохыг хичээ. Та тэр явдлаас ямар сургамж авсан бэ? Энэ нь танд хэрхэн тусалсан бэ? Хэлэх үгээ хэрхэн эхлэхээ мэдэхгүй байгаа бол ингэж эхлэх нь их сайн арга шүү.

4. АХИН ДАХИН ДАДЛАГА ХИЙ!

Та хэлэх үгээ бичсэнийхээ дараа өөрөө өөртөө, дараа нь гэр бүлийн гишүүд юм уу найзуудынхаа өмнө чанга ярих дадлага хийхийг хүсэж болох юм. Таны хэлэх үг өгөгдсөн хугацаанд багтаж байгаа эсэхийг мөн тодруулж хэлэх хэрэгтэй хэсгүүд байгаа эсэхийг олж мэдэж чадна. Хэрвээ бишоп чинь зөвшөөрвөл, та Сүмийн байр руу өмнө нь очиж, индэр дээрээс үг хэлэн, дадлага хийж болно.



ХЭЛЭХЭД ТУСЛАХ ДОЛООН ЗҮЙЛ

*Ариун ёслолын цуглаан
дээр удахгүй үг хэлэх гэж
байна уу? Дараах аргуудыг
туршиж үзээрэй.*

Сара Хэнсон

Та нар яадгийг мэдэхгүй, гэхдээ намайг ариун ёслолын цуглаан дээр үг хэлэхээр хуваарилах үед би хэлэх үгээ бичих тухайд биш, харин үгээ хэрхэн хэлэх тухайд их санаа зовдог. Би дандаа “Би дэндүү уйтгартай байвал яана аа? Би ямар нэгэн зүйл хэлэхээ мартвал яана аа? Би буруу үг хэлчихвэл яана аа?” гэх мэтээр санаа зовдог.

Та нарт ингэж бодогдож байсан уу? (Ингэж бодож байсан хүн нь би ганцаараа биш байх гэж найдаж байна.) Тийм бол, энэ нь дэлхийн төгсгөл биш шүү. Ярих чадвараа нэмэгдүүлж, сонирхолтой үг хэлэхэд туслах дараах долоон аргыг туршиж үзээрэй.

ҮГ ХЭЛЭХ

5. “БИ ЭНД БАЙМААРГҮЙ БАЙНА” ГЭСЭН БАЙДЛААР ҮГЭЭ ЭХЛЭХЭЭС ЗАЙЛСХИЙ.

Эхний энэ үгийг ямар ч байдлаар илэрхийлж болох ч сонсогчдын ихэнх нь үүнийг даруй мэдэрдэг. Ихэнхдээ хүмүүс “Бишоп надаас үг хэлэх үү гэж асуухаар над руу утасдахад нь би үүнээс гарах шалтгаан хайхыг хичээсэн” гэж хэлдэг. Сүмийн ихэнх гишүүн үг хэлэхэд их хэцүү байдгийг ойлгодог ч таныг ерөнхийдөө “Би энд баймааргүй байна” гэж хэлэхэд хүмүүс үүнийг “Намайг битгий сонсоорой” гэж хэлж байгаа мэт сонсдог. Ийм байдлаар үгээ эхлэхээс зайлсхийж, өөрийн хэлэх сэдэвт урам зоригтой ханд!

6. ойлгомжтой ярь. Хэн нэгэн хүн

сандарснаасаа болж дэндүү хурдан эсвэл дэндүү намуухан ярих нь олонтоо тохиолддог. Би ч бас ингэж байсан. Гэхдээ цугласан олон таныг ойлгож болохын тулд үг хэлэхдээ ойлгомжтой ярих нь маш чухал. Үгээ удаан бөгөөд тод, чанга хэлж ярихад санаа тавь (тийм ээ, микрофонтой ч гэсэн дэндүү намуухан байж магадгүй юм шүү.) Хүмүүс таны хэлэх зүйлийг сонсохыг хүсэж байгаа!

7. толгойгоо өндийлгө. Харц тулгарах

нь сайн холбоо харилцааны маш чухал тал юм. Энэ нь та яриандаа чин сэтгэлээсээ төвлөрч, хандаж байгааг харуулдаг. Та үг хэлэхдээ цугласан олны хүн бүртэй харц тулгарах хэрэгтэй биш, гэхдээ та үе үе өрөөний урд эсвэл хойд хэсэг рүү харж байх юм бол маш сонирхолтой үг хэлж буй хүн байх болно. Бичсэн үгнээсээ хараа салгахгүй байхаас зайлсхий. Сонсож байгаа хүмүүс таны зулайг биш, таны инээмсэглэлийг харахыг хүсэж байгаа.

Энэ долоон аргыг дагасан ч гэсэн та үгээ буруу хэлж эсвэл гуравдугаар эгнээнд хэн нэгэн дутхийж байгааг анзаарч болох юм. Гэхдээ энэ нь та үгээ маш муу хэлсэн гэсэн үг үү? Мэдээж, үгүй!

Бид тавтай таатай орчноос бага зэрэг л гарахад санаа зовж, жижиг алдаа гаргах нь ердийн хэрэг байдаг. Гэхдээ, та чадах бүхнээ хийж, Сүнсний урихаар хичээх аваас хэлэх үгэндээ гацах эсвэл нэг юмыг мартах эсэх нь хамаагүй. Та Бурханы ажлыг хийж байгаа бөгөөд Түүний хүүхдүүдэд сайн мэдээний талаар илүү ихийг ойлгож мэдэхэд нь тусалж байгаа билээ.

Хэрвээ та өөрийн итгэдэг зүйлсийн талаар зааж, гэрчлэх юм бол бүх зүйл зүгээр өнгөрөх болно. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.



Бид ариун сүмд юу хийдэг вэ?

Ариун сүм бол Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд ойртож чадах ариун газар юм. Ариун сүмд бид чухал үнэнийг заалгаж, санваарын ёслолуудад (ариун нандин ёслолуудад) оролцож мөн Бурхантай гэрээ байгуулдаг (ариун амлалтууд авдаг) бөгөөд эдгээр нь биднийг Түүний дэргэд эргэж очиход бэлтгэдэг.

Бид өөрсдийнхөө төлөө болон өөрсдийн өвөг дээдсийн төлөө ариун сүмийн ёслолуудыг хүлээж авч чаддаг. Жишээлбэл, амьд байхдаа зохих эрх мэдэлтэй хүнээр баптисм хүртэх боломжгүй байсан өвөг дээдсийнхээ болон бусдын өмнөөс өсвөр үеийнхэн баптисмуудад оролцож болдог. Насанд хүрэгчдийн оролцдог ариун сүмийн бусад ёслолд хишиг хүртэх, лацдан холбуулах (ариун сүмийн гэрлэлт гэх мэт) зэрэг ёслол багтдаг.



Өвөг дээдсийнхөө төлөө баптисм хүртэж, гишүүнээр батлуулах

Баптисм хүртэж, гишүүнээр батлуулах нь дэлхий дээр амьдарч байсан, хариуцлага хүлээх чадвартай хүн бүрийн авралд шаардлагатай юм (Иохан 3:5-ыг үзнэ үү). Гэсэн хэдий ч олон хүн сайн мэдээний талаар сонсолгүй эсвэл авралын ёслолуудыг хүлээн авалгүй нас барсан. Есүс Христийн ач ивээл, нигүүлслээр дамжуулан эдгээр адислагыг хүлээн авах арга зам хүн болгонд зориулагдан бэлтгэгдсэн билээ. Ариун сүмүүдэд, Сүмийн зохистой гишүүд нас барагсдын өмнөөс баптисмыг гүйцэтгэж болдог. Сүнсний дэлхийд сайн мэдээг номлодог (С ба Г 138-ыг үзнэ үү) бөгөөд сонссон хүмүүс нь үүнийг болон өөрсдийнх нь өмнөөс гүйцэтгэгдсэн ёслолуудыг хүлээн зөвшөөрөхөөр сонгож болдог.

ТА ХЭРХЭН БЭЛТГЭЖ БАЙНА ВЭ?

Баптисмын гэрээнүүдээ сахих нь ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахад бэлтгэхэд тань хэрхэн тусалдаг вэ?

.....
.....
.....

Та ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахад бэлэн байхын тулд өөр юу хийх хэрэгтэй байна вэ?

.....
.....
.....

Таны ариун сүмийн эрхийн бичиг хүчинтэй байгаа юу? Хэрэв танд эрхийн бичиг байхгүй бол та бишоп, салбарын ерөнхийлөгчтэйгөө цаг тохирч болно.

.....



Ариун сүм рүү анх удаа явах талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл [lds.org/temples](https://www.lds.org/temples) гээрээс “Inside Temples” гэдгийг үзнэ үү.



АРИУН СҮМ: ИТГЭЛИЙН БЭЛГЭДЭЛ

Ариун сүм бүр нь Бурханд итгэх бидний итгэлийн бэлгэдэл, үхлийн дараах амьдралд итгэх бидний итгэлийн нотолгоо мөн. Ариун сүм бол бүхий л үйл ажиллагаа, хичээл, Сүм дэх аливаа дэвшилт алхам бүхэн болдог газар юм. Сайн мэдээг тунхаглах, гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэх, нас барагсдыг гэтэлгэх бидний бүхий л хүч чармайлт биднийг ариун сүм рүү хөтөлдөг.

Расселл М.Нэлсон, “Ариун сүмийн адислалд бэлтгэгтүн,” *Лиахона*, 2010 оны 10-р сар, 41.

Хишиг хүртэх

Хишиг гэдэг үг “бэлэг” гэсэн утгатай. Ариун сүмийн хишиг бол Бурханаас өгөгдсөн бэлэг бөгөөд Тэрээр энд онцгой адислалуудыг танд “тэнгэрийн хүчээр” (С ба Г 95:8) өгдөг.

Та Сүмд нэгдэхдээ баптисм, гишүүний баталгаа гэсэн хоёр ёслолыг хүлээн авсан. Түүнчлэн ариун сүмийн хишгийг хоёр хэсгээр хүлээж авдаг. Эхлээд та анхны ёслолуудыг хүлээн авах бөгөөд бэлгэдлээр болон зохих ёсоор цэвэр болж, “утаагдан” мөн тэнгэрлэг өв, мөнхийн чадавхынхаа талаар онцгой адислал хүлээн авдаг. Хоёр дахь хэсэгт та Бүтээлт, бидний дэлхий дээрх зорилго, Есүс Христийн Цагаатгал, номлол зэргийг багтаасан авралын төлөвлөгөөний талаар илүү суралцах үедээ хишгийнхээ үлдсэн хэсгийг хүлээж авдаг.

Хишгийн үеэр бид Бурханд дуулгавартай байж, Есүс Христийг дагаж мөн ёс суртахууны хувьд цэвэр байж, Бурханы хаант улсыг барихад туслах чанд амлалтуудыг өгдөг. Хэрэв бид гэрээнүүдээ сахивал Бурханы бүх мөнхийн адислалыг хүлээн авах амлалт бидэнд өгөгдсөн юм.

Лацдан холболт

Бурханы төлөвлөгөөний төвд гэр бүлүүд байдаг нь бидний аз жаргалын төлөө билээ. Гэр бүлүүдийг мөнхөд нэгтгэх нь санваарын лацдан холбох эрх мэдлээр дамжуулан авах, ариун сүмд хүртэх боломжтой дээд адислал юм. Энэ эрх мэдэл нь Есүсийн төлөөлөгчдөдөө ярьсан тэрхүү эрх мэдэл юм (Матай 16:19-ийг үзнэ үү). Ариун сүмийн лацдан холболт эхнэр, нөхрийг хооронд нь мөн хүүхдүүдийг аав, ээжтэй нь холбож, өөрсдийн хийсэн гэрээнд үнэнч байснаар мөнхөд хамтдаа байх боломжийг олгодог. ■

ХҮНДЭТГЭЛИЙН өдрөөр мэдрэх

Би Хүндэтгэлийн өдөрт дуртай байх хэрэгтэй гэдгээ мэдэж байсан ч яаж гэдгээ мэдэхгүй байлаа.

Алисса Нийлсэн

Судруудад Хүндэтгэлийн өдрийг ариун өдөр, баясгалант сайхан өдөр, амралтын өдөр, тэмдэглэх өдөр гэж хэлсэн байдаг.¹ Гэхдээ цөөн хэдэн жилийн өмнө, арван хэдэн настай байхдаа би Хүндэтгэлийн өдрийг ядаргаатай гэж боддог байв. Би амар амгаланг мэдрэхийн оронд сэтгэлийн дарамтыг мэдэрдэг байсан. Мөн би баяр хөөрийн оронд уйтгар гунигийг мэдэрдэг байсан. Би найдварын оронд, гэмшил мэдэрдэг байсан. Би Хүндэтгэлийн өдрөөр уйтгар гунигийг бүрэн мэдэрч байв.

Ням гаргийн өглөө бүр, хөнжил дотроо хүнээс ичмээр удаан

нуугдсаныхаа дараа би эцэст нь ням гараг гэдгийг өөрийн эрхгүй хүлээн зөвшөөрч, Сүм рүү явахдаа өмсдөг хувцсаа өмсдөг байлаа. Сүм дээр очоод би өнгөрсөн долоо хоногийнхоо тухай дүгнэн боддог байсан юм. Ариун ёслолын үеэр, би гаргасан алдаануудаа нэмж, энэ жагсаалтаа эхний хүнийг үг хэлэхээр босохоос өмнө дуусгаж чаддаггүй байлаа. Цуглааны үлдсэн хугацаанд Сүм дээр байх дургүй байгаадаа харамссан сэтгэлээсээ болж гэмшил төрөн, нулимсаа гаргахгүй байхыг хичээн өнгөрөөдөг байлаа.

Тэр өдөр бас л тийм байв. Би хийсэн сонголтуудынхаа талаар гэмшиж, ирээдүйн сонголтуудаа

зовниж мөн одоогийн нөхцөл байдлын талаар бодоод уйтгарлан, гунигладаг байсан. Би сургууль, нэмэлт үйл ажиллагаа байгаа үед сатаардгаас бусад үед сөрөг зүйл бодож цагаа өнгөрөөдөг байв.

Би 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоний хэлсэн Хүндэтгэлийн өдөр хэрхэн баясгалант өдөр байдаг тухай үгийг сонсож, ахин дахин уншсаныхаа дараа Хүндэтгэлийн өдрөөр одоо мэдэрч байгаа зовлон гунигийг биш, харин амар амгалан, хайрыг мэдрэхийн төлөө залбирсан.² Мөн хариулт нь ирсэн.



УЙТГАР ГУНИГ

Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ дээр төвлөр

Туулж байгаа зовлондоо бодлоо төвлөрүүлэхээ больж, харин Тэнгэрлэг Эцэгтэй болон Аврагчтай харьцах харьцаан дээрээ анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй гэсэн сүнслэг бодол надад төрсөн юм. Би хийсэн буруу зүйлээ тунгаан бодохын оронд, амьдралд минь Тэдний хэрхэн оролцож байгааг тунгаан бодох цаг гаргав.

Сөрөг бодлууд орж ирэх үед би Бурханы болон Есүс Христийн талаар өөрийн мэддэг бас итгэдэг зүйлээ мөн Бурханы хүүхэд гэдгээ өөрөө өөртөө хэлж байсан. Тэр надад хайртай. Есүс Христ бол миний Ах бөгөөд миний төлөө

Цагаатгал хийсэн. Тэд намайг баяр хөөртэй байж, Өөрсөд рүү нь эргэж ирээсэй хэмээн хүсдэг. Хүндэтгэлийн өдөр нь Бурханаас өгөгдсөн бэлэг юм.

Би энэхүү гэрчлэлдээ итгэлээ хэрэгжүүлж эхэлсэн.

Ариун ёслолыг идэвхтэй хүлээн авах

Юунд анхаарлаа төвлөрүүлэх вэ гэдгээ өөрчилсөн минь ариун ёслолд хэрхэн хандаж байгаа талаараа бодоход хүргэсэн юм. Маш удаан хугацааны туршид би ариун ёслолыг өөрийгөө шийтгэх цаг болгосон байв. Гэтэл ариун ёслолын зорилго нь энэ биш шүү дээ. Ариун ёслол нь гэрээнүүдээ шинэчлэх ариун нандин ёслол юм. Энэ нь Есүс Христийн цагаатгах хүчээр дамжуулан дахин цэвэр болох боломж юм. Би итгэлээр болон наманчлагч сэтгэл зүрхтэйгээр ёслол, гэрээндээ анхаарал төвлөрүүлснээр өршөөлийн бэлгийг хүлээн авч, гэрээнүүдээ сахидгийг мөн Их Эзэний Сүнсийг хүлээж

авснаар ариун ёслол амар амгалант өгдөг болохыг ухаарсан (С ба Г 20:77, 79-ийг үзнэ үү).

Ариун ёслолын туршид Христийн Цагаатгалыг бодох нь миний оюун санаанд өөр нэгэн бэлгийг авчирсан. Би өршөөгдөх боломжтой төдийгүй, Аврагч маань Өөр дээрээ миний шаналлыг авсан учраас би бас эдгээлтийг хүлээн авч чадах юм (Алма 7:11–12-ыг үзнэ үү). Түүний Цагаатгалаар болон ариун ёслолоор дамжуулан санаа зовнил, уйтгар гунигийн оронд би амар амгалан болоод хүч чадлыг Хүндэтгэлийн өдөр мөн өөр ямар ч өдөр олж авч чадна.

Мөн би тэрхүү амар амгалант олсон юм. Миний Аврагч ням гаргуудад төдийгүй үргэлж надтай хамт байдаг!

Итгэлтэй байх дадлагыг тэвчээртэй хий

Энэ нь нэг долоо хоногт зассан зүйл биш байсан. Энэ нь хэцүү байсан бөгөөд цаг хугацаа шаардсан. “Харин бид харахгүй байгаа зүйлдээ найдвал түүнийгээ тэвчээртэйгээр хүлээдэг” (Ром 8:25). Би анхаарлаа төвлөрүүлж байгаа зүйл дээрээ анхаарч, Хүндэтгэлийн өдрийг хайрлахын төлөө залбирч байсан.

Яваандаа, би тэр ариун өдөр амар амгалан болоод баяр хөөрийг олсон ба үргэлжлүүлэн хичээж байсан. Хэрэв үргэлжлүүлэн хичээгээгүй байсан бол би Хүндэтгэлийн өдрийн уйтгар гунигийг ахин мэдрэх байсан байх. Долоо хоног бүр Аврагч дээр болон Хүндэтгэлийн өдрийн зорилго дээр хичээнгүйгээр анхаарлаа төвлөрүүлэхийг шаарддаг ч гэсэн амар амгалан болоод баяр хөөр өгнө гэсэн амлаалт нь үнэн гэдгийг би мэднэ. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. Египетээс гарсан нь 20:11; Египетээс гарсан нь 31:15; Левит 23:32; Исаиа 58:13; Сургаал ба Гэрээ 59:13-ыг үзнэ үү.
2. (Рассэлл М.Нэлсон, “Хүндэтгэлийн өдөр нь баясгалант өдөр билээ,” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 122.)

ЗАДАНИЕ

БҮТЭН САР



БОЛ БУСАД



БАЙДЛА

Та ариун сүмд орох зохистой байж чадна

Ахлагч Квинтин Л.Күк

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга

Сүмийн гишүүдээсээ бид ариун сүмийн эрхийн бичиг авахуйц зохистой амьдраасай хэмээн чин сэтгэлээсээ хүсдэг билээ. Ариун сүмийг хол, магадгүй хүрч чадахгүй зорилго гэж битгий хараарай. Ихэнх гишүүн маань бишоптойгоо хамт ажиллан, шаардлага хангахын төлөө тууштай байж, гэм нүглээ бүрэн наманчилснаар бүх зөв шударга жишигт харьцангуй богино хугацаанд хүрч чадна. Үүнд өөрсдийгөө уучлах хүсэлтэй байж мөн сул тал, нүглүүд нь ариун сүмд ороход саад болж байна гэдэгт төвлөрөхгүй байх хэрэгтэй.

Аврагчийн Цагаатгал Бурханы бүх хүүхдийн төлөө хийгдсэн. Түүний гэтэлгэгч золиослол нүглээ үнэхээр наманчилсан хүмүүсийн төлөөх шударга ёсны шаардлагыг хангадаг. Үүнийг судар дээр:

“Та нарын нүглүүд час улаан мэт боловч цас шиг цагаан болно” (Исаиа 1:18).

“Би тэдний нүглийг дахин санахгүй” (Иеремиа 31:34) хэмээн маш уран сайхан тодорхойлсон байдаг.

Шударга зарчмуудаар амьдрах нь танд болон таны гэр бүлд аз жаргал, биелүүлсэн гэх сэтгэл ханамж болон амар амгаланг авчирна гэдгийг бид амлаж байна. Насанд хүрсэн болон өсвөр насны гишүүд маань зохистой байдлаа ариун сүмийн эрхийн

бичгийн асуултуудад хариулахдаа өөрсдөө тодорхойлдог. Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христийн болон Түүний сайн мэдээний Сэргээлтийн гэрчлэлээ нэмэгдүүлж, Ариун Сүнсний тохинууллыг мэдрэх нь чухал шаардлага юм.

Хүн бүрийг ариун сүмд орохуйц зохистой болохын тулд шаардлагатай өөрчлөлтүүдийг хийгээсэй хэмээн бид чин сэтгэлээсээ хүсдгийг ойлгоорой. Амьдрал тань аль зүгт явж байгааг залбирч тодорхойлон, Сүнсний удирдамжийг эрэлхийлж, ариун сүмд ороход хэрхэн бэлдэх талаар бишоптойгоо ярилцаарай. Ерөнхийлөгч Томас С.Монсон (1927–2018) “та нарын хувьд ариун сүмд орохуйц зохистой байхын төлөө ажиллахаас илүүтэй чухал зорилго гэж үгүй”¹ гэж хэлсэн.

Бидний хүн нэг бүр Аврагчийг хүндэтгэн, шаардлагатай өөрчлөлтүүдийг хийж, Түүний эрхэм нандин ариун сүмүүдэд өөрсдийгөө харахын төлөө би залбирч байна. Ингэснээр бид Түүний ариун зорилгуудыг биелүүлж, Их Эзэний болон Түүний Сүмийн энэ амьдралд хийгээд мөнхөд хүртээх адислалуудад өөрсдийгөө мөн гэр бүлээ бэлтгэж чадах болно. ■

2016 оны дөрөвдүгээр сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс авав.

ЭШЛЭЛ

1. Томас С.Монсон “Ариун сүм—дэлхийн гэрэлт цамхаг,” 2011 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 95.



1940 оны
9-р сарын 8-нд
**Юта мужийн
Логанд**
төржээ

1960–1962 онд тэр
**Британи
номлолд**

үйлчилсэн ба түүний
хамтрагчдын нэг
нь ахлагч Жэффри
Р.Холланд байжээ.



2007 оны 10-р сарын 6-нд

**Арван хоёр
Төлөөлөгчийн
Чуулгын**

гишүүнээр батлагдсан



Тэр ахлах
сургуулийнхаа

**сагсан
бөмбөгийн
болон
америк хөл
бөмбөгийн**

багт орж,
мужийн аварга
шалгаруулах
тэмцээнд тоглож
байсан.

1962 оны
11-р сарын 30-нд
**Логан Юта
ариун сүмд**

Мари Гэггитэй
гэрлэсэн



Тэр **3 хүүхэд,
11 ач, зээтэй**



Изабэллийн аялал



Жэссика Ларсэн

Бодит түүхээс сэдэвлэв

Бразил, 1992

Изабэлл гүн цэнхэр тэнгэр өөд нүдээ онийлгон харав. Ямар ч үүл харагдсангүй. Тэр хатсан уруулаа норгов.

Түүний аав, ээж хоёр нь гадасны ерөнхийлөгч Сантьяготой аяархан ярилцаж байв. Завины мотор маш чанга байсан учраас тэр тэдний ярихыг сонсож чадахгүй байлаа. Гэхдээ тэдний юу ярьж байгааг тэр мэдэж байв. Уух ус дуусчихсан байсан.

Изабэлл өөрсдийн аяны гол шалтгаан дээр анхаарлаа төвлөрүүлэхийг хичээж байлаа. Тэд гэр бүлээрээ лацдан холбуулахаар ариун сүм рүү явж байв. Тэр жаахан охин байхаасаа л аав, ээж хоёрынхоо Сао Пауло дахь үзэсгэлэнт ариун сүмийн талаар ярьж байсныг санадаг байв. Тийшээ явах нь бараг л үлгэр мэт санагдаж байлаа. Изабэллийн гэр бүл Амазоны гүн ой дотор Манауст амьдардаг байсан бөгөөд ариун сүм 2000 гаруй милийн (3219 км) зайд байдаг байв.

Тэгтэл ерөнхийлөгч Сантьяго тэнд очих зургаан өдрийн аяныг төлөвлөв. 100 гаруй гишүүн явахаар шийдсэн байна. *Ээж нь* түүнд “Энэ нь золиослол болох болно, гэхдээ золиослол адислал авчирдаг” гэж хэлсэн байв.

Эхлээд аян нь сэтгэл хөдөлгөм байлаа. Тэд завины тавцан дээр өлгөдөг оронд унтаж, дуулал дуулж мөн судар уншиж байсан.

Тэгтэл уух ус дууссан байсан бөгөөд голын ус уухад дэндүү бохир байв.

Изабэлл *ээжийгээ* гаранд нь хүрэхийг мэдэрчээ. Тэр “Ерөнхийлөгч Сантьяго биднийг нэг дор цуглуулж байгаа мөн бид бороо орохын төлөө залбирна” гэж хэлэв.


Изабэлл тэр хүмүүстэй нэгдэн, залбирал ч эхлэв. Залбирч дууссаны дараа тэр хүзүүн дээр нь хүйтэн агаар сэрвэгнэхийг мэдэрчээ. Тэр завины хажуу руу гүйн очоод, дуу алдав. Шуурганы саарал үүлнүүд тэдний зүг нүүж байлаа. Удалгүй бороо цутган орж эхэлжээ. Тэр борооны дуслыг уухаар амаа ангайж байлаа.

Ээж нь “Хурдал!” “Сав, түмпэн, юу ч хамаагүй бариад тос” гэж хашгирав.

Изабэлл сав аваад, гараа сунгав. Тэр чадахынхаа хэрээр ус тосохыг хүсэж байлаа. Хүн бүр инээн, баярлан, хамтдаа хөдөлмөрлөсөн юм. Удалгүй тэд усанд нэвт нордог маш том үдэшлэг хийж байгаа мэт байв. Бороо 15 минут үргэлжилжээ. Энэ нь тэдэнд өөрсдөдөө хэрэгтэй усаа нөөцөлж авах хангалттай хугацаа байв. Энэ бол гайхамшиг байлаа.

Удалгүй завь нь газарт хүрсэн юм. Гэхдээ тэд цааш 1500 миль (2414 км) явах хэрэгтэй байв. Аяллын цаад хэсэгт хүн бүр автобусаар аянаа үргэлжлүүлсэн юм. Хэдэн өдрийн туршид автобус нь бартаат замаар донслон явж байлаа. Нэг удаа хүчтэй донсолсноос

*Аян зам нь удаан, аюултай
байх хэдий ч ариун сүмд очих
нь үнэ цэнтэй байх болно.*



ҮНЭЛЖ БАРШГҮЙ АДИСЛАЛУУД

“Ариун сүмийн адислалуудыг үнэлж баршгүй юм.”

Ерөнхийлөгч Томас С. Монсон (1927–2018), “Ариун сүмийн адислалууд,” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 77.



цонхны шил нь хагарчээ. Заримдаа тэд халуун, хүн ихтэй хотын дундуур явж байв. Гэхдээ хотод ядаж л зам нь гайгүй, тийм ч их донсолгоотой байсангүй.

Тэд аль нэг тосгон юм уу хотод юм идэхээр зогсоход хүн бүр дандаа баяртай байдаг байсан. Тэд замдаа Сүмийн байруудад эсвэл Сүмийн гишүүдтэй хамт ундалж байлаа. Эхний орой нь тэд их орой ирсэн болохоор Изабэлл хэн ч хүлээгээгүй байх даа гэж санаа нь зовж байв. *Ээж нь* “Битгий санаа зов. Хар даа!” гэж ядрангуйгаар инээмсэглэн хэлэв.

Салбарын ерөнхийлөгч болон Сүмийн гишүүд зам даган зогсоод, хүлээж байлаа. Тэд “Золиослол адислал авчирдаг” гэсэн бичигтэй самбар барьсан байв. Изабэлл инээмсэглэв. *Ээжийнх нь* зөв байлаа!

Гурван өдөр донслон давхисны дараа бид эцсийн эцэст Сао Паулод хүрсэн юм. Изабэлл муруй замаар эргэх үед илүү сайн харахын тулд суудал дээрээ босож зогсов. Гэнэт автобусанд байсан бүх хүн баяр хөөртэйгөөр “*Ариун сүм! Ариун сүм*” хэмээн дуу алдацгаав. Тэд эгнүүлэн тарьсан далдуу модны дээгүүр ариун сүмийн өндөр, шовх орой цухуйж байхыг харж байв. Тэнгэр элч алтан Моронай нарны туяанд гялалзан байв.

Хүн бүр эцэж ядарсан байсан ч хэн ч амрахыг хүссэнгүй. Тэд тэр даруй лацдан холбуулахыг хүсэж байлаа. Изабэллийн гэрийнхний лацдан холбуулах цаг болоход тэрээр цагаан хувцсаа нямбайлан өмсөв. Тэр лацдан холбох өрөөнд орохдоо аавынхаа нүүр дүүрэн инээж байгааг харлаа. *Ээжийнх нь* нүүрээр баярын нулимс урсаж байв. Тэдний аялал урт удаан, бүр аюултай байсан. “Гэхдээ золиослол маань үр дүнгээ өглөө” гэж Изабэлл бодов. Изабэлл гэр бүлтэйгээ лацдан холбуулахаар суудлаа эзлэхдээ инээмсэглэж байлаа. ■

Зохиогч нь АНУ-ын Техаст амьдардаг.



2012 онд Изабэллийн өссөн Бразилийн Манауст ариун сүм баригдсан юм. Тэр үед Изабэлл болон бусад хүүхэд нь өсөж том болоод өөрсдийн гэсэн гэр бүлтэй болсон байв. Тэдний олон нь энэ үзэсгэлэнтэй ариун сүмийг үзэхээр ирсэн бөгөөд өөрсдийн аяллыг дурсан санадаг.

“Энд дэлхий дээр надад гэр бүл бий. Тэд надад сайн ханддаг” (Хүүхдийн дууны ном, 188).

“Эндрю! Автобус ирчихсэн шүү” гэж эмээ нь дуудав. Эндрю хаалгаар яаран гарлаа. Тэр эмээ, өвөө, дүү Эми нар руугаа гараараа даллав. Эми сургуульд явахад дэндүү жаахан байсан учраас эмээ, өвөө хоёртойгоо гэртээ үлддэг байсан.

Эндрю сургуульдаа дуртай байлаа. Тэр завсарлагаанаар найзуудтайгаа тоглох дуртай. Тэр бас Мисс Кимбалл багшдаа дуртай байв.

Өглөөний завсарлагааны дараа Мисс Кимбалл “Дараагийн долоо хоногт бид Эцэг эхийн өдөрлөгтэй. Эцэг эхдээ, ирэхдээ ажил дээрээсээ бидэнд үзүүлэх ямар нэгэн зүйл авчраарай гэж хэлээрэй. Бид тэднийг

Эндрю сургуулийн Эцэг эхийн өдөрлөгөөр яах ийх талаар юу гэж бодохоо мэдэхгүй байв.

Сайн
ӨВӨӨ, ЭМЭЭ



сонсохыг тэсэн ядан хүлээж байна” гэж хэлэв.

Эндрюгийн нүүр халуу оргих шиг болов. Түүнд аав, ээжийнхээ талаар хэлэх юу ч байсангүй. Тэр ээжийнхээ талаар сайн санадаггүй байв. Түүнийг жаахан байхад нь ээж нь орхисон байлаа. Тэр аавыгаа бүр огт мэддэггүй.

Бусад хүүхэд аав, ээжийнхээ талаар ярихыг нь Эндрю сонсов. Тонигийн ээж гал сөнөөгч, Жэссикагийн аав амьтны хүрээлэнд ажилладаг. Хүүхэд болгон аавыг нь сармагчин юм уу удаан хөдөлгөөнтэй амьтан авчраасай гэж хүсэж байв.

“Танай аав, ээж хоёр яах вэ?” гэж Тони Эндрюгээс асуулаа.

Эндрю доош тонгойн, хөл рүүгээ хараад, мөрөө хавчин, “Би өвөө, эмээ хоёртойгоо амьдардаг” гэж хэлэв.

Эндрю өвөө, эмээдээ хайртай. Гэхдээ тэд гоё ажил хийдэггүй. Эмээ нь хөнжил, нялх хүүхдийн хувцас зардаг байсан. Өвөө нь хоол зөөдөг том машин барьдаг байв. Эндрю Эцэг эхийн өдөрлөгөөр яах ийх талаар юу гэж бодохоо мэдэхгүй байлаа.



Тэр орой Эндрю Мормоны Номын эхний бүлгээс “Би, Нифай, буянт сайн эцэг эхээс мэндэлсний учир, . . .” (1 Нифай 1:1) хэмээн уншив.

Эндрю “Би аав, ээжтэйгээ амьдардаггүй. Би өвөө, эмээтэйгээ л амьдардаг” гэж бодов.

Яг тэр үед Эми Эндрюгийн өрөөнд зөөлөн хөнжил тэвэрсээр орж ирлээ. Тэр үүнийгээ Эндрюд харуулахаар өргөж, “Эмээ хийсэн” гэж хэлэв.

“Тийм ээ, эмээ танд энэ хөнжлийг хийж өгсөн.” Эндрю инээмсэглэлээ.

Тэр эмээгийнхээ өөрийнх нь төлөө хийж өгдөг сайхан зүйлсийн талаар буюу сургуульд явахын өмнө өглөөний хоол хийж өгч, гэрийн даалгавар хийхэд нь туслан, Эми тэр хоёртой тоглоом тоглодог талаар бодов. Эмээ нь яг л ээж хүн шиг байдаг байв.

Тэгээд Эндрю өвөөгийнхөө талаар бодлоо. Өвөө нь орой бүр Эндрюд түүх уншиж өгдөг. Тэр бас гэрийн даалгаварт нь тусалдаг байлаа. Тэр бас Эндрюд дугуй яаж унахыг зааж өгсөн. Өвөө нь яг л аав хүн шиг байдаг байв.

Эндрю нүүр дүүрэн инээмсэглэлээ. Тэр эмээ, өвөө хоёртоо маш их талархаж байв. Гэхдээ тэр эмээ өвөөгөө сургууль дээр авчрах талаар санаа зовж байлаа. Гэхдээ бүх зүйл зүгээр болно доо. Тэр “Би буянт сайн эцэг эхгүй байж болно, гэхдээ би буянт сайн өвөө эмээтэй, тэр л маш онцгой сайхан зүйл” гэж бодлоо.

Эцэг эхийн өдөрлөг дээр Эндрю ангийн арын хэсэгт өвөөтэйгөө суун, бусад хүүхдийн эцэг эхийн ярихыг сонсож суув. Тонигийн ээж гал сөнөөгчийнхөө хувцсыг авчирчээ. Тэр хүүхэд болгонд гал сөнөөгчийн малгайгаа өмсүүлж үзүүлэв. Жэссикагийн аав амьтны хүрээлэнгээс яст мэлхий авчирч үзүүлсэн.

Мисс Кимбалл “Эндрю, чиний ээлж” гэж хэлэв.

Эндрю өвөөгийнхөө хамтаар ангийн урд хэсэг рүү алхлаа. Тэр гүнзгий амьсгаа аваад, “Манай өвөө том машин барьдаг бас хоол хүргэж өгдөг. Тэр олон хүнтэй уулздаг бас маш их шаргуу ажилладаг” гэж хэлэв.

Эндрюг өвөө рүүгээ харахад өвөө нь инээмсэглэж байв. Тэгээд өвөө нь том машин барьдаг талаараа ярилаа. Тэр бас ажлаасаа авчирсан амттанаа хүүхэд бүрд өгөв. Эндрюгийн ангийн хүүхдүүд өвөөгөөс нь ажлынх нь талаар олон зүйл асуужээ.

Эндрю өвөөгөө ирсэнд маш их баяртай байв. Тэр өвөө, эмээ, Эмитэйгээ хамт нэг гэр бүл бөгөөд тэд буянт сайн хүмүүс. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЭЦЭСТ НЬ
МӨНХИЙН
ГЭР БҮЛ
БОЛОВ



Жэйн Макбрайд

Бодит түүхээс сэдэвлэв

“Газарт лацадсан болгон чинь тэнгэрт лацдагдах болно” (Хиламан 10:7).

Миа “Тэр бүлүүд мөнх” гэдэг нь юу гэсэн утгатай вэ? гэж асуугаад, тоглоомны нэг жижиг хэсгийг урагш хөдөлгөлөө. Тэр сайн найз Зөүитэйгээ том өрөөнд нь тоглоом тоглож байв. Ханан дээр нь “Тэр бүлүүд мөнх” гэсэн бичигтэй зураг байлаа. Миад энэ нь сайхан сонсогдож байв.

Зөүи “Энэ нь бүр нас барсныхаа дараа ч гэр бүл хэвээр үлдэнэ” гэсэн үг гэж тайлбарлав. Тэр нэг хөзөр тавиад, тоглоомын хэсгээ хөдөлгөв.

Миа өрөөг тойруулан харав. Бүх зүйл ердийн харагдаж байлаа. Буйдан, ширээ, дэрнүүд, зурагт гээд. Гэсэн ч Зөүигийн гэр өөрийнхөөс нь өөр санагдаж байв. “Чамд мөнхийн гэр бүл байдаг уу?” гэж Миа асуув.

Зөүи тоглоомоосоо толгойгоо өндийлгөн, инээмсэглэж, “Тийм! Манай аав, ээж хоёр ариун сүмд гэрлэсэн болохоор бид мөнхөд хамтдаа байж чадна” гэж хэлжээ.

“Тийм учраас танай гэр өөр санагддаг юм уу?” гэж Миа асуув.

Зөүи тээнэгэлзсэн байдалтайгаар “Өөр өө?” гэж асуув.

Миа Зөүигийн гэрт байдаг мэдрэмжийг юу гэж тайлбарлахаа мэдэхгүй байв. Энэ нь баяр хөөртэй, халуун дулаан мэдрэмж байлаа. Гэхдээ тэгж хэлэх гэхээр инээдтэй сонсогдохоор байв. “Зүгээр ээ.” “Үргэлжлүүлээд тоглоё” гэж тэр хэлэв.

Тэр орой Миа Зөүигийн мөнхийн гэр бүлийн талаар бодохгүй байж чадсангүй. Тэр Зөүигийн гэр бүлд байдаг мэдрэмжинд маш дуртай байв. Миагийн гэр бүл цөөн хэдэн өдрийн дараа Канадын Онтарио руу нүүх гэж байв. Тэр шинэ гэр нь ямар мэдрэмж төрүүлэх бол гэж бодож байлаа.

“Ээж ээ, Зөүигийн гэр маш баяр хөөртэй санагдах юм” гэж Миа өөрийг нь хөнжлөөр хучих үед ээждээ хэлэв. “Манай шинэ гэр тийм мэдрэмж төрүүлээсэй гэж би хүсэж байна.” Миа аав, ээж, дүү нартаа хэчнээн их хайртайгаа бодлоо. “Би бас гэр бүлээ мөнхийнх байгаасай гэж хүсэж байна.”

Ээж нь түүнийг чимээгүйхэн сонсож байв. Тэгэхэд ээж нь “Би ч бас” гэж хэлэв.

Маргааш нь ээж нь Зөүигийн ээж рүү утасджээ. Тэр Зөүигийн гэр бүл Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд явдгийг олж мэдэв.

Аав, ээж хоёрыгоо юм баглаж байх хооронд Миа тэдэнд “Би тэр сүм рүү явмаар байна” гэж хэлжээ. Тэдний байшин бараг хоосон болсон байв.

Аав нь нэг хайрцгийг скоцдож байхдаа “Зөүигийн ээж бидэнд Сүмийн байр олоход тусална” гэж хэлсэн гэв.

Миа инээмсэглэсэн ба чээж нь халуу оргив. Тэдний шинэ гэр Зөүигийн гэр шиг халуун дулаан, баяр хөөртэй байж магадгүй!

Миагийн гэр бүл шинэ гэртээ төвхнөөд, сүм рүү явж эхэлжээ. Тэнд хүмүүс нь маш найрсаг байв. Хүн бүр нэг нэгнээ “ах,” “эгч” гэж дуудаж байсан. Миа дүү нартайгаа Хүүхдийн хэсэгт явав. Тэр дуу дуулж, судруудаас унших дуртай байв.

Удалгүй хоёр залуухан эмэгтэй Миагийн гэрт хүрч иржээ. Тэд номлогчид байсан бөгөөд тэдний нэрийг Жастин эгч, Рамос эгч гэдэг. Тэд Миагийн гэр бүлийнхэнд Тэнгэрлэг Эцэг, Есүс болон Мормоны Номын талаар хэлж өгсөн. Миа сайн мэдээний талаар сонсох маш их дуртай байлаа. Эрэгтэй дүү нар нь хүртэл чимээгүй суугаад, сонссон гээч!

Миа, Рамос эгч, Жастин эгч хоёрт Зөүигийн гэрийн талаар ярьж өгөв. “Би Зөүигийн гэр бүлийн адил мөнхийн гэр бүлтэй байхыг хүсэж байна.”

Рамос эгч “Тэнгэрлэг Эцэг бид бүгдийг мөнхийн гэр бүлтэй байхыг хүсдэг, бас биднийг аз жаргалтай байхыг хүсдэг” хэмээн нүүр дүүрэн инээн хариулсан.

Удалгүй Миагийн гэр бүл баптисм хүртэхээр шийджээ.

Зөүигийн гэр бүлийнхэн Онтарио руу явж, тэдний баптисмд оролцсон юм. Жилийн дараа тэд дахин ирэв. Энэ удаа Миагийн гэр бүл ариун сүмд лацдан холбогдож байв.

Лацдан холболтын өдөр Миа цав цагаан хувцас өмсөөд, гэр бүлийнхэнтэйгээ ариун сүмийн гадаа зогсож байлаа. Тэд бүгдээрээ нүүр дүүрэн инээмсэглэж байсан. Миа халуун дулаан, амар амгаланг мэдэрч, баяртайгаар “Бид одоо мөнхийн гэр бүл болчихлоо” гэж хэлжээ.

Аав нь “Тийм ээ, бид мөнхийн гэр бүл” гэж хэлэв. ■
Зохиогч нь АНУ-ын Колорадоод амьдардаг.



Найз ба НОМЛОГЧ

Сайн уу?

Миний нэрийг Хуан
Баутиста гэдэг.
Би Аргентинаас
ирсэн.

Би сайн мэдээг
хуваалцсанаар
гэрлээ
гэрэлтүүлдэг.



Дотнын найзууд

Миний сайн найз Факундо бид хоёр бүр
таван настайгаасаа бие биенээ мэддэг.
Бид хоёр хөл бөмбөг тоглох дуртай.
Би түүнийг Сүмийн олон үйл
ажиллагаанд урьж байсан.





Факундогийн эхний асуулт

Нэг удаа Факундо бидэнтэй хамт оройн хоол идэж байхдаа “Танай гэр бүл яагаад дандаа залбирдаг юм бэ?” гэж асуусан. “Яагаад гэвэл Тэнгэрлэг Эцэг биднийг адисалдаг мөн энэ нь Түүнд талархлаа илэрхийлэх арга” гэж би хэлсэн юм. Тэр маш их гайхаж байв.



Гэр бүлийн үдэш

Манай дүү Бэнжамин баптисм хүртэхэд бэлэн болж байсан үед нэгэн гэр бүлийн үдэшт Факундо ирсэн. Факундо Сүнснийг мэдэрсэн бөгөөд би бас баптисм хүртэж болох уу гэж асуусан. Тэгэхэд манай аав Факундогийн аав, ээжтэй ярьсан юм.

Номлогчид Факундогийн гэр бүлийнхэнд заасан. Тэгээд Факундо болон түүний эгч Аугустин хоёр баптисм хүртсэн. Түүний аав, ээж сүмд ирдэг ч баптисм хараахан хүртээгүй байгаа.



Факундогийн хоёр дахь асуулт

Факундо манай ээжээс, би Бурханы талаар тан шиг их мэддэг болох болов уу? гэж асуусан. Ээж инээмсэглэн, хэрвээ судруудыг уншиж, залбирах юм бол бүр илүү ихийг ч сурч чадна гэж хэлсэн.

ЧИ ХЭРХЭН ГЭРЭЛТЭЖ БОЛОХ ВЭ?

- Найзыгаа Сүмийн үйл ажиллагаанд эсвэл гэр бүлийн үдэшт урь.
- Найрсаг байдал болон хайрын сайн үлгэр жишээг үзүүл.
- Тусламж үзүүлж, сүнслэг өдөөлт авахын төлөө залбир.



БИДЭНД ОД ИЛГЭЭНЭ ҮҮ!

“Гэр[лээ] тэдний өмнө тийнхүү гэрэлт[үүл]” (Матай 5:16) хэмээн Есүс биднээс хүссэн. Чи гэрлээ хэрхэн гэрэлтүүлж чадах вэ? Од хайчлаад, дээр нь өөрийнхөө түүхийг бичээрэй. Одныхоо зургийг эцэг эхийнхээ зөвшөөрлийн хамт э-мэйлээр liahona@ldschurch.org хаяг руу илгээхийг эцэг эхээсээ хүсээрэй.



“Надад Есүс Христийн талаар болон Түүний бидний Аврагч хийгээд Гэтэлгэгчийн үүргийн талаар итгэл, гэрчлэл бий”.

Ахлагч Гари И.Стивэнсон

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга

“A Gospel Perspective” (Хавай дахь Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт, 2017 оны 9-р сарын 19), devotional.byuh.edu.

Мормоны Номын уншлагын клуб

МОРМОНЫ НОМЫГ УНШИЖ, БИДЭНТЭЙ НЭГДЭЭРЭЙ!

Та ганцаараа, гэр бүлтэйгээ эсвэл найзтайгаа хамт уншиж болно. Тэгээд Мормоны Ном уншиж байгаа зургаа бидэнд илгээн, Мормоны Номоос өөрийн дуртай түүхийг эсвэл сурсан зүйлийнхээ талаар бидэнд хэлнэ үү. Та түүхээ бидэн рүү liahona.lds.org вэбсайтаар ("Submit an Article" дээр дарж) илгээнэ үү.

Энэ сарын судар:

Хиламан 5:12

“Санагтун, Бурханы Хүү, Христ болох, бидний Гэтэлгэгчийн хадан дээр та нар сууриа тавих ёстойг санагтун.”



Манай гэр бүл Мормоны Номыг уншиж байгаа. Заримдаа бид түүхүүдийг жүжигчлэн тоглодог. Энэ нь маш хөгжилтэй байдаг. Би өдөр бүр шинэ үг, шинэ зүйл сурч авдаг. Эдгээр зүйлийг хийх нь ариун ёслолын цуглаанд болон

Хүүхдийн хэсэгт анхаарлаа төвлөрүүлэхэд минь тусалдаг. Бас энэ нь намайг гэр бүлдээ ойр дотно байхад тусалдаг.

Амарон И, 7 настай, Камбож, Пномпен



Мормоны Номыг номлогчид бидэнд танилцуулснаас хойш би үүнийг унших маш их дуртай болсон. Миний дуртай түүх Мозагийн номонд Бэнжамин хаан өөрийн хүмүүсийг итгэлээрээ удирддаг хэсэгт байдаг. Би итгэлтэй байж бас аав

ээжийнхээ надаар хийлгэхээр хүссэн зүйлсэд дуулгавартай байхыг хүсэж байна.

Жанис С, 10 настай, Филиппин, Ллоло

БИДНИЙ ХУУДАС



"Анхны үзэгдэл," Алана Л., 7 настай, Бразил, Сао Пауло



Би Есүс Христийн үнэн Сүмд баптисм хүртсэндээ маш баяртай байна. Би Мормоны Ном үнэн гэдгийг мэднэ мөн энэ номноос өдөр бүр унших дуртай. Энэ нь намайг дүү нартаа илүү хариуцлагатай ах байхад тусалдаг.

Андрэй Л., 10 настай, Филиппин, Ллойло



Марко С., 9 настай, Перу, Лима



Харада К., 8 настай, Япон, Ёкохама

Рут үнэнч найз байсан

Наоми гэдэг нэртэй нэгэн эмэгтэй хоёр хүү болон тэднийхээ эхнэрүүдтэй хамт амьдардаг байв. Хоёр хүү нь хоёулаа нас барахад Наоми бэрүүддээ төрхөмдөө буцаж болно гэж хэлжээ. Гэвч бэрүүдийнх нь нэг болох Рут маш үнэнч байсан. Тэр үлдээд, Наомийг халамжлахад туслахаар шийджээ. Рут ойролцоох талбайгаас тариа цуглуулахаар явж гэнэ. Уг талбайн эзэн нь Рутийг ямар сайн хүн болохыг нь сонссон байв. Тэр Рутэд эелдэг хандаж байв. Рут түүнтэй гэрлэхээр шийдсэн. Рут, Наоми хоёр найзууд хэвээр үлдсэн бөгөөд Наоми Рутын хүүг халамжлахад тусалдаг байв. Олон жилийн дараа, Есүс энэ гэр бүлийн удмаас төрсөн билээ. Тэгэхээр Рут Есүсийн өвөг дээдсийн нэг байсан гэсэн үг!

Рут 1–4 дээрээс Рутийн талаар унш.



“Рут найрсаг бас хайрладаг нэгэн байсан,” Кайли К, 8 настай, АНУ, Виржини



РУТ

Рут үнэнч найз байхыг сонгосон бөгөөд би ч бас тэгж чадна!

- ☐ Рут 1:16-г чээжил.
- ☐ Үнэнч байна гэдэг нь хэцүү ч гэсэн хэн нэгнийг дэмжинэ гэсэн үг юм. Хэн нэгэн өөрт чинь үнэнч байсан цаг үеийн тухай өдрийн тэмдэглэлдээ бич.
- ☐ Энэ долоо хоногт шинэ найзтай бол. Тэдний тухай гурван хөгжилтэй зүйлийг мэдэж ав.
- ☐ Би ...-ээр сайн найз байж чадна

Ханна, Самуел хоёр

Ким Вэбб Рэйд

Ханна хүүхэдгүйдээ маш гунигтай байдаг байв. Тэр ариун сүмд залбирчээ. Хэрвээ хүүтэй болох юм бол хүүтээ Бурханд үйлчлүүлэхээр өсгөх болно гэж тэр амласан.



Ханна, түүний нөхөр хоёр хүүхэдтэй болжээ! Ханна түүнд Самуел гэж нэр өгөв. Бурхан өөрийнх нь залбиралд хариулсныг тэр мэдэж байв.



Самуелыг өсөх үед Ханна амлалтаа хадгалсан. Тэр ариун сүм дээрх прист болох Елигээс Бурханд хэрхэн үйлчлэхийг Самуелд заахыг гуйв. Ели Самуелыг халамжлан асрахад тусалсан.

Нэг орой Самуел орондоо байхдаа нэгэн дуу хоолойг сонсжээ. Тэр Елигээс өөрийг нь дуудсан эсэхийг асуув. Ели түүнд Бурхан Самуелтай ярихыг хичээж байгааг хэлсэн. Дараагийн удаа Самуел уг дуу хоолойг дуулаад, сонсов. Тэгээд Бурхан Самуелд хандан ярьсан. Самуел Бурханыг сонсож, Түүнийг дагажээ.





Би Бурханы талаар мэдэж авч, мөн Түүний зарлигуудыг дагаж чадна! ■

1 Самуел 1-3-аас.

Би бусадтай хуваалцаж чадна





Ерөнхийлөгч
Эзра Тафт Бэнсон
(1899–1994)

МОРМОНЫ НОМ ЭЛБЭГ ДЭЛБЭГИЙГ АВЧИРДАГ

*Таныг энэ номыг нягт няхуур судалж
эхлэх тэр мөчөөс эхлэн та нарын
амьдрал руу урсан орох хүч энэ
номонд агуулагддаг.*



Бурханд илүү ойртох, өдөр тутмын амьдралдаа Түүнтэй илүү адилхан болох, Түүнийг байнга дэргэдээ байгаа юм шиг мэдрэхийг хүсдэг нэгэн хүсэл бидний зүрх сэтгэлийн гүнд байдаггүй гэж үү? Хэрэв тийм аваас, Мормоны Ном өөр ямар ч номноос илүүтэйгээр бидэнд туслах болно.

Мормоны Ном бидэнд үнэхээр үнэнийг заадаг ч энэ нь үүнээс илүү ихийг заадаг. Мормоны Ном үнэхээр Христийн тухай гэрчилдэг ч энэ нь бүр илүү ихийг гэрчилдэг. Бас үүнээс ч илүү зүйл бий. Таныг энэ номыг нягт няхуур судалж эхлэх тэр мөчөөс эхлэн та нарын амьдрал руу урсан орох хүч энэ номонд агуулагддаг. Та нар уруу таталтыг сөрөн зогсох агуу хүчийг олох

болно. Та нар хууран мэхлэгдэхээс зайлсхийх хүчийг олно. Та нар давчуу бөгөөд нарийн зам дээр үлдэх хүчийг олно. Судруудыг “амьдралын үгс” (С ба Г 84:85-ыг үзнэ үү) гэж нэрлэдэг ба Мормоны Номын тухайд энэ нь хамгийн үнэн билээ. Та нар эдгээр үгийн араас өлсөж цангаж эхлэх үедээ өөрсдийн амьдралыг илүү элбэг хангалуун болохыг мэдрэх болно.

Гэр орон дахь өсөн нэмэгдсэн хайр, эв эе, эцэг эх, хүүхдүүдийн бие биеэ дээдлэн хүндлэх явдал, сүнслэг болон зөв шударга байдал нэмэгдэх зэрэг амлалтууд хоосон

амлалт биш бөгөөд харин Бурханд илүү ойртоход Мормоны Ном бидэнд туслах болно гэж бошиглогч Иосеф Смитийн хэлсэн тэр зүйлийн утга учир юм. . . .

Би 10 гаруй жилийн өмнө Мормоны Номын талаар дараах үгийг хэлж байсан.

“Бидний энэ номонд хэрхэн хандах нь мөнхийн үр дагавартай юу? Тийм ээ, нэг бол бидэнд адислал болж, эсвээс зүхэл болно.

Хожмын үеийн гэгээнтэн бүр энэ номыг насан туршдаа судлах ёстой. Эс бөгөөс тэрбээр сүнслэг байдал, оюун санааны эв нэгдлийг бүх амьдралд нь хангаж өгч чадах сүнсийг үл тоомсорлон үүнд хайхрамжгүй хандаж байгаа гэсэн үг юм. Мормоны Номоор дамжуулан Христийн хадан дээр итгэлээ төлөвшүүлж, төмөр бариулаас зууран барьж байгаа хөрвөгч, ингээгүй хүн хоёр ялгаатай.”

. . . Их Эзэнээс бидэнд өгсөн энэхүү гайхамшигтай, агуу бэлэгт хөнгөмсгөөр хандсанаар зүхлийг . . . өөрсөд дээрээ дуудахгүй байцгаая. Харин энэхүү бэлгийг зүрх сэтгэлдээ эрхэмлэн нандигнан хадгалж, үүнээс ирэх адислалуудыг хүртэцгээе. ■

“The Book of Mormon—Keystone of Our Religion,” Ensign, 1986 оны 11-р сар, 4–7-оос авав.



**БАРУУН ЗҮГ РҮҮ,
ДЭВИД МИКЛ**

1856-1860 оны хооронд Англи, Вэйлс, Шотланд болон Скандинаваас цагаачлан орж ирсэн 3000 хожмын үеийн гэгээнтнээс бүрдсэн гар тэрэгний 10 бүлэг Сион дахь бусад гэгээнтэнтэй нэгдэхээр 1300 миль (2090 км) газрыг алхаж туулсан юм. Эдгээр анхдагч өөрсдийн эзэмшдэг бүхнийг 1 метр өргөн, 1.5 метрийн урттай гар тэргэнд тавьж татаад, Америкийн тал хөндийнүүдийг гаталсан билээ.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

**ТУСГААРЛАГДСАН МЭТ
САНАГДАЖ БАЙНА УУ?**

*Бид анхаарлыг минь сарниулж
сатааруулсан, хүлээх ч завгүй цаг
үед амьдарч байна. Гэхдээ бид
Бурхантай үнэхээр холбогдохын
тулд хурдаа сааруулж,
хөдөлгөөнгүй байх хэрэгтэй.*

48

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД
ЗОРИУЛАВ

**ХЭЦҮҮ АСУУЛТТАЙ
ТУЛГАРААД БАЙНА
УУ? ТУСЛАМЖ
НЬ ЭНД БАЙНА.**

50

АРИУН ЁСЛОЛЫН
ЦУГЛААН

**ҮГ ХЭЛЭХЭД
ТУСЛАХ ДОЛООН
ЗҮЙЛ**

56

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

**МАНАЙ МОРМОНЫ
НОМЫН
УНШЛАГЫН КЛУБТ
НЭГДЭЭРЭЙ.**

73



ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

